



ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ



From
the People of Japan

G9198/9221-МОН:

Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг
гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл

ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ВИКТИМОЛОГИ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2023 он

Тайлан бэлтгэсэн:

Зөвлөх

Чойжилын Нямсүрэн (хууль зүйн ухааны доктор, профессор)

Судлаач

Шаравдоржийн Ариунбилэг (хууль зүйн ухааны доктор, дэд профессор)

Батбаярын Цогтбаатар (хууль зүйн ухааны доктор)

Батсайханы Эрдэнэбат (хууль зүйн ухааны доктор)

Ширчиний Номин-Эрдэнэ (Шинжлэн магадлахуйн ухааны доктор)

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГС.....	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	6
ТАЛАРХАЛ.....	8
ХУРААНГУЙ.....	9
ТАНИЛЦУУЛГА.....	13
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮҮХЭД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ВИКТИМОЛОГИЙН СУДАЛГААНЫ ОНОЛ АРГА ЗҮЙН ҮНДЭС	19
ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСАД ГЭР БҮЛИЙН ХҮРЭЭНД ХҮҮХЭД ЭМЭГТЭЙЧҮҮД ХОХИРОХ ЯВДАЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	30
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ЯВДАЛД ХҮҮХЭД ЭМЭГТЭЙЧҮҮД ХОХИРОХОД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ	58
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСАД ХҮҮХЭД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВИКТИМОЛОГИЙН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ.....	75
ТАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСАД ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРСОН ХОХИРОГЧИЙН ЗӨРЧСӨН ЭРХИЙГ НӨХӨН СЭРГЭЭХ НЬ	92
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХҮҮХЭД ЭМЭГТЭЙЧҮҮД ӨРТСӨН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ЭНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОЛОН УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ТУРШЛАГА	101
ДОЛООДУГААР БҮЛЭГ. ХҮҮХЭД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВИКТИМОЛОГИЙН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУЛГАМДСАН АСУУДАЛ, САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ.....	109
ДҮГНЭЛТ.....	118
САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	119
НОМ ЗҮЙ.....	121
ХАВСРАЛТ.....	129

ТОВЧИЛСОН ҮГС

АХБ	Азийн хөгжлийн банк
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард УЛс
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГМЯ	Гол мэдээлэгчийн ярилцлага
ГЯ	Ганцаарчилсан ярилцлага
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ФБЯ	Фокус бүлгийн ярилцлага
ОХУ	Оросын Холбооны Улс
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Чанарын судалгаанд оролцогчдын түүврийн хуваарилалт
- Хүснэгт 2. Орон нутаг, нийслэл, улсын хэмжээнд үйлдсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн судалгаа.
- Хүснэгт 3. Улаанбаатар хотод үйлдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт явдлын хөдөлгөөн
- Хүснэгт 4. Нийслэлийн дүүргүүдийн хүн амын нягтаршил, нутаг дэвсгэрийг гэр бүлийн хүчирхийлэлтэй харьцуулан судалсан байдал.
- Хүснэгт 5. Улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийг насны байдлаар харьцуулсан судалгаа
- Хүснэгт 6. Нийслэлийн дүүргүүдийн хүн амын нягтаршил, нутаг дэвсгэрийг гэр бүлийн хүчирхийлэлтэй харьцуулан судалсан байдал.
- Хүснэгт 7. Шүүхийн статистик мэдээллээс үзэхэд сүүлийн гурван жилд дараах нөхцөл байдал илэрч байна.
- Хүснэгт 8. Шүүхийн сүүлийн 3 жилийн судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын гэр бүлийн хамаарлыг харьцуулсан судалгаа.

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. *Виктимологийн ерөнхий онолын бүтцийг харуулав.*
- Зураг 2. *Улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд, эмэгтэйчүүдийг харьцуулсан судалгаа.*
- Зураг 3. *Нийслэлийн хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд, эмэгтэйчүүдийг харьцуулсан судалгаа.*
- Зураг 4. *Улаанбаатар хотод үйлдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт явдлын хөдөлгөөн.*
- Зураг 5. *Улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийг насны байдлаар харьцуулсан судалгаа*
- Зураг 6. *Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогчдын судалгаа.*
- Зураг 7. *Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогчдын судалгаа*
- Зураг 8. *Шүүхийн судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хүчирхийллийн хэлбэр, бүтцээр нь харьцуулсан судалгаа.*
- Зураг 9. *Шүүхийн судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн бие махбодын хүчирхийллийн хөдөлгөөнийг харьцуулсан байдал.*
- Зураг 10. *Шүүхийн судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн сэтгэл санааны болон бэлгийн хүчирхийллийн хөдөлгөөнийг харьцуулсан байдал.*
- Зураг 11. *Судалгаанд оролцогчдыг насны ангилал.*
- Зураг 12. *Судалгаанд оролцогчдыг ам бүлийн байдлаар харуулав.*
- Зураг 13. *Судалгаанд оролцогчдыг боловсролын түвшин харуулав.*
- Зураг 14. *Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан эсэх саналыг харуулав.*
- Зураг 15. *Иргэдээс гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан эсэхийг тодруулсан судалгаа.*
- Зураг 16. *Судалгаанд оролцогчдын гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг ямар байгууллага шийдвэрлэсэн талаар харьцуулсан судалгаа.*
- Зураг 17. *Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хамтарсан багийн урьдчилан сэргийлэх ажлын талаарх саналыг харуулав.*
- Зураг 18. *Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн шалтгаан нөхцөлийг илэрхийлсэн саналыг харуулав.*
- Зураг 19. *Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийн хэдэн хувь нь цагдаагийн байгууллагад хандсан эсэх талаарх саналыг харуулав.*
- Зураг 20. *Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсооход хамгийн түрүүнд хэнээс хамаарах эсэх талаарх саналыг харуулав.*

- Зураг 21. Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байгаа гол шалтгааны талаар илэрхийлсэн саналыг харуулав.
- Зураг 22. Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэр бүл салалтын байдлын талаар илэрхийлсэн саналыг харуулав.
- Зураг 23. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрсэн хохирогчийг гэр бүлийн хамаарлаар харьцуулсан судалгаа.
- Зураг 24. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдийг хамаарлаар нь харьцуулсан байдал.
- Зураг 25. Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагын сүүлийн 3 жилийн тайлан мэдээнд хийсэн судалгаа.
- Зураг 26. Нийт хандалтыг харьцуулсан байдал.
- Зураг 27. Иргэдийн сэтгэгдлийг харуулсан байдал.
- Зураг 28. Судалгаанд оролцсон иргэдээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байгаа гол шалтгааны талаар илэрхийлсэн саналыг харуулав.
- Зураг 29. Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ч хууль сахиулах байгууллагад хандаагүй шалтгаан нөхцөлийг илэрхийлсэн саналыг харуулав.
- Зураг 30. Монгол Улсад бүртгэсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт, гэрлэлтээ цуцлуулсан байдлыг харьцуулсан судалгаа.
- Зураг 31. Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийллийн хор аюулын шинжийг илэрхийлсэн төсөөлөл.
- Зураг 32. Гэр бүлийн хүчирхийлэл үргэлжилсэн хугацааг харуулсан график.
- Зураг 33. Гэр бүлийн хүчирхийллийн давтамжийг харуулсан график.
- Зураг 34. Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдалтай тэмцэх, “шүгэл үлээх”- эд учирч болох эрсдэлийн талаар иргэд дараах үзэл бодолтой байна.
- Зураг 35. Судалгаанд оролцогчдын гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийн талаарх гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн үзэл бодол.
- Зураг 36. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох ажлын үр дүн ямар байгууллагаас хамаарах талаар иргэдийн саналыг харуулав.

ТАЛАРХАЛ

Азийн Хөгжлийн Банк (АХБ) нь Ази, Номхон далайн бүс нутагт нэн ядуурлыг арилгах, хүртээмжтэй, тогтвортой, эрсдэлийг даван туулах чадвартай хөгжлийг бүс нутагт цогцлоохын төлөө тууштай ажиллаж, “2030 он хүртэлх Стратегийн үндсэн зорилтуудын нэг болох жендерийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгахад чиглэсэн” төслүүдийг бүс нутгуудад амжилттай хэрэгжүүлж байна.

Монгол Улсад АХБ-ны дэмжлэгтэй хэрэгжиж буй хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл нь цар тахлын дараах үед гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, цахим шийдлийг нэвтрүүлэх, орон нутгийн санаачилгыг дэмжих, анхан шатны нэгжийн үйлчилгээ үзүүлэгчдийг чадавхжуулах, гэр бүлийн хүчирхийллийн яаралтай тусламжийн утасны үйлчилгээнд хиймэл оюун ухаанд суурилсан систем нэвтрүүлэх замаар иргэдэд эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх, хамтарсан багийн үйлчилгээнд холбон зуучлах мэдээллийн тогтолцоог бий болгох зэрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд үр дүнтэй ажил, арга хэмжээг санхүүжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсад хэрэгжүүлж байгаа эрх зүйн шинэтгэлийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлан, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх үйлдлийг зөрчил, гэмт хэрэгт тооцон хуульчилж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цогц хууль тогтоомжийг мөрдөж, багагүй хугацаа өнгөрч байна. Эрдэмтэн судлаачдын дунд тухайн төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, зөрчил, эрүүгийн эрх зүйн зохицуулалт, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагаанд тулгамдсан асуудал, хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх асуудлын талаарх судалгаа шинжилгээний ажил цөөнгүй хийжээ. Энэ судалгаа нь G9198/9221-МОН: Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд Монгол Улсад анх удаа хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлыг виктимологийн үүднээс судалсан бүтээл юм. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн виктимологи судалгааг санхүүжүүлэн, анхан шатны судалгааны тайлан гаргахад дэмжлэг үзүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк, Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы санд гүн талархал илэрхийлье.

Дэлхийн нийтийн хэмжээнд тулгамдсан асуудал болж буй гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр гүйцэтгэсэн судалгааны ажилд шаардагдсан тоо баримт, мэдээллийг гарган өгч, гүн туслалцаа үзүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид, мөн судалгааны ажлын хүрээнд бидэнтэй цаг гарган ярилцаж, өөрсдийн мэдлэг, туршлагаа хуваалцсан төрийн, тэр дундаа хууль сахиулах байгууллагын албан хаагчид, өмгөөлөгчид, хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагын төлөөллүүд, судалгааны байгууллагууд, болон салбарын мэргэжилтнүүд зэрэг олон талын оролцогч талуудад болон судалгаанд шаардлагатай чухал мэдээллийг бидний хүсэлтээр ирүүлсэн Үндэсний статистикийн хороо, Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн газар, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хамт олонд тусгайлан талархлаа илэрхийлж

байна. Мөн бүлгийг боловсруулахад идэвх санаачилга гарган ажилласан судалгааны багийн гишүүддээ талархал илэрхийлье.

Судалгааны багийн зөвлөх

ХУРААНГУЙ

Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын виктимологийн судалгааны ажлын зорилго нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх стратеги, арга зүй, төлөвлөлтийг сайжруулах замаар гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, гэр бүлийн хүчирхийллийн болзошгүй хохирогчийг урьдчилан илрүүлэх, судалгааны дүнд түшиглэн хохирогч төвтэй үйлчилгээг сайжруулахад чиглэсэн.

Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэргийн виктимологийн судалгааны онол арга зүйн үндэс нэгдүгээр бүлэг нь 2 дэд бүлэгтэй. Хүүхэд эмэгтэйчүүдийн эрсэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын виктимологийн судалгааны онолын үндэс дэд бүлэгт Виктимологийн шинжлэх ухааны ойлголт, орчин үеийн хандлага, виктимологийн мэдлэгийн бүтэц, Монгол Улсад хийгдсэн гэмт хэргийн виктимологийн талраах судалгааны тойм, Хүүхэд эмэгтэйчүүдийн эрсэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын виктимологийн судалгааны арга зүйн үндэс дэд бүлэгт хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын виктимологи судалгааны судлах зүйлийн объектыг тодорхойлох, хохирогч; хохирох эрсдэл, боломж (victim precipitation); хохирох явдал (victimization); хор аюул дагуулсан үйл явдал, зан үйл ба хохирогчийн хоорондох холбооны талаарх ойлголт, виктимизацийн үзүүлэлтүүд, тэдний ойлголт, тодорхойлолт, нэр томъёог нутагшуулах, нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар авч үзсэн. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын виктимологийн судалгааны эрх зүйн үндэс дэд бүлэгт хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн Олон улс дахь болон Монгол улс дахь эрх зүйн зохицуулалтыг судалсан.

Монгол улсад гэр бүлийн хүрээнд хүүхэд эмэгтэйчүүд хохирох явдал, өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ хоёрдугаар бүлэг 4 дэд бүлэгтэй. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн тоон судалгаа дэд бүлэгт цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал статистик судалгааны сүүлийн 6 жил¹-ийн тоон мэдээлэл, шүүхийн сүүлийн 3 жилийн гэр бүлийн хүчирхийллийн тоон мэдээлэлд үндэслэн виктимологийн үндсэн ойлголтыг тодорхойлох, гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, чиг хандлагыг тодорхойлох судалгааг хийсэн. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогчийн гэр бүл дэх харилцан хамаарал дэд бүлэгт хохирогчийн гэр бүлийн хамаарлыг хүүхэд, эмэгтэйчүүдээр ялган, онцлогийг судалж, шалтгааныг тодорхойлох судалгааг хийсэн. Хүүхдийг үл хайхрах хүчирхийллийн судалгаа дэд бүлэгт үл хайхрах хүчирхийллийн ойлголт, төрлийг тодорхойлж, хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээний төвд ирсэн дуудлага мэдээлэлд судалгаа хийсэн. Контент анализ судалгааны үр дүн дэд бүлэгт цахим орчинд гэр бүл, хүүхэд хүчирхийллийн гэмт хэргийн гаралт, түүний шалтгаан нөхцөлийн талаар гарсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх зорилгоор түүврийн аргаар сонголт хийсэн 58 сайтын 44 нийтлэл, 17 сурвалжилга, 16 ярилцлага, мөн эдгээр мэдээлэлд хандсан 143854 сэтгэгдлийг контент анализын аргаар боловсруулж, үүнээс сонгон авсан нийт 80 мэдээллийн, түүврийн аргаар судалбал зохих дүн сэтгэгдэлд шинжилгээ хийсэн.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдалд хүүхэд эмэгтэйчүүд хохироход нөлөөлж буй хүчин зүйл гуравдугаар бүлэг 3 дэд бүлэгтэй. Хохироход нөлөөлж буй

¹ Эрүүгийн хууль шинэчлэн найруулагдсанаас хойших үеэр судалгааны цар хүрээг тогтоосон болно

объектив хүчин зүйл, шалтгаан нөхцөл дэд бүлэгт нийгэм, эдийн засаг, хүн ам зүй, соёл, уламжлал, хот байгууламж, орон сууцны архитектур ба гэмт явдал нь гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан болох судалгааг явуулсан. Хохироход нөлөөлж байгаа субъектив хүчин зүйл дэд бүлэгт хувь хүний зан үйл дэх эрсдэлийн хүчин зүйлүүд, хохирогчийн өдөөн хатгасан зан үйл, хохирогчийн болгоомжгүй зан үйл, архи, согтууруулах ундааны хэрэглээ, зан суртахуун-сэтгэл зүйн онцлог зэргийг судалж, хохироход нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлсон. Хохирогчийн сэтгэл зүйн онцлог дэд бүлэгт хохирогчийн профиль, түүний хувийн шинж чанар, виктим зан үйлийн онцлогийг тодорхойлох судалгааг хийсэн.

Монгол Улсад хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх виктимологийн ажил, арга хэмжээ дөрөвдүгээр бүлэг дэд бүлэгтэй. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх виктимологийн нийтлэг ажил, арга хэмжээ дэд бүлэгт виктимологийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний ойлголт, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх криминологийн нийтлэг ажил, арга хэмжээний талаар судалсан. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх виктимологийн тусгай ажил, арга хэмжээ дэд бүлэгт төрийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийллээс урьдчилсан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ, түүний эрх зүйн үндсийг судалсан.

Монгол Улсад хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хохирсон хохирогчийн зөрчсөн эрхийг нөхөн сэргээх нь тавдугаар бүлэг 3 дэд бүлэгтэй. Гэмт хэрэгт хохирсон иргэдийн аюулгүй байдлыг хангах дэд бүлэгт Хохирогчийн аюулгүй байдлыг хангах, дахин хохирох явдлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах эрх зүйн зохицуулалт, хамгаалалтын арга хэмжээний талаар судалсан. Хохирогчдын эмнэлэг, нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг дэд бүлэгт хүчирхийллийн улмаас хүүхэд эмэгтэйчүүд нийгэм, эдийн засгийн амьдралд оролцох эрхийг сэргээн эдлүүлэх эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудлыг судалсан. Зөрчсөн эрхийг нөхөн сэргээх асуудал дэд бүлэгт Зөрчигдсэн эрхийг сэргээх асуудлыг олон улсад болон Монгол улсад хэрхэн зохицуулсан, өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг судалсан.

Хүүхэд эмэгтэйчүүд өртсөн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрхийг хамгаалах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын болон гадаадын зарим улс орны туршлага зургаа дугаар бүлэг 2 дэд бүлэгтэй. Олон улсын эрх зүйн хэмжээ дэд бүлэгт гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх эрх зүйн баримт бичиг, сайн туршлага, ололттой зохицуулалтыг судалсан. Гадаад улс орнуудын сайн туршлага дэд бүлэгт гадаад улсуудад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа криминологийн практикийг Ирланд, Непал, Япон, Бразил, Казакстан, АНУ, Турк, Их Британи, Финлянд, Австри, Швец, Шинэ Зеланд, Мексик, Никарагуа, Кипр, ӨАБНУ, Испан, ОХУ-ын жишгийг судалсан.

Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх виктимологийн ажил, арга хэмжээний тулгамдсан асуудал, сайжруулах арга зам долоо дугаар бүлэгт дэд бүлэгтэй. Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал дэд бүлэгт гэр бүлийн харилцааг зохицуулж байгаа үндэсний хууль тогтоомжид судалгаа хийж, онцлог зохицуулалтыг судалсан. Хүүхэд эмэгтэйчүүдийн эрхийг хангах хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах нь дэд бүлэгт Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд үзүүлэх үйлчилгээ, тусламж, дэмжлэг үзүүлэх байгууллагын эрх зүйн зохицуулалтын онцлогийг тус тус судалсан болно.

ТАНИЛЦУУЛГА

Судалгааны ажлын үндэслэл. Монгол Улсад 2017-2022 онд гэмт хэргийн улмаас нийт 184.785 хүн хохирсноос гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт 7046 хүн хохирсон байна. Үүнээс 6322 нь буюу 90.05 хувь нь эмэгтэй, 540 буюу 8.76 хувь нь хүүхэд байгаагаас үзэхэд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын дийлэнх хувийг хүүхэд, эмэгтэйчүүд эзэлж байна.

2022 онд энэ төрлийн гэмт хэрэг хохирсон эмэгтэйчүүдийн хамгийн өндөр буюу 3595 нь 25-39 насны эмэгтэйчүүд байна. Харин хохирогч хүүхдүүдийн хувьд 58 нь 7 хүртэлх насны, 197 нь 8-13 насны, 213 нь 14-17 насны хүүхдүүд байна. Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 онд нийт 1729 бүртгэсэн нь өмнөх оны мөн үеэс 198 буюу 12.9 хувиар, нийслэлийн хэмжээнд 882 бүртгэсэн 30 буюу 3.5 хувиар, орон нутгийн хэмжээнд 847 бүртгэсэн нь 168 буюу 24.7 хувиар тус тус өссөн байна. Цагдаагийн байгууллагад 2022 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 10094 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 568 буюу 6.0 хувиар, 8593 зөрчлийг шийдвэрлэсэн нь 1353 буюу 18.7 хувиар тус тус өссөн байна. Гэмт хэргийн улмаас 1664 иргэн, үүнээс 1468 буюу 88.2 эмэгтэй, 177 буюу 10.6 хувь нь хүүхэд хохирч, 1432 хүн гэмтэж, 28 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй хохирсон хүн 175 буюу 11.7 хувиар, гэмтсэн хүн 204 буюу 16.6 хувиар, нас барсан хүн 14 буюу 2.0 дахин хувиар тус тус өсөж, энэ гэмт хэргийн улмаас 1915.1 сая төгрөгийн хохирол учирсан байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор эхнэр 769, хамтран амьдрагч 389, нөхөр 101, төрсөн хүүхэд 89, дагавар хүүхэд 41, төрсөн эцэг, эх 36, төрсөн ах, эгч 18, төрсөн дүү 18, хадам эцэг, эх 14, бусад 189 хүн байна.

Хамтрагчтай байсан болон одоо хамтрагчтай байгаа эмэгтэйчүүдийн 57.9% нь бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийлэл, хянах зан үйл зэрэг хүчирхийллийн хэлбэрүүдээс аль нэгд нь юм уу эсвэл хэд хэдэн хэлбэрийн хүчирхийлэлд өртсөөр байна.

Цагдаагийн байгууллагад 2022 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 10094 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 568 буюу 6.0 хувиар, 8593 зөрчлийг шийдвэрлэсэн нь 1353 буюу 18.7 хувиар тус тус өссөн байна.

2023 оны эхний улирал буюу нэг, хоёр, гуравдугаар сард 10167 хэрэг бүртгэсэн бөгөөд Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэргийн 394 буюу 91.8 хувийг хөнгөн, 35 буюу 8.2 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 26.6, хүнд гэмт хэрэг 23.9 хувиар тус тус буурсан дүнтэй байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх нийт гэмт хэргийн 51.8 хувь нь Улаанбаатар хотод, 48.2 хувь нь хөдөө орон нутагт үйлдсэн бөгөөд 201 буюу 46.9 хувь нь согтуугаар, 33 буюу 7.7 хувь нь эмэгтэй хүн оролцож үйлдэгджээ. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 403 иргэн хохирсон бөгөөд 353 нь эмэгтэй /87.5 хувь/, 38 буюу 12.5 хувь нь хүүхэд байна. Нийт үйлдсэн гэмт хэргийн улмаас 396.5 сая төгрөгийн хохирол учирчээ.

Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэл нь ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн хамгийн ноцтой зөрчилд тооцогдоно. Иймд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, уг гэмт явдалд хохироход нөлөөлж буй хүчин зүйл, шалтгаан нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажлууд хийгдэж байгаа хэдий ч гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, хохирогчид

шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх цогц стратеги, төлөвлөлт шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд нийгмийг цочирдуулсан хэргүүд гарч, гэр бүл дэх хүчирхийлэлд өртөгсдийн тоо нэмэгдсээр байгаа, Монгол Улсад гэр бүл, жендерт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой хууль, бодлогын баримт бичиг хангалтгүй хэрэгждэг, хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо боловсронгуй бус, хохирогчдод гэм хор, сэтгэл санаа, хууль эрх зүй, нийгмийн хамгааллын зөвлөгөө өгч байгаа байдал хангалтгүй байгаа зэрэг нь гэр бүл дэх хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг хууль сахиулах бүх түвшинд эрчимжүүлэх нийгмийн хэрэгцээ, шаардлага илүү их байгааг харуулж байна.

Гэр бүл хүчирхийллийн гол шалтгааныг хуулийн зохицуулалт оновчтой бус, тухайн харилцааг зохицуулж буй хуулиудын уялдаа холбоо алдагдсан өөрөөр хэлбэл хуулийн хийдэл, алдаа бий болсон, байгууллагуудын эрх хэмжээ, оролцоо ерөнхий, салангид байдлаар хуульчилсан, хохирогч, гэр бүлийн гишүүдийн иргэний эрхийг хамгаалах процедур хангалттай бус байгаатай холбоотой байна.

Виктимологийн суурь судалгааны үр дүнд үндэслэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, түүний онцлог, хэрэгцээ, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн хянан шийдвэрлэхэд хохирогч төвтэй аргачлалыг хөгжүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн үр дагавар, шалтгаан, нөхцөл, хүчин зүйл, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх виктимологийн арга замыг тодорхойлох хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх НҮБ-ын удирдах газар, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс 2010 онд “Гэмт хэрэгт хохирох явдлын талаар шинжлэн судлах Удирдамж” (Manual on Victimization surveys) батлан гаргасан нь улс орнуудад гэмт хэрэгт хохирох явдал, эрсдэлийг судлах, судалгааны үр дүнг гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсронгуй болгоход чухал хувь нэмэр оруулж байна. Энэхүү удирдамж нь гэмт хэрэг хохирох явдлыг судлах, шинжилгээ хийх арга зүйн зарчмуудыг олон улсын хэмжээнд нэгдмэл байдлаар боловсруулах анхны баримт бичиг төдийгүй, хохирох эрсдэлийг үндэсний түвшинд судлах, ялангуяа тухайн судалгааг анх удаа хийж байгаа улс оронд чухал ач холбогдолтой юм гэж тус баримт бичигт дурджээ.

Гэмт хэргийн виктимологийн шинжлэх ухаан шинэ тутам хөгжиж байгаа өнөө үед гэмт хэрэгт хохирох явдал, гэмт хэрэгт хохирох эрсдэл, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, учир шалтгаан, хохирогч-этгээд (хувь хүн, байгууллага, төр, нийгэм), гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх арга замыг, ажлыг виктимологийн шинжлэх ухааны үүднээс шинээр тодорхойлж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх нийгэм-улс төр, эрх зүйн хэрэгцээ шаардлага тулгамдаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банктэй хамтран Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжаар “G9198/9221-МОН: Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийг 2019 оноос амжилттай хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн виктимологи судалгаа”-г судалгааны дэд багийн ахлагч, ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор, криминологийн багийн ахлагч Б.Эрдэнэбатын удирдлагаар судлаач Ш.Ариунбилэг (ДХИС-ийн Эрх зүй

нийгмийн ухааны сургуулийн захирал, хууль зүйн доктор, дэд профессор. Хуульч-виктимологич) судлаач Б.Цогтбаатар (ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор-сэтгэл зүйч), судлаач Ш.Номин-Эрдэнэ (ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн ахлах багш. Шинжлэн магадлахуйн доктор-сэтгэл зүйч) нар гүйцэтгэж байна. Судалгааны ерөнхий зөвлөхөөр хууль зүйн доктор, профессор Ч.Нямсүрэн ажиллаж байна.

Судалгааны ажлын зорилго, зорилт. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын виктимологийн судалгааны ажлын зорилго нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх стратеги, арга зүй, төлөвлөлтийг сайжруулах замаар гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, гэр бүлийн хүчирхийллийн болзошгүй хохирогчийг урьдчилан илрүүлэх, судалгааны дүнд түшиглэн хохирогч төвтэй үйлчилгээг сайжруулахад оршино.

Судалгааны үр дүнд хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр, нөлөөлж буй шалтгаан, нөхцөл, хүчин зүйл, үр дагаврын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлнэ. Судалгааны үр дүнд үндэслэн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй, төлөвлөлтийг сайжруулна.

Судалгаа нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн гаралт, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг эсрэг энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх криминологийн арга хэмжээг боловсруулахад оршино. Энэ зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Судалгааны ажлын төлөвлөгөө, аргачлалыг боловсруулж, мэдээлэл цуглуулах, судалгааны оролцогчтой ярилцах, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой хэрхэн харилцах талаар нарийвчилсан арга аргачлал, төлөвлөгөөг боловсруулна. Судалгааны аргачлалд гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлыг нас, хүйсээр ангилсан мэдээлэл цуглуулах ажлыг тусгана;

2. Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлөөс гадна эмзэг байдлын судалгаа буюу гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхэд хүргэж буй нийгэм, эдийн засаг, хүн ам зүй байдал болон гэмт хэрэг гарах бусад хүчин зүйлсийг тодорхойлох;

3. Виктимологи судалгааны үр дүнг холбогдох оролцогч талууд, төслийн гүйцэтгэгч, хэрэгжүүлэгч байгууллага, төсөл хэрэгжүүлэх нэгж, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулах, үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр танилцуулах, олон нийтэд түгээх, судалгааны эргэлтэд оруулах;

4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Хүүхэд хамгааллын тухай зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах.

Урьдчилсан судалгаа хийгдсэн байдал. Дотоод хэргийн их сургуулийн эрдэмтэн судлаачдаас “Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа, УБ, 2015”; “БНСУ-ын Сөүл хотноо оршин суугч Монгол иргэдийн гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа, Сөүл, 2016”; “Улаанбаатар хотод оршин суугч иргэдийн гэмт хэргээс айх айдас: Нэгдмэл загварын шинжилгээ, Сөүл, 2016; “БНСУ-ын Сөүл хотноо оршин суугч гадаад иргэдийн гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа”, Сөүл, 2018 зэрэг судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Мөн 2008 онд Нээлттэй нийгэм форум, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захиалгаар “Гэмт хэргийн хохирогчийн эрхийн хамгаалалт” суурь судалгаа, НҮБ-ын

Хөгжлийн хөтөлбөр, ХЗДХЯ-ны захиалгаар хийсэн “Гэрч хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал” судалгаа 2018-2021 онд цувралаар хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан байна.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв: “Монгол улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба хууль эрх зүйн орчин” Уб.,2002; “Гэр бүл дэх хүчирхийлэл (Баримтат мэдээлэл)” Уб.,2021; “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа” Уб.,2021; НҮБ-ын Хүн амын сан. “Хүчирхийллийн нүцгэн үнэн: жендерт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан-2017” Уб., 2018; Монголын криминологчдын холбоо. Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх нь” Уб.,2020 болон бусад судалгааны ажил хийгдсэн байна.

Гэмт хэргийн виктимологийн шинжлэх ухаан өнгөрсөн зууны 90-ээд оноос эхлэн хоёр зууны уулзварт хөгжиж буй залуу шинжлэх ухааны хувьд эрүүгийн, криминологийн, криминалистикийн шинжлэх ухааны уулзварт оршиж байгаа, салбар дундын шинжтэй төдийгүй, гэмт хэрэг, гэмт явдлын төрлийн шинжээр тусгай онол шинж чанарыг илэрхийлэх онцлогтой байна.

Энэ судалгаа нь эмэгтэйчүүд хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын гаралт, энэ гэмт хэрэгт өртөхөд нөлөөлж буй объектив, субъектив хүчин зүйл, шалтгаан нөхцөл, мөн гэмт хэрэгтэй, хохирогчийн дүр төрхийг (профайлин) судлахын хамт уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх криминологи, виктимологийн ажил, арга хэмжээг өөр хоорондын уялдаа холбоотойгоор судалж, дүгнэлт хийж, арга замыг тодорхойлох иж бүрэн ажил болох юм.


СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Бэлтгэл ажил:

- Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд захиалагчтай гэрээ хийж, Хуульч, сэтгэл зүйч, виктимологч мэргэжилтнүүд, ажилтнууд оролцсон ажлын хэсэг байгуулагдсан.
- Судалгааг гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, удирдамж гарган хэлэлцэж, хийх ажлын талаар уулзалт зохион байгуулж ажилласан.
- Судалгааны баг судлаачийн ёс зүй дүрмийг хатуу баримталсан болно. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, хохирогч хүүхэд, эмэгтэйчүүд, тэдний сэтгэцийн болон эрүүл мэндийн эмзэг байдлыг хөндөхгүйгээр хууль тогтоомж ёс зүйг баримтлан ажилласан болно.

Төслийн суурь судалгаанд чанартай мэдээлэл цуглуулах зорилгоор анхдагч болон хоёрдогч судалгааны аргыг хослуулан ашиглалаа. Анхдагч мэдээллийг цуглуулахад түүвэр судалгаа, ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлага болон ажиглалтын судалгааг хийж гүйцэтгэсэн. Хоёрдогч мэдээллийг цахим сүлжээн дэх олон нийтийн санаа бодол, баримт бичгийн судалгааны хүрээнд хийж гүйцэтгэсэн.

Зураг 1. Судалгааны төрөл, арга зүйг харуулсан зураглал.



Судалгааны ажилд хууль зүйн шинжлэх ухааны арга зүйд тулгуурлан онолын, тоон ба чанарын аргаар судалгааг явуулсан болно. Судалгааг зохион байгуулахдаа олон улсад түгээмэл ашигладаг КАП (KNOWLEDGE, ATTITUDE AND PRACTICE) – МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ТУРШЛАГА АРГАЗҮЙГ үндэслэв. Энэхүү арга нь тодорхой сэдвийн талаарх зорилтот бүлгийн хүмүүсийн юу мэдэж байгааг (Мэдлэг - Knowledge), юу бодож байгааг (Хандлага - Attitude) болон юу хийдэг болохыг (Туршлага - Practice) стандарт хэлбэр, бүтцийн дагуу боловсруулсан тоон болон чанарын асуултуудаар тодорхойлно¹.

Онолын судалгаа. Гэмт хэргийн виктимологийн, түүний дотор хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын виктимологийн судалгааны ойлголт, тодорхойлолт, нэр томъёог нэг мөр ойлгож зөв хэрэглэх, судалгааны арга зүйг нарийвчлан тодорхойлохын тулд криминологи, виктимологийн онол, арга зүйн бүтээлүүдийг судалсан болно.

Тоон судалгаа. *Статистик-математикийн арга:* Энэ аргын хүрээнд 2017-2022 оны цагдаагийн, прокурорын байгууллага, шүүхийн статистик мэдээ, мэдээлэлд тулгуурлан гэмт хэргийн хохирогч, түүний хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд эмэгтэйчүүдийн судалгааг нарийвчлан авч үзсэн болно.

Санал асуулгыг түүвэр сонголтоор нийслэл хотын 7 дүүргийн хүрээнд 1000 иргэдээс (респондент) авсан болно. Мэдээлэл цуглуулалтад компьютер ашиглан ярилцлага авах (CAPI) аргыг хэрэглэсэн. Судалгааны мэдээлэл цуглуулалтын CSPro 6.3 (тооллого, түүвэр судалгааны мэдээлэл боловсруулах систем) программыг ашигласан болно.

Чанарын судалгаа. *Ярилцлагын хүрээнд* ганцаарчилсан болон (фокус) бүлгийн ярилцлагыг тодорхой тулгамдаж буй асуудлын хүрээнд тусгайлан сонгож авсан өдөөх асуултаар хуульч, иргэд, гэмт хэргийн хохирогч, энэ төрлийн гэмт хэрэг зөрчил үйлдсэн этгээд зэрэг респондентийг түүвэр сонголтын аргаар хийсэн болно.

Контент анализын хүрээнд баримт бичгийн судалгаа, шүүхийн шийдвэр, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хавтаст хэрэг, урд өмнө хийгдэж байсан

¹ ДЭМБ, КАП аргачлалын үндэс, https://www.who.int/cholera/vaccines/КАП_protocol.pdf

судалгааны материал, тайлан мэдээнд дүн шинжилгээ хийж, нөгөө талаас энэ аргын хүрээнд цахим орчинд олон нийтийн санаа бодлыг тусгайлан судалсан болно.

Энэхүү судалгаанд ганцаарчилсан ярилцлага (ГЯ), фокус бүлгийн ярилцлага (ФБЯ), гол мэдээлэгчийн ярилцлага (ГМЯ), ажиглалт, кейсын судалгаа зэрэг чанарын болон тоон судалгааны холимог арга хэрэгслийг ихэвчлэн ашигласан.

Хүснэгт 1. Чанарын судалгаанд оролцогчдын түүврийн хуваарилалт

№	Төрөл	Оролцогчийн тоо	Зөвлөгөө өгсөн
Ганцаарчилсан ярилцлагын оролцогчид			
1	Мөрдөгч	12	-
2	Өмгөөлөгч	5	-
3	Хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч	15	25
4	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч	31	31
Нийт		63	56
Фокус бүлгийн ярилцлага			
1	Хууль зүйн их дээд сургуулийн багш нарын төлөөлөл	8	-
2	Цагдаагийн байгууллагын ажилтны төлөөлөл	12	-
3	Төрийн ба төрийн бус байгууллагын төлөөлөл	10	-
4	Иргэдийн төлөөлөл	18	18
5	Багш сурган хүмүүжүүлэгчийн төлөөлөл	8	8
Нийт		56	26

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ХҮҮХЭД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ВИКТИМОЛОГИЙН СУДАЛГААНЫ ОНОЛ АРГА ЗҮЙН ҮНДЭС

1.1. Хүүхэд эмэгтэйчүүдийн эрсэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын виктимологийн судалгааны онолын үндэс.

Хүүхэд эмэгтэйчүүдийн эрсэг гэмт явдлын виктимологийн судалгаа Монгол Улсад гэмт хэргийн виктимологийн тусгай онолын хүрээнд анх удаа хийж байгаа суурь шинжтэй судалгаа учраас түүний онол, арга зүйн үндсийг тодорхойлох нь судалгааны ажлын үндсэн чиг баримжааг тогтоох үндэс болно гэж судалгааны баг үзсэн.

Гэмт хэргийн виктимологийн шинжлэх ухаан нь XX зууны дунд үеэс АНУ, Герман, Финлянд, Япон, Канад, Швейцарт эрчимтэй хөгжиж эхэлсэн. 1970-аад онд виктимологийн асуудлууд нь дорнод европын улс орнууд, түүний дотор, ЗХУ-д судлагдах үндэс тавигдсан байна. Өнөөгийн байдлаар Япон улсад виктимологийн асуудлуудыг судлах тусгай институт, АНУ-д виктимологийн клиник, алба байгуулагдан ажиллаж байна.

Виктимологийн асуудлаар 1973 оноос эхлэн олон улсын бага хурал, зөвлөгөөн, ярилцлага зохиогдох болсон бөгөөд 1979 онд Мюнстер хотод болсон III симпозиумын үед НҮБ-ын ивээл дор Дэлхийн виктимологийн нийгэмлэг (World Society of Victimology) байгуулагдсан юм. Энэ нийгэмлэг нь өөрийн хүчин чармайлтыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх виктимологийн арга хэмжээг боловсруулах талаар олон улсын эрдэмтдийн үйл ажиллагааг зохицуулахад төвлөрүүлсэн юм. Энэ нь гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудад виктимологийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хурдан хөгжүүлэх боломж олгосон юм.

Виктимологи гэсэн нэр томъёо нь “victima” хохирогч гэсэн латин үг, “logos” сургаал гэсэн грек үгнээс гаралтай бөгөөд хохирогчийн тухай сургаал буюу “хохирогч судлал” гэсэн утгыг илэрхийлнэ¹. Виктимологи нь хохирогч, түүний мөн чанар, нийгмийн сөрөг үр дагавар бүхий бүхий тохироонд хохирогчийн гүйцэтгэх үүргийн тухай сургаал мөн. Эрх зүйн бус виктимологи нь азгүй учралын хохирогчийн тухай сургаал учраас түүний нарийвчилсан чиглэлд травматологи, суицидологи судалдаг байна.

Виктимологийн шинжлэх ухааныг үндэслэгчийг немецийн криминологич Ханс фон Гентиг, Румыны эрдэмтэн Бенджамин Мендельсон нарыг тооцож байна². Виктимологийн шинжлэх ухааны үндэслэгчид нь нацизм, сталинизмын хохирогч-эрдэмтэд байгаа нь тохиолдлын хэрэг биш юм. Тэд гэмт хэрэг үйлдэгдэхэд хохирогчийн гүйцэтгэх үүргийг анх шинжлэх ухааны байр сууринаас судалж, виктимологийн шинжлэх ухааны статусыг тодорхойлсон юм³.

Хохирогчийн эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, учирсан хохирлыг арилгах, аюулгүй байдлыг хангах талаарх үндсэн хуулийн үзэл санаанууд 2002, 2015, 2017 оны эрүүгийн болон эрүүгийн процессын хуульд нарийвчлагдан тусгагдсан юм.

¹ Х.Ю.Кернер. Криминология. Словарь- справочник., М., 1998.

² Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. УБ., 2005. 15 дахь тал.

³ Д.В.Ривман. Криминальная виктимология . СПб., 2002. С 23-25.

Монгол Улсад гэмт хэргийн виктимологийн онолын талаар хууль зүйн ухааны доктор, профессор П.Батбаатар “Гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлын зарим асуудал” (2018), хууль зүйн ухааны доктор, профессор Ч.Нямсүрэн “Гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдлын зарим асуудал” (2013), хууль зүйн ухааны доктор Ш.Ариунбилэг “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэнд учирсан гэмт хорыг арилгах эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” (2011), Хууль зүйн доктор, дэд профессор Ш.Чулуунбат “Улаанбаатар хотод оршин суугаа иргэдийн гэмт хэргээс айх айдас: нэгдмэл загварын шинжилгээ” (2018), доктор М.Ванчигмаа “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь иргэний нэхэмжлэл” (2020) сэдвээр тус тус докторын зэрэг хамгаалжээ. Гэмт хэргийн виктимологийн талаар 2005 онд хууль зүйн ухааны доктор, профессор Ч.Нямсүрэн “Гэмт хэргийн виктимологи” нэг сэдэвт томоохон бүтээл туурвижээ.

Хохирогчтой харилцах олон улсын эрх зүйн стандартад ойртуулах өнөөгийн эрэлт хэрэгцээ, нөгөө талаас виктимологийн нөхцөл байдал, гэмт явдлын гаралт (criminalization) ба хохирох явдлын (victimization) харилцан үйлчлэл, тэднээс урьдчилан сэргийлэх зэрэг нь гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, тэдэнтэй хүн ёсоор харьцах, мөн гэмт хэрэг, нийгмийн гажуудал, сөргөлдөөнийг багасгах, саармагжуулах чадвартай төрийн цэгцтэй бодлого боловсруулахыг шаардаж байгаа юм.

Орчин үед виктимологийн мэдлэгийн бүтцийг шинжлэх ухааны болон нийгмийн амьдралын салбар хүрээгээр нь мэдлэгийн түвшнээр ангилахыг чухалчилж байна. Уг ангиллын дагуу виктимологийн мэдлэгийг дараах байдлаар ангилсан. Үүнд:

1. Нийгэм дэх хохирох үзэгдэл, түүний нийгмийн бусад институт, үйл явцын уялдаа холбоо ба социумын хамаарлыг тодорхойлж байгаа виктимологийн нийтлэг, “суурь” онол;

2. Дунд түвшингийн виктимологийн тусгай онол (гэмт явдлын виктимологи, эрүүгийн виктимологи, деликтийн виктимологи, гэмлийн виктимологи гэх зэрэг);

3. Хавсарга виктимологи буюу виктимологийн техник (хохирохоос урьдчилан сэргийлэх ажлын тусгай техник, нийгмийн дэмжлэгийн технологи, нөхөн төлбөр, хохирол арилгах механизм, даатгалын технологи зэргийг боловсруулах, нэвтрүүлэх, туршлагын судалгаа шинжилгээ) зэрэг чиглэл гэж ангилдаг.

Хүний аюулгүй байдал, хүн төрөлхтөнд тулгарч байгаа аюул, тэдгээрийн хохирох явдал, түүний бүрэлдэхүүн зэрэг асар том, нарийн төвөгтэй объектын судлах зүйлийг тодорхойлох нь маш олон тооны шинжлэх ухааныг төрүүлэн гаргах үндэслэл болно. Виктимологийн онолын энэхүү ерөнхий глобал шинж нь: 1) Гэмт хэргийн виктимологи; 2) Осол гэмтлийн виктимологи; 3) Сэтгэцийн виктимологи; 4) Байгаль орчин, байгалийн гамшиг ба аюул сүйрлийн виктимологи; 5) Техникийн аюулгүй байдлын виктимологи гэсэн хандлагаар орчин үед хөгжиж байна.

Гэмт хэргийн виктимологи нь тусгай буюу дунд түвшний онолын хувьд эрүүгийн виктимологи, криминологийн виктимологи, криминалистикийн виктимологи¹ гэсэн гурван бие даасан хэсгээс бүрдэнэ.

Гэмт хэргийн виктимологи нь эрүүгийн ерөнхий онол, виктимологийн ерөнхий онол, социологийн ерөнхий онолын гүн ухааны үзэл, арга зүйд тулгуурлан суурилах боловч эрүүгийн эрх зүй, криминологи, эрүүгийн процессын эрх зүй, эрүүгийн

¹ Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. УБ., 2005. 69 дахь тал.

социологи, криминалистикийн зэрэг дунд түшингийн тусгай шинжлэх ухааны хохирогчийн тухай мэдлэг, мэдээлэлд тулгуурлан хөгжиж байгаа салбар дундын шинжлэх ухаан мөн. Ийм учраас гэмт хэргийн хохирогчийг виктимологийн дунд түвшний онолын хувьд зөвхөн криминологийн аспектээр биш, мөн эрүүгийн эрх зүйн онолын болон хууль зүйн бусад шинжлэх ухааны, тухайлбал криминалистикийн тактик, шуурхай эрэн сурвалжлах онол, хууль зүйн сэтгэл судлал, эрх зүйн социологийн аспект, хандлагаар иж цогцоор нь судлах хэрэгтэй юм.

Монгол Улсад хийж буй гэр бүлийн хүчирхийлэл, түүний дотор хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг ихэвчлэн гэмт хэргийн гаралтын судалгааны хүрээнд, эсхүл криминологи судалгааны нэг институци маягаар судлах хүрээгээр хязгаарлаж ирсэн нь учир дутагдалтай байна. Гэр бүлийн хүчирхийллийг судлахад виктимологийн, түүний дотор эрүүгийн, криминологийн, криминалистикийн цогц хандлага үгүйлэгдэж байна.

Бидний хийж буй энэ судалгааны хязгаарлалт нь эрүүгийн болон криминологийн виктимологийн түвшинд хийж буй анхны цогц судалгаа учраас шинжлэх ухааны ойлголт, тодорхойлолт, нэр томъёог нэг мөр ойлгож нутагшуулах, виктимологийн судалгааны объект, судлах зүйлийг нарийвчлан тодорхойлох, судалгааны ажлын бүтцийг томъёолоход хүндрэл учирч байсныг тэмдэглэх хэрэгтэй юм.

Ром-германы эрх зүйн тогтолцоотой улс орнууд нь эрх зүйн зохицуулалтын онцлогоос хамаарч, виктимологийн шинжлэх ухааныг академик чиглэлээр хөгжүүлж байхад, Англо-саксоны эрх зүйн бүлд хамаарах улс орнууд нь прагматик чиглэлээр, шууд тусгай онол, практикаар хөгжүүлэх, ерөнхий виктимологийн чиглэлийг шууд виктимологийн техникийн талаар нь амьдралд нэвтрүүлж байна.

1.2. Хүүхэд эмэгтэйчүүдийн эрсэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын виктимологийн судалгааны арга зүйн үндэс.

Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын виктимологи судалгааны судлах зүйлийн объектыг тодорхойлох, судлах зүйлийг сонгон авах даа виктимологийн шинжлэх ухааны ерөнхий зүй тогтолд захируулсан болно.


Виктимологийн суурь шинжлэх ухааны судлах зүйл нь уламжлалт, нэгэнт тогтсон сургаалуудын хамгийн тэргүүлэх үзэл санааг нэгтгэх, ашиглах замаар, нийгмийн аюултай үзэгдлүүд ба хохирогчдын хоорондын уялдаа холбоо, хөдөлгөөний зүй тогтол гэж үзэж болно.

Нийгмийн аюултай үзэгдлүүдийн хохирогчийн тухай сургаалуудын хөгжилд хийсэн судалгаанаас үзэхэд, виктимологийн ерөнхий онол нь дараах түвшинд авч үзэж болно. Үүнд:

- 1) Хохирогч;
- 2) Хохирох эрсдэл, боломж (victim precipitation);
- 3) Хохирох явдал (victimization);
- 4) Хор аюул дагуулсан үйл явдал, зан үйл ба хохирогчийн хоорондох холбоо зэргийг өөрийн үндсэн ойлголтын хувьд судална¹.

¹ Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. Уб.,2005. 62 дахь тал

Зураг 1. Виктимологийн ерөнхий онолын бүтцийг харуулав.



Виктимологийн судлах зүйлд дараах ойлголтуудыг авч үздэг байна. Үүнд: 1) Гэмт хэргийн шинж чанар, нийгмийн хор аюулын зэрэглэлийг тогтоож, хохирогчийн зүгээс түүнд хэрхэн хандаж байгааг ойлгож мэдэх; 2) Хохирох явдлын эрсдэлийг үнэлж цэгнэх; 3) Гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан хохирол, алдагдлын зэрэглэл, шинж чанарыг үнэлэх; 4) Хохирогч ба түүнийг гомдоосон этгээдийн хоорондын харилцааг судлах; 5) Гэмт хэргийн хохирогчид гэр бүл, нийгэмлэг, нийгмийн зүгээс үзүүлэх нийгмийн мэдрэмж, хандлагыг судлах; 6) Гэмт хэргийн хохирогч (төрөлхийн ба тохиолдлын); 7) Гэмт хэрэгт хохирох явдал (анхдагч, хоёр дахь, гурав дахь, дөрөв дэх); 8) Нийгмийн зүгээс гэмт хэргийн хохирогчид хандах хандлага, үзүүлэх нөлөөлөлд шинжилгээ судалгаа хийх; 9) Хохирогчийн зан үйлийн загваруудыг тайлбарлаж, тодорхойлох; 10) Гэмт хэрэгтэн ба хохирогчийн харилцан хамаарлын шалтгаант холбоо, энэ холбооны магадлалыг тогтоох; 11) Хохирогчийн зүгээс гэмт хэргийг өдөөн хатгах буюу хохирогчийн “буруу”-гийн асуудал; 12) Хохирсон болон хохирч болзошгүй этгээдэд тусламж, дэмжлэг үзүүлэх тодорхой шаардлагуудыг томъёолох; 13) Гэмт хэргийн улмаас учирсан гэм хорыг арилгах, хохирлыг нөхөн төлөх; 14) Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах зэргийг авч үзсэн байна.

Бид судлах зүйлийг сонгохдоо энэ зүй тогтлыг харгалзан хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын виктимологи судалгааны судлах зүйлийг дараах байдлаар сонгон авсан. Үүнд:

1) Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэргийн виктимологийн судалгааны онол арга зүй, эрх зүйн үндэс;

2) Монгол улсад гэр бүлийн хүрээнд хүүхэд эмэгтэйчүүд хохирох явдлын өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ;

3) Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдалд хүүхэд эмэгтэйчүүд хохироход нөлөөлж буй хүчин зүйл, шалтгаан нөхцөл;

4) Монгол улсад хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх виктимологийн ажил, арга хэмжээ, тулгамдаж буй асуудал;

5) Монгол улсад хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хохирсон эмэгтэйчүүдийн зөрчсөн эрхийг нөхөн сэргээх нь;

6) Хүүхэд эмэгтэйчүүд өртсөн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрхийг хамгаалах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын болон гадаадын зарим улс орны туршлага.

Виктимологи нь судалгааны бусад бүх салбаруудын нэгэн адил өөрийн судлагдахууныг таньж мэдэх тодорхой хандлага, аргачлал, арга хэрэгсэл, замуудыг ашигладаг. Тус шинжлэх ухаан нь олон шинжлэх ухааны уулзварт үүсэж хөгжиж байгаа учраас тухайн салбар шинжлэх ухааны арга зүй, танин мэдэхүйн аргуудад тулгуурладаг. Тухайлбал, материалист диалектик, позитивист, бүтэц, чиг үүргийн ойлголтууд нь виктимологийн хөгжлийн логик, бүтцийг тодорхойлох, түүнийг дагаж мөрдөх боломж олгож байна.

Материалист диалектикийн хууль категориудад тулгуурлан хохирох явдал, түүний шалтгаан нөхцөл, хохирогч-хувь хүн, түүний онцлог, хохирохоос урьдчилан сэргийлэх бололцооны асуудлыг тодорхойлно. Энэ нь диалектикийн тооноос чанарт шилжих хууль, шалтгаан, үр дагавар, үзэгдэл мөн чанар, ерөнхий тусгай, онцгой; зайлшгүй ба санамсаргүйн ухагдахуунууд криминологи, виктимологийн шинжлэх ухаанд өргөн хэрэглэгдэнэ.

Виктимологийн аргын позитивист ойлголт нь байгалийн шинжлэх ухаанд ашиглагдаж байгаа арга, зарчмуудыг виктимологийн шинжлэх ухаанд нэвтрүүлэх эрмэлзлээр тодорхойлогдож байгаа бөгөөд энэ шинжээрээ виктимологийн шинжлэх ухааны бодит, оновчтой байдлыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Нийгмийн үзэгдэлд позитивист аргыг ашиглахад орон зай, цаг хугацааны дотор нийгмийн хэм хэмжээнд байгалийн, жам ёсны хувиралт явагдах бөгөөд шинэ үүссэн хэсэг нь тогтолцоог бүрдүүлэх чадваргүй байна. Эдгээр хэм хэмжээнүүд нь эмх замбараагүй байдаг бөгөөд, тэд бие биеэ байнга үгүйсгэж байдаг байна. Эрдэмтэд нийгмийн ухамсрын энэ байдлыг аноми гэж нэрлэжээ. Аноми нь нийгмийн тодорхой байдал алдагдсантай холбоотойгоор, хувь хүнээс зан үйлийн чиг шугамаа тогтвортой байлгах, тодорхойлох боломжгүй болсон нөхцөл байдлыг хэлнэ гэж тодорхойлжээ. Манай нийгэмд 1990-ээд оны эхэнд аномиын үзэгдэл газар авснаас, амьдралынхаа чиг шугамыг алдаатай сонгох, төөрч будилах, аль ч учраа олохгүй байснаас ядуурах, ажилгүйдэх, мөн түүний хамт гэмт явдал ба гэмт хэрэгт хохирох явдал газар авсан.

Бүтэц чиг үүргийн арга нь нийгмийн үзэгдлийн бүхэл тогтолцоонд түүнийг бүрдүүлж байгаа аль нэг бүрдэл хэсгийн гүйцэтгэх үүргийг нээн харуулахад чиглэсэн функционализмын үндэслэлд тулгуурлана. Гэхдээ функционализм нь зөвхөн тогтолцооны доторх үзэгдлүүд хоорондын холбоо харилцааг тодорхойлдог учраас нийгмийн үзэгдлийн үүсэл хөгжлийг тайлбарлах талаар учир дутагдалтай. Харин виктимологийн мэдлэгийн бүтцийн асуудлыг бид энэ аргын хүрээнд судалгааны объектын сонголт, судалгааны түвшнээр ангилан авч үздэг.

Хууль зүйн загварчлал гэж эрх зүйн үзэгдлүүдийг харьцуулж, судлагдахууны адил шинж чанарыг тогтоох замаар, өөр үзэгдлийг тодорхойлж байгаа аргыг хэлдэг бөгөөд эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ, процесс ажиллагааны үе шат бүхэн зан үйлийн загварчлал байдаг байна. Харин криминологийн шинжлэх ухааны боловсруулсан гэмт явдлын гаралтын байдал, бүтэц, хөдөлгөөн, гэмт хэрэгтэн-бие хүн, гэмт явдлын шалтгаан нөхцөл гэсэн ойлголтуудын загварчлалыг виктимологийн шинжлэх ухаанд мөн хэрэглэдэг байна. Энэ нь гэмт хэрэгт хохирох явдал, хохирох явдлын шалтгаан нөхцөл, хохирох явдлын бүтэц, хөдөлгөөн, хохирогч-бие хүн гэсэн ойлголтуудаар илэрхийлэгддэг байна.

Эрх зүйн ойлголт гэдэг нь эрх зүйн журмуудын төсөөллийн тухайн төрлийг тодорхойлж өгнө. Ийм учраас ойлголт бол логикийн ухагдахуун, харин нэр томьёо нь лингвистикийн ухагдахуун тул “нэр томьёо” нь зохих ойлголтод нэр өгөхөд л оршино.

Нэр томьёо (terminus-хил, хязгаар гэсэн утгатай латин гаралтай үг) нь үйлдвэрлэл, шинжлэх ухаан буюу соёлын салбарын ямар нэгэн тусгай ойлголтын нэрийг илэрхийлсэн үг буюу өгүүлбэр юм. Хууль цаазын салбар дахь ойлголтын нэр нь хууль зүйн нэр томьёо мөн. Ойлголт нэр, томьёоны хоорондын гинжин холбоо бол ойлголтыг тодорхойлох явдал мөн. Хууль цаазын бүтээлүүдэд хууль зүйн нэр томьёог ашиглан тодорхойлох тухай багагүй бичсэн байдаг. Энд нэр томьёо биш, харин ойлголт тодорхойлогдож байгаа учраас энэ нь тийм зөв зүйтэй биш юм .

Тодорхойлолт гэдэг нь юмс үзэгдлийн хамгийн гол шинжийг тусгаж байгаа ойлголтыг богино хэмжээгээр илэрхийлэх логик арга мөн. Виктимологийн шинжлэх ухааны тухайд гэмт болон хохирох явдлын уг сурвалж, учир шалтгааны (криминоген-виктимоген детерминацын) хүчин зүйлүүд мөний хувьд хохирогчдын зан үйл ба тэдний хувийн зан чанарт анхаарлаа хандуулна. Виктимологийн ойлголт, нэр томьёоны дунд “хохирогч” (ерөнхий утгаараа), “гэмт хэргийн хохирогч”, “хохирох эрсдэл, боломж (виктим эрсдэл)”, “хохирох явдал” (виктимизаци), “хохирлын уг гарвал” (сурвалж), (виктимоген байдал) ба “хохирох тохироо”, “хохирогчийн виктим зан үйл”, “хохирогчийн гэм буруу” зэрэг чухал байр суурь эзэлнэ.

Виктимологийн шинжлэх ухаанд эрүүгийн эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, криминалистикийн шинжлэх ухааны хамгийн өргөн хэрэглэгддэг хууль зүйн загварчлал, харьцуулалтын аргуудаас гадна, криминологи, эрүүгийн социологийн шинжлэх ухааны нэгэн адил, виктимологийн судалгааг явуулах социологийн тодорхой аргууд чухал үүрэгтэй. Эдгээр аргуудад виктимологийн мэдээллийг цуглуулах арга болон виктимологийн мэдээллүүдийг нэгтгэн дүгнэх, боловсруулах аргуудыг ашигладаг байна.

Виктимологи нь ерөнхий агуулгаараа хохирогч, түүнд хохирол учрахтай холбоотой янз бүрийн асуудлыг судална. Хамгийн эхэлж гэмт хэрэг үйлдэгдэх болон түүнд хохирох учир шалтгааны (криминоген-виктимоген детерминаци) хүчин зүйлүүдийн хувьд хохирогчдын зан үйл ба тэдний хувийн зан чанарт анхаарлаа хандуулна. Ийм учраас виктимологийн ойлголт, нэр томьёоны дунд “хохирогч” (ерөнхий утгаараа), “гэмт хэргийн хохирогч”, “хохирох эрсдэл (виктим боломж)”, “хохирох явдал (виктимизаци), “виктимоген-хохирох уг шалтгаан” ба “хохирох тохироо” чухал байр суурийг эзэлнэ. Эдгээр ойлголтуудаас виктимологийн шинжлэх ухааны шийдвэрлэх асуудлуудын хэмжээ хязгаар тодорхойлогдоно.

Виктимологийн үзэгдэл, үйл явцын мөн чанарыг танин мэдэхийн тулд үнэн зөв мэдээллийг олж авах шаардлагатай. Виктимологийн шинжлэх ухаанд энэ мэдээллийн үндсэн эх сурвалж нь виктимологийн судалгаа шинжилгээ мөн. Виктимологийн судалгаа, шинжилгээг тодорхой шалгуураар ангилах, төрөлжүүлэх хандлагууд бий. Эхний шалгуур нь виктимологийн үзэгдэл, үйл явц, түүний үр дагаврын тухай мэдлэг хүлээн авах түвшнээр нь онолын ба туршлагын судалгаа, шинжилгээ гэж ангилдаг. Онолын судалгаа нь виктимологийн үзэгдлүүдийн үүсэл хөгжлийн чиг хандлагыг илрүүлэх, хохирох үзэгдэл, үйл явц, үр дүнд задлан шинжилгээ хийх онолыг боловсруулахад чиглэгдэнэ. Онолын судалгаа шинжилгээнд хуримтлагдсан фактын материалуудыг нэгтгэн дүгнэх асуудал шийдвэрлэх ач холбогдолтой.

Туршлагын шинжилгээ судалгааны төвд фактын материалыг цуглуулах, хуримтлуулах, анхан шатны боловсруулалт хийх ажиллагаа өөрөө багтана. Туршлагын судалгаа шинжилгээ нь виктимологийн үзэгдэл, объект, үйл явцыг судлахад хэрэг болох, өнгөрсөн үйл явдлуудыг шууд буюу шууд бусаар бүртгэн авах замаар фактуудыг цуглуулах, нэгтгэх ажиллагаа юм.

Виктимологийн судалгаа шинжилгээг ангилах өөр нэг шалгуур бол түүний зорилго, зорилт, чиг үүргийн зориулалтаас хамаарч суурь ба хавсарга судалгаа гэж ангилдаг. Суурь судалгаа шинжилгээ нь виктимологийн мэдлэгийг хүрээг өргөжүүлэх, баяжуулах, мөн түүний онол арга зүйг боловсруулах, боловсронгуй болгоход чиглэнэ.

Хавсарга судалгаа, шинжилгээ нь виктимологийн тодорхой үйл явцыг урьдчилан таамаглах, зохицуулах, түүнд нөлөөлөх зэрэгтэй холбоотой виктимологийн асуудлуудын практик шийдлүүдэд тулгуурлана. Виктимологийн техник буюу хавсарга шинжлэх ухаан нь виктимологийн хавсарга судалгаа, шинжилгээнд тулгуурладаг. Виктимологийн мэдээллүүдийн үндсэн эх сурвалж, цуглуулах хэрэгслийг дараах байдлаар ангилдаг байна. Үүнд:

- 1) Эрүүгийн гэмт хэргийн тоо бүртгэлийн материалууд;
- 2) Иргэд, нийгмийн нийтлэгүүд, нийгмийн институт ба албад, эрүүгийн ажилтнуудын социологийн санал асуулгын материалууд;
- 3) Эрх зүйн эх сурвалжийн болон хэрэглэсэн актуудын анализын материалууд;
- 4) Гэмт хэргийн хохирогчийн өөрийнх нь яриа, санал асуулга;
- 5) Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн шинжилгээ;
- 6) Гэрчүүдийн санал асуулга;
- 7) Эмнэлгийн бичиг баримтын шинжилгээ тус тус багтана.

Орчин үеийн виктимологи нь танин мэдэхүйн диалектик зарчимд үндэслэн мэдээлэл цуглуулах, боловсруулах явцад, социологийн тодорхой ба сэтгэл зүйн шинжилгээний мэдээлэл цуглуулах (магадлан шалгах, сонгон шалгах, нэг бүрчлэн шалгах), нэгж үйл явдлын бүртгэлийн (ажиглах, бичиг баримт ба материал судлах, анкетын ба бусад санал асуулга, сэтгэцийн шинжилгээ, сорилго), мэдээллийг задлан шинжлэх боловсруулах (тодорхойлон бичих ба төрөлжүүлэх, хэв маягийн ангилалт, туршлагын шинжилгээ, тоо бүртгэлийн шинжилгээ, генийн шинжилгээ, нийгмийн загварчлал гэх зэрэг) зэрэг хангалттай хэмжээгээр загварчлагдсан аргуудыг ашигладаг.

Виктимологи нь мөн мөн ерөнхий, тусгай ба хууль зүйн сэтгэл судлалын мэдээллүүдийг хохирох эрсдэл, хохирох үйл явцын шалтгаан нөхцөлийг танин мэдэхийн тулд ашигладаг бөгөөд эдгээр нь хохирогч-бие хүнийг судлах, ангилахад

голлох үүрэг гүйцэтгэж, виктимологийн урьдчилан сэргийлэх, хүмүүжлийн нөлөөллийн арга хэмжээг боловсруулахад үнэлж баршгүй тустай юм. Үүнд мөн хүн ам зүйн, социологийн ба улс төр судлалын мэдээллүүд багтах ба эдгээр нь гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөр боловсруулах, прогноз дэвшүүлэхэд, түүнчлэн насанд хүрээгүй хүүхэд, рецидив-хохирогч, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд, эмэгтэйчүүд, эдийн засгийн салбар дахь хохирох явдлыг тусгайлан судлахад чухал ач холбогдолтой.

Виктимологи нь хохирогч, хохирох эрсдэл, хохирох үйл явцыг бүхэлд нь хамарсан иж цогцолбор шинжлэх ухаан буюу гэмт явдлын болон гэмт явдлын бус хохирогчийг судлах өөр өөрийнхөө судлах зүйлтэй шинжлэх ухааны зэрэгцээ салбарууд үүсэх хөгжих хэтийн төлөвтэй байна.

Виктимизаци нь хохирох эрсдэлийг нэгтгэн дүгнэх хэмжүүрийн хувьд гэмт явдлын нэгэн адил, төстэй үзүүлэлтүүдээр илэрхийлэгдэж болно. Энэ нь мэдээжийн хэрэг, анхдагч виктимизацийг тодорхойлох нь эрүүгийн тоо бүртгэлийн мэдээллийн үндсэн дээр гэмт явдал, түүний бүрдэл хэсгүүдэд хийсэн судалгаа шинжилгээнээс илүү гүн гүнзгий нарийн төвөгтэй байгаа юм. Үүнээс гэмт хэрэгт хохирох явцын судалгаа шинжилгээнд (Victimization surveys) дараах зүйлийг ангилан авч үзэх хэрэгтэй байна. Ийм учраас виктимизацийн үзүүлэлтүүдийг:

1) *виктимизацийн байдлыг* хохирох эрсдэлийн тоо, цаг хугацаа ба нутаг дэвсгэрийн хуваарилалтын онцлог, тодорхой нутаг дэвсгэр дэх түүний бүтцийн элементүүдээр нь тодорхойлж, туйлын ба харьцангуй /коэффициент/ үнэлгээгээр тооцож байгаа ерөнхий нэгдсэн үзүүлэлтээр;

2) *виктимизацийн бүтцийг* гэмт хэргийн төрөл, хэв маягаар нь, мөн алс хэтдээ гэмт хэргийн хохирогчийн төрөл, хэв маяг, виктим идэвхийн хэв маягаар нь;

3) *виктимизацийн хөдөлгөөнийг* хохирох эрсдэлийн хуваарилалтын зүй тогтол, процессыг цаг хугацаагаар нь тодорхойлох;

4) *виктимизацийн географи, экологи, топографийг* бүс нутгийн эдийн засаг-газар зүйн шинж чанар, нийгмийн нийтлэгүүдийн оршин суугаа орчны экологийн шинж, тодорхой криминоген тохирооны тархалтын шинжээр нь хохирох эрсдэлийн зүй тогтол, онцлогийг орон зайд нь тус тус тодорхойлж болно.

Гэмт хэрэгт хохирох хамтын эрсдэлийн үзүүлэлтүүд нь */түүний түвшин, бүтэц зохион байгуулалт, төрөл, хөдөлгөөн гэх зэрэг/* чухамдаа гэмт явдлын буюу хамтын (нийтлэг) виктимизацийн үр дүнг тусгаж чадна.¹ Ийм учраас хэрэгжиж байгаа хохирох хамтын эрсдэл нь виктимизацийн байдлаар */түвшин, бүтэц ба хөдөлгөөн/* тодорхойлогдоно.

Хохирох эрсдэлийн түвшин гэдэг нь бие хүнд хохирол учруулж байгаа гэмт хэргийн туйлын тоогоор илэрхийлэгдэх тоо хэмжээ бөгөөд эдгээр гэмт хэргийн хохирогчийн тоо, түүнчлэн гэмт хэргийн улмаас хохирол учирсан тохиолдолд *эрсдэлийн түвшин* нь гэмт хэрэг ба хохирогчоос илүү байж болно.

Хохирох эрсдэлийн индекс /буюу коэффициент/ нь хохирч болох эрсдэлийг тодорхойлж байгаа харьцангуй хэмжүүрүүдийг тусгана. Тэд нь зарчмын хувьд гэмт явдлын индекстэй адил төсөөтэй байна.

Хохирох эрсдэлтэй этгээдүүдийн индекс нь тодорхой цаг үеийн, аль нэг нутаг дэвсгэр дэх, нийт хүн амын 10 мянга, эсхүл 100 мянган хүнийг харгалзсан гэмт хэргийн

¹ Коновалов. В.П. Изучение потерпевших с целью совершенствования профилактики правонарушений. М.: ВНИИ МВД СССР. 1982.С 10.

хохилогчийн тооноос бодож гаргана. Энэ үзүүлэлт нь зөвхөн харьцангуй тоогоор илэрхийлэгдэнэ.

1.3. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын виктимологийн судалгааны эрх зүйн үндэс

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 40/34 дүгээр шийдвэрээр “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал” батлагдсан нь дэлхийн улс орнуудад виктимологийн шинжлэх ухаан хөгжих эрх зүйн гол үндэслэл болсон юм.

Олон улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр НҮБ-ын 1979 оны Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Олон улсын хүний эрхийн байгууллагууд 1993 онд Вена хотод хуралдаж гэр бүлийн харилцаанд эмэгтэйчүүдийг хүчирхийлэх бүх хэлбэрийг устгахыг уриалсан Венийн тунхаглал, НҮБ-ын Хүний эрхийн комисс 1994 онд эмэгтэйчүүдийн хүчирхийллийн асуудлаар илтгэх тусгай илтгэгч томилсон шийдвэр, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны зүйл бүхий эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг тунхаглал, Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг 1995 оны Бээжингийн тунхаглал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хүчирхийллийн асуудал нь эрүүл мэндийн салбарын тэргүүлэх ач холбогдол өгөх зүйл болохыг онцолсон 1996 оны тогтоол, 1997 оны хүчирхийлэлд өртсөн хүнд тусламж үйлчилгээ үзүүлэх удирдамж зэрэг эрх зүйн актууд үйлчилж байна.

Монгол улс нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенцод Монгол улс 1990 онд нэгдэн орсон. Конвенцод зааснаар “Хүүхдүүд нас хүйс, нийгмийн гарал, шашин шүтлэг, хаана, хэнээс төрсөн зэргээсээ үл хамааран эрүүл, аюулгүй, аз жаргалтай, бүрэн дүүрэн амьдралаар амьдрах ёстой”¹ гэх үзэл санаа нь энэхүү конвенцын үндэс мөн. Энэ үүднээс хүүхэд бүр ямар эрх эдлэх ёстой, эдгээр эрхээ эдлэхэд нь эцэг эх, асран хамгаалагч, гэр бүл, төр засаг ямар үүрэг хүлээх ёстой тухай эл конвенцод нарийвчлан заасан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт зааснаар иргэн нь: “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх”² эрхтэй, Арван есдүгээр зүйлд: “Төрөөс... хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заажээ.

Мөн Монгол Улсын урт хугацааны бодлогын Алсын хараа 2050-ын Давуу талдаа тулгуурлан эрсдэлийг даван туулах нь хэсэгт “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хөрш орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, эрсдэлтэй иргэдийн хяналтыг чангатгах”³ талаар төрийн бодлогын хэмжээнд авч үзсэн байна.

¹ НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц. 1989

² Монгол Улсын Үндсэн хууль. 1992. Төрийн мэдээлэл №1.

³ Монгол Улсын Их Хурлын тогтоол. 2020. Дугаар 52. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай

2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдан 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчлэлд хамаарах зарчмын томоохон өөрчлөлтийн нэг нь хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх процессыг тодруулснаас гадна гэр бүлийн хүчирхийллийг иргэний эрх зүйн маргаан бус гэмт хэрэг, зөрчил¹ болохыг хуульчилсан. Энэхүү хуульд гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагч, асран хамгаалагч, үрчлэн авсан хүүхэд, эцэг эх, салсан хосууд болон хамтрагчид зэргийг хуульд хамруулснаас гадна ГБХ-ийн тодорхойлолтыг илүү өргөжүүлэн, сэтгэл санаа, эдийн засгийн болон бэлгийн хүчирхийллийг хүлээн зөвшөөрч хуульчлан, тусгасан.

УИХ-аас 2017 онд баталсан Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт: “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон; хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; бусадтай харилцахыг хязгаарласан; хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна”² гэж заажээ. 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 11.7 дугаар зүйлд: “Гэр бүлийн харилцаатай хүнийг байнга зодсон; харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гээд 2 дахь хэсэгт: “Энэ гэмт хэргийг хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн; асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн; таслан зогсоох хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”³ хэмээн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хуульчилжээ. Түүнчлэн, Эрүүгийн хуулийн бусад төрлийн гэмт хэрэгт дараах байдлаар хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон хуульчилжээ. Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.8 дахь хэсэгт “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүнийг санаатай алах”; 11.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах”; 11.4 дүгээр зүйл 2.1 дэх хэсэгт “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах”; 11.6 дугаар зүйл 2 дахь хэсэгт “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах”; 12.1 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэгт “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэх” зэргээр хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хуульчилсан байна.

Монгол Улс НҮБ-ын “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ийн зарчим, үзэл баримтлалд тулгуурлан “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулийг 1996 онд баталснаар хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангах эрх зүйн үндсийг тогтоосон. Энэ хуулийг “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” нэртэйгээр 2016 онд шинэчлэн баталсан. Энэ нь сүүлийн жилүүдэд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хийсэн ажлын нэг хэсэг

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай. 2017. Төрийн мэдээлэл №5.

² Зөрчлийн тухай. 2017. Төрийн мэдээлэл №24.

³ Эрүүгийн хууль. 2016. Төрийн мэдээлэл №7.


бөгөөд үүнээс гадна хэд хэдэн хууль хэрэгжиж эхлээд байна. Тухайлбал, 2015 онд “Хүүхэд харах үйлчилгээний тухай”, Хүүхэд хамгааллын тухай” хуулийг баталсан. Мөн 2015 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд хүүхдийн эсрэг гэмт хэргийг бие даасан бүлэг бий болгон, 2016 онд шинэчлэн баталсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах зохицуулалтыг хуульчилсан.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСАД ГЭР БҮЛИЙН ХҮРЭЭНД ХҮҮХЭД ЭМЭГТЭЙЧҮҮД ХОХИРОХ ЯВДАЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн тоон судалгаа

Бид статистик мэдээлэлд үндэслэн гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, чиг хандлагыг тодорхойлох зорилтын хүрээнд цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал статистик судалгааны сүүлийн 6 жил¹-ийн тоон мэдээлэл, шүүхийн сүүлийн 3 жилийн гэр бүлийн хүчирхийллийн тоон мэдээлэлд үндэслэн виктимологийн үндсэн ойлголтыг тодорхойлох судалгааг явуулсан.

Зураг 2. Улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд, эмэгтэйчүүдийг харьцуулсан судалгаа.



Улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас сүүлийн 6 жилд 261112 хүн хохирсноос хүүхэд 9605 буюу 3.6 хувь, эмэгтэй 82821 буюу 31.7 хувийг эзэлж байна. Ковид 19 цар тахлын үед хүүхэд, эмэгтэйчүүд хохирсон гэмт хэргийн тоо буурсан ч 2022 оноос огцом өссөн байна. тухайлбал, хүүхэд хохирсон гэмт хэрэг 2020 оноос 2022 онд 70.5 хувиар, эмэгтэйчүүд хохирсон хэрэг мөн онтой харьцуулахад 70.8 хувиар тус тус эрс өссөн байна.

Зураг 3. Нийслэлийн хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд, эмэгтэйчүүдийг харьцуулсан судалгаа.

¹ Эрүүгийн хууль шинэчлэн найруулагдсанаас хойших үеэр судалгааны цар хүрээг тогтоосон болно



Нийслэлд гэмт хэргийн улмаас сүүлийн 6 жилд 189207 хүн хохирсноос хүүхэд 6050 буюу 3.1 хувь, эмэгтэй 59229 буюу 31.3 хувийг эзэлж байна. Хохирсон хүүхэд, эмэгтэйчүүдийн өсөлтийн хувьд Ковид 19 цар тахлын үед хүүхэд, эмэгтэйчүүд хохирсон гэмт хэргийн тоо мөн адил буурсан ч 2022 оноос огцом өссөн байна. Тухайлбал, хүүхэд хохирсон гэмт хэрэг 2020 оноос 2022 онд 85.6 хувь, эмэгтэйчүүд хохирсон хэргийн тоо 78.1 хувиар эрс өссөн, хөдөө орон нутагт үйлдсэн гэмт хэрэгтэй харьцуулахад 8-15 хувиар өссөн дүнтэй байна.


Хүснэгт 2. Орон нутаг, нийслэл, улсын хэмжээнд үйлдсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн судалгаа.

Он	Улсын хэмжээнд	Нийслэлд	Орон нутагт
	Нийт гэмт хэрэгт эзлэх хувьтай харьцуулсан байдлаар		
2017 он	1286 (4%)	757 (2.3%)	529 (1.7%)
2018 он	1070 (3%)	590 (2.3%)	478 (4.6%)
2019 он	985 (3.1%)	494 (2.4%)	491 (4.4%)
2020 он	1138 (4.9%)	584 (4%)	554 (6.6%)
2021 он	1531 (6%)	852 (5.2)	679 (7.6%)
2022 он	1729 (4.8%)	882 (6.6%)	847 (7.6%)

Улсын хэмжээнд сүүлийн 6 жилийн хугацаанд үйлдсэн бүх гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг харьцуулан судлахад Улаанбаатар хотод давамгайлсан байдлаар үйлдэж байна. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн эзлэх хувь бүх хэрэгтэй харьцуулсан байдлаар судлахад Улаанбаатар хотод тогтмол өссөн дүг харуулж байна. Тодруулбал 2021 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг өмнөх оноос 1.2 хувиар, 2020 онд мөн 1.2 хувиар тогтмол дүнтэй өссөн байна.

Улаанбаатар хотод үйлдсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг дүүргээр нь харьцуулан судлахад хүн ам шигүү суурьшсан, дүүргүүдэд түлхүү үйлдэгдэж байна.

Зураг 4. Улаанбаатар хотод үйлдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт явдлын хөдөлгөөн.



Сүүлийн 6 жилийн хугацаанд улсын хэмжээнд 183836 гэмт хэрэг бүртгэснээс 168686 иргэн, үүнээс 82821 эмэгтэй, 9605 хүүхэд хохирч, нийслэлийн хэмжээнд нийт хохирогч нарын 73.4 хувь, эмэгтэй хохирогчдын 71.5 хувийг, хүүхдийн 62.9 хувийг эзэлж байна. Үүнээс үзэхэд нийслэлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн 10 эмэгтэйн 7 нь, 10 хүүхдийн 6 нь хохирогч болж байна.


Хүснэгт 4. Нийслэлийн дүүргүүдийн хүн амын нягтаршил, нутаг дэвсгэрийг гэр бүлийн хүчирхийлэлтэй харьцуулан судалсан байдал.

Дүүрэг	Сүүлийн 6 жилд үйлдсэн ГБХ-ийн гэмт хэрэг	Газар нутгийн хэмжээ (км ²)	ГБХ-ийн эзлэх дундаж	Хүн амын нягтаршил ¹	ГБХ-ийн эзлэх хүн амын дундаж
Баянгол	514	29.500	57	225.840	439
Баянзүрх	1180	1.244.100	1054	361.689	307
Сүхбаатар	394	208.4 00	529	144.409	367
Сонгинохайрхан	922	1.200.600	1302	327.580	355
Чингэлтэй	429	89.300	208	148.977	347
ХанУул	488	484.700	993	187.278	384
Налайх	122	687.600	5636	39.579	324
Багануур	92	620.200	6741	28.570	311
Багахангай	18	140.000	7778	4.123	229

Нийслэлийн дүүргүүдэд үйлдсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, түүнийг дүүргийн нутаг дэвсгэр, хүн амын тоотой харьцуулан, сүүлийн 6 жил үйлдсэн гэмт хэргийн тоотой харьцуулан судлахад хүн амын нягтаршил, газар нутгийн хэмжээнээс үл шалтгаалан Багахангай дүүрэгт хамгийн өндөр, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүдэд эзлэх хувь өндөртэй байна. Энэ нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт нутаг дэвсгэрийн нөхцөл байдал үл шалтгаалдаг байдлыг харуулж байна.


¹ 2020 оны хүн ам, орон сууцын тооллогын мэдээ

Зураг 5. Улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийг насны байдлаар харьцуулсан судалгаа¹.



Цагдаагийн байгууллагын хэмжээнд сүүлийн 6 жил бүртгэсэн гэмт хэргийн мэдээгээр нийт 9605 хүүхэд хохирсноос 60.9 хувь нь буюу хүүхэд 6050 нийслэлд үйлдсэн гэмт хэргийн улмаас хохирсон байна. Насны байдлаар харьцуулан судлахад нийслэлийн хэмжээнд өсвөр насны хүүхэд хохирсон тохиолдол харьцангуй өндөр 61.9 хувь буюу 3747 хүүхэд байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд гэмт хэргийн улмаас хүүхэд хохирох явдал эрс өсөж, 5 жилийн өмнөх үзүүлэлтийг давсан байна.


Зураг 6. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогчдын судалгаа.



Цагдаагийн байгууллагын статистик тайлан мэдээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн улмаас нас барсан хохирогч 82 буюу 1.1 хувь, гэмтсэн хохирогч 5956 буюу 81.3 хувь, хүчиндүүлсэн хохирогч 417 буюу 5.6 хувь, бусад хэлбэрийн хохирол хүлээсэн хохирогч 864 буюу 11.8 хувьтай байна. 2022 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас амь насаараа хохирсон, гэмтсэн хохирогчдын тоо сүүлийн 5 жилийн дунджаас хамгийн өндөр байна.

¹ Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэсэн гэмт хэргийн мэдээ 2017-2022 он

Зураг 7. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогчдын судалгаа¹.



Цагдаагийн байгууллагын хэмжээнд сүүлийн 6 жил бүртгэсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн мэдээгээр 7046 хүн хохирсноос, 2017 онд хохирсон хүүхдийн судалгаа, 2018 онд хохирсон хүүхэд, эмэгтэйчүүдийн судалгааг гараагүй, сүүлийн 4 жилийн хугацаанд хохирсон хүүхэд, эмэгтэйчүүдийн тоо тогтмол өсөж байна.

Хүснэгт 6. Нийслэлийн дүүргүүдийн хүн амын нягтаршил, нутаг дэвсгэрийг гэр бүлийн хүчирхийлэлтэй харьцуулан судалсан байдал.

Хэргийн төрөл	2020		2021		2022		Сүүлийн 3 жилийн дүн	
	Хэргийн тоо	Ял шийтгүүлэгчийн тоо	Хэргийн тоо	Ял шийтгүүлэгчийн тоо	Хэргийн тоо	Ял шийтгүүлэгчийн тоо	Хэргийн тоо	Ял шийтгүүлэгчийн тоо
Хүнийг алах	210	209	197	205	179	177	586	591
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	365	375	327	322	399	402	1091	1099
Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	5689	6194	5006	4926	6097	6509	16789	17629
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	101	67	99	60	97	84	294	211
Хүчиндэх	307	295	346	328	363	333	1016	956

Эрүүгийн анхан шатны шүүхээр 2022 онд хянан шийдвэрлэсэн нийт хэргээс хүнийг алах гэмт хэрэг 18 хэргээр буюу 9.1 хувиар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2 хэргээр буюу 2.0 хувиар, хүн худалдаалах гэмт хэрэг 3 хэргээр буюу 50.0 хувиар тус тус буурсан бол хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг 72 хэргээр буюу 22.0 хувиар, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт

¹ Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэсэн гэмт хэргийн мэдээ 2017-2022 он

хэрэг 1091 хэргээр буюу 21.8 хувиар, хүчиндэх гэмт хэрэг 17 хэргээр буюу 4.9 хувиар тус тус өссөн дүнтэй гарчээ. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг дангаар зүйлчлэхээс гадна хүн алах, санаатайгаар хүний биед гэм хор учруулах, хүчиндэх гэмт хэрэгт гэр бүлийн хамаарал бүхий этгээд болон бага насны хүүхдийн эсрэг гэмт хэрэгт гэсэн нэр томъёогоор илэрхийлж давхар зүйлчлэх асуудал шүүхийн практик элбэг байна. Жишээ нь эрүүгийн хуулийн “Хүнийг алах” гэсэн 10.1 дүгээр зүйлийн 2.7 дах хэсэгт хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй, бага насны хүүхэд, жирэмсэн болохыг мэдсээр байж алах, 2.8 дахь хэсэгт гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж алах үйлдлийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс өөр зүйлээр зүйлчлэх нь хүчирхийллийн статистик мэдээлэл бүрэн гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлжээ.

Мөн хуулийн хүчиндэх гэсэн 12.1 дүгээр зүйлд “Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол...” хорих ял шийтгэхээр заажээ. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар бэлгийн хүчирхийллийн хүнд хэлбэрүүд болох гэр бүлийн хамаарал бүхий хоёр ба түүнээс дээш хүнийг хүчиндэж, жирэмсэн болгож, бэлгийн замын халдварт өвчин тараасан, мөн бага насны хүүхдийг хүчиндсэн бол гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгтэй давхар зүйлчлэх эсэх нь тодорхойгүй байна. Энэ талаар нарийвчилсан тайлбар гаргах шаардлагатай байна. Мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол онц хүндрүүлэхээр заасан.

Үүнээс үзэхэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, түүний дотор хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн бодит судалгаа гаргахад хүндрэлтэй байна.


Монгол Улсын шүүхийн мэдээнээс үзэхэд 2022 онд Гэмт хэргийн улмаас хохирсон хүний 19365 хүн буюу 99.9 хувь нь Монгол Улсын иргэн, 11 хүн буюу 0.1 хувь нь гадаад улсын иргэн байна. Мөн онд гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 5.8 хувь буюу 1132 хүн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн байна.

Хүснэгт 7. Шүүхийн статистик мэдээллээс үзэхэд сүүлийн гурван жилд дараах нөхцөл байдал илэрч байна.

Он		2020	2021	2022	нийт
Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нийт хүн		1552	1353	1132	3737
Үүнээс	Эмэгтэй	1255	924	968	3147
	хүүхэд	141	114	163	418
Хүчирхийллийн хэлбэрээр	Бие махбодын	1465	1269	1028	3762
	Сэтгэл санааны	40	15	17	72
	Бэлгийн	47	68	85	200
	Эдийн засгийн	0	1	2	3
Үргэлжилсэн	1 жил хүртэл	1157	862	894	2913

хугацаа	2-3 жил	262	271	155	688
	4-5 жил	94	129	55	278
	6-8 жил	28	33	17	78
	8 жилээс дээш	11	58	11	80
Давтамж	Жилд 1-2	878	819	825	2522
	Улиралд 1-2	111	270	138	519
	Сард 1 удаа	217	134	109	460
	14 хоног дутам	41	50	21	112
	7 хоног дутам	128	14	4	146
	3 хоног дутам	130	8	0	138
	байнга	47	58	35	140

Зураг 8. Шүүхийн судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хүчирхийллийн хэлбэр, бүтцээр нь харьцуулсан судалгаа.




Хүчирхийллийн хэлбэрээр нь авч үзэхэд нийт хүчирхийллийн 93% нь бие мах бодийн, 5 % нь бэлгийн хүчирхийлэл, сэтгэл санааны хохирол 2%-ийг эзэлж байна. Харин хүүхдийг үл хайхрах хүчирхийллийн хэрэг сүүлийн 3 жилд огт хянан шийдвэрлээгүй байна.

Үл хайхрах хүчирхийлэл харьцангуй амьдралын боломжтой гэр бүлд явагддаг. Аав, ээж ар гэрийнхэн нь хүүхдэдээ анхаарал бага тавьж, хүүхдээ үл хайхрах хүчирхийлэлд өртүүлдэг асуудал байдаг. Эцэг эхийн хараа хяналт сулрах, завгүй олон цагаар ажиллах зэрэг нөхцөл байдал хүүхдүүдийг үл хайхрах хүчирхийлэл буюу түүнийг дагасан эрсдэлүүдэд хүргэж байдаг. Завгүй гэх нэрийн дор хүүхдээ үл хайхрах хүчирхийлэлд өртүүлдэг. Том хүүхдээрээ бага хүүхдүүдээ харуулах, хэт өндөр настай хүмүүст хүүхдээ харуулж орхидог. Хэдийгээр ийм нөхцөл байдлын дуудлага 108 төвд бага ирдэг ч энэ нь цаашдаа даамжирвал хүүхэд эрсдэлд орох нөхцөлүүдийг бүрдүүлж байдаг.


Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Зураг 9. Шүүхийн судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн бие махбодын хүчирхийллийн хөдөлгөөнийг харьцуулсан байдал.



Шүүхийн тайлан мэдээнд 2020-2022 онд бие махбодын хүчирхийллийн хөдөлгөөнийг үзэхэд байнга буурч буй үзүүлэлттэй байна. Тухайлбал бие махбодын хүчирхийлэл 2020 онд 1465 байсан бол 2022 онд 1028 болж 29 хувиар буурчээ.

Зураг 10. Шүүхийн судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн сэтгэл санааны болон бэлгийн хүчирхийллийн хөдөлгөөнийг харьцуулсан байдал.




Дээрх судалгаанаас 2020-2022 бэлгийн хүчирхийлэл байнга өсөж байгаа нь сонирхол татаж байна. Сэтгэл санааны хүчирхийлэл нь бие махбодын болон хүүхдийг үл хайхрах, эдийн засгийн хүчирхийллийн байнгын дагавар гэдгийг цаашид тооцох шаардлагатай юм.

Бид түүвэр сонголтоор нийслэл хотын 7 дүүргийн хүрээнд 1000 иргэдээс гэр бүлийн хүчирхийлэл, түүний дотор хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын талаар тандалт судалгааг компьютер ашиглан ярилцлага авах (CAPI) аргаар явуулсан болно. Судалгааны мэдээлэл цуглуулалтын CSPro 6.3 (тооллого, түүвэр судалгааны мэдээлэл боловсруулах систем) программыг ашигласан. Судалгаанд оролцогчдын хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахаар зорьсон бөгөөд 1276 хүнийг хамруулснаас 53.1% нь эрэгтэй, 46.9% нь эмэгтэй хүнийг судалгаанд оролцуулав.


Судалгааны хүрээнд 21 үзүүлэлтээр “docs.google.com/forms” программ ашиглан авсан мэдээллээс үзэхэд дараах нөхцөл байдал илэрч байна.

Зураг 11. Судалгаанд оролцогчдыг насны ангилал.




Судалгаанд оролцогчдын насны хувьд 18-60 насны иргэд оролцсон бөгөөд 35-60 нас хүртэлх хүмүүс 76%-ийг эзэлж байгаа нь насны хувьд харцангуй тогтсон, амьдрал, гэр бүлийн тушлага бүхий насныхан хамрагдсан байна.

Зураг 12. Судалгаанд оролцогчдыг ам бүлийн байдлаар харуулав.




Судалгаанд оролцогчдын ам бүл 3-6 гишүүнтэй 95%-ийг эзэлж байгаа нь гэр бүлийн нөхцөл байдлыг дүгнэхүйц туршлагатай хүмүүс хамрагдсан.

Зураг 13. Судалгаанд оролцогчдыг боловсролын түвшин харуулав.




Судалгаанд оролцогчдын 90.6%-ийг дээд боловсролтой хүмүүс эзэлж байгаа нь оюун дүгнэлтийг харьцангуй сайн хийж туршлагатай хүмүүс хамрагдсныг илэрхийлж байна.

Зураг 14. Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан эсэх саналыг харуулав.




Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь гэр бүлийн хүчирхийллийн аливаа нэг хэлбэрт өртөж байсан бөгөөд 70 орчим хувь нь төрийн байгууллагад хандаж байгаагүй байна. Мөн 40 орчим хувьд нь хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан байна.

Зураг 15. Иргэдээс гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан эсэхийг тодруулсан судалгаа.




Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь хүчирхийллийн дам хохирогч болсон, хүүхдийн дэргэд согтууруулах ундаа хэрэглэсэн талаар илэрхийлжээ.

Зураг 16. Судалгаанд оролцогчдын гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг ямар байгууллага шийдвэрлэсэн талаар харьцуулсан судалгаа.




Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь цагдаагийн байгууллагад итгэл хүлээлгэсэн, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд чухал үүрэгтэйг илэрхийлсэн байна.

Зураг 17. Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хамтарсан багийн урьдчилан сэргийлэх ажлын талаарх саналыг харуулав.




Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь хамтарсан багт итгэл хүлээлгээгүй байна.

Зураг 18. Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн шалтгаан нөхцөлийг илэрхийлсэн саналыг харуулав.



Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь хуулийн мэдлэг дутмаг, гэр бүлээ хадгалж үлдэх эрмэлзлэл, дахин ирэх заналхийлэл, садан төрлийн таарамжгүй харилцаа үүсэхээс эмзэглэн хүчирхийллийн талаар зохих газарт мэдэгдээгүй зэрэг шалтгаанаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн шалтаанаа илэрхийлсэн байна.

Зураг 19. Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийн хэдэн хувь нь цагдаагийн байгууллагад хандсан эсэх талаарх саналыг харуулав.




Судалгаанд оролцогчдын 74.2% нь 10-60% нь нуугдмал байдлаар цагдаагийн байгууллагад мэдэгдэхгүй өнгөрдөг талаар дурджээ. Энэ нь тэдний хохирогчийн гэмт хэрэгт дахин хохирох, гэр бүлийн хүчирхийллийн хэрэг даамжрах шалтгаан болдог гэдгийг огт мэдэхгүй, хуулийн байгууллагад мэдэгдэхгүй нуудаг байдлыг илэрхийлсэн байна.

Зураг 20. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсооход хамгийн түрүүнд хэнээс хамаарах эсэх талаарх саналыг харуулав.



Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь иргэдийн ёс суртахуунтай холбож үзсэн бол 25 хувь нь л хохирогчийн хувийн байдлаас шалтгаална гэж хариулсан байна. Энэ нь судалгаанд оролцогчдын 4/1 нь л хохирогчоос шалтгаалж байна гэж үзсэн боловч хохирогчийн виктимологи эрсдлийг үл тооцон “түүнийг буруутгах” хандлага давамгайлсан гэж үзэх үндэстэй байна.

Зураг 21. Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байгаа гол шалтгааны талаар илэрхийлсэн саналыг харуулав.



Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь архидан согтуурах, өссөн орчин соёлын ялгаа, буруу хандлага, төрөл садны нөлөөлийг давамгайлж байна гэж үзсэн

бол хохирох эсрдлийн талаар огт ойлголтгүй байна. Энэ нь Монгол Улсад гэмт хэргийн виктимологийн талаар огт ойлголт байхгүй, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болох нь өөрөөс нь шалтгаалж байна гэж үзэх ойлголт байхгүй болохыг илэрхийлж байна.

Зураг 22. Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэр бүл салалтын байдлын талаар илэрхийлсэн саналыг харуулав.



Судалгаанд оролцогчдын 54.8% нь баривчилах шийтгэлээс шалтгаалж гэр бүл салахад нөлөөлж байна гэж үзсэн бол, нөгөө талаар өрх толгойлсон эмэгтэйчүүдийн олширсон шалтгааны 77 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл гэж үзсэн байна. Энэ нь хохирогчдийн дунд цагдаагийн байгууллагад хандах, зөрчигдсэн эрхээ сэргээн эдлүүлэх, гэмт хэргийн хохирогч дахин боохгүй байх шалтгаан болсон байна.

Гэр бүлийн хүчирхийллийн виктимологийн үндсэн ойлголтыг тодорхойлох судалгаагаар насны хувьд харцангуй тогтсон, амьдрал, гэр бүлийн тушлага бүхий, гэр бүлийн нөхцөл байдлыг дүгнэхүйц туршлагатай, оюун дүгнэлтийг харьцангуй сайн хийж чадах боловсролтой иргэд хамрагдсан. Тэдний гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдлэг хангалттай, аюул занал, төрөл, хэлбэрийн талаарх мэдлэг хангалттай байдаг нь асуулгын үр дүнгээр бүрэн илэрхийлэгдсэн.

Судалгаанд оролцсон иргэдийн гэр бүлийн хүчирхийлэлд хохирсон асуудлыг хүчирхийллийн дам хохирогч болсон, хохирогчийн зүгээс ямар нэгэн буруутай үйдлэл байгаагүй, дийлэнх хувь нь хуулийн мэдлэг дутмаг, гэр бүлээ хадгалж үлдэх эрмэлзлэл, дахин ирэх заналхийлэл, садан төрлийн таарамжгүй харилцаа үүсэхээс эмзэглэн хүчирхийллийн талаар зохих газарт мэдэгдээгүй зэрэг шалтгаанаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн шалтгаанаа илэрхийлсэн байна.

Тэдний дийлэнх хувь нь архидан согтуурах, өссөн орчин соёлын ялгаа, буруу хандлага, төрөл садны нөлөөлийг давамгайлж байна гэж үзсэн бол хохирох эсрдлийн талаар огт ойлголтгүй байна. Энэ нь Монгол Улсад гэмт хэргийн виктимологийн талаар огт ойлголт байхгүй, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болох нь өөрөөс нь шалтгаалж байна гэж үзэх ойлголт байхгүй, хохирогчийн виктимологи эсрдлийг үл тооцон “түүнийг буруутгах” хандлага давамгайлсан гэж үзэх үндэстэй байна.

2.2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогчийн гэр бүл дэх харилцан хамаарал


Шүүхийн мэдээнээс үзэхэд гэр бүлийн гишүүдээ эхнэр 1571, нөхөр 273, хамтран амьдрагч 1261, эмээ 2, төрсөн эх 53, хадам эх 40, төрсөн эгч 29 гэр бүлийн хүчирхийлэлд өртжээ. Үүнээс эмэгтэйчүүд Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн байдлыг авч үзвэл төрсөн хүүхэд 167, үрчилж авсан хүүхэд 7, дагавар хүүхэд 153 байна.

Хүснэгт 8. Шүүхийн сүүлийн 3 жилийн судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын гэр бүлийн хамаарлыг харьцуулсан судалгаа.

Он		2020	2021	2022	3 жилээр
Гэр бүлийн хамаарлаар	Эхнэр	511	604	456	1571
	Нөхөр	51	116	106	273
	Хамтран амьдрагч	644	316	301	1261
	эмээ	0	2	0	2
	Төрсөн эх	20	12	11	53
	Хадам эх	28	6	6	40
	Төрсөн эгч	5	17	7	29
	Төрсөн дүү	17	15	24	56
	Төрсөн хүүхэд	58	49	60	167
	Үрчилж авсан хүүхэд	6	1	0	7
	Дагавар хүүхэд	48	48	57	153
	Бусад	164	167	103	434
Нийт		1572	1353	1131	4046

Гэр бүлийн хүчирхийлэлд хохирсон насанд хүрсэн нийт хохирогчдын 73 хувийг эмэгтэйчүүд, нийт хохирогчдын 327 буюу 8 хувийг хүүхэд эзэлж байна.


Зураг 23. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрсэн хохирогчийг гэр бүлийн хамаарлаар харьцуулсан судалгаа.



Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг хувьд эхнэр 1571 байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Энэ нь нийт 2956 эмэгтэй хохирогчдын 53% болж

байна. Мөн хамтран амьдрагч эмэгтэй нийт эмэгтэй хохирогчдын 43%-ийг эзэлж байна.

Зураг 24. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдийг хамаарлаар нь харьцуулсан байдал.



Бидний түүвэр сонголтоор авсан иргэдийн санал асуулгаар гэр бүлийн хүчирхийллээс үүдэж ямар эрсдэл учирч болох талаар асуухад дараах дүр зураг харагдаж байна. Үүнээс үзэхэд хамгийн санаа зовоосон асуудал нь хүүхэд өнчин хоцрох (45.2%), хүүхдийн сэтгэц, бие махбодод хүнд хор уршиг учрах гэж хариулжээ.

2022 онд Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн иргэний хэргийн тухайд гэрлэлт цуцлахтай холбоотой 3790 хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулбал 967 хэргээр буюу 34.3 хувиар, эцэг тогтоохтой холбоотой 350 хэрэг шийдвэрлэсэн нь 19 хэргээр буюу 5.7 хувиар, эцэг, эх байх эрх хасахтай холбоотой 36 хэрэг шийдвэрлэсэн нь 20 хэргээр буюу 12.5 хувиар, гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцохтой холбоотой 39 хэрэг шийдвэрлэсэн нь 16 хэргээр буюу 69.6 хувиар тус тус өссөн бол хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой 1117 хэрэг шийдвэрлэсэн нь 130 хэргээр буюу 10.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл, дарамт, мөлжлөг нь бие махбод гэмтэх, сэтгэлийн түгшүүртэй, сэтгэц хямралд орох, жирэмслэх амиа хорлохыг оролдох, цаашлаад үхэлд хүрэх хор уршигтай төдийгүй ирээдүйн амьдралын чанарт нь шууд нөлөөлдөг. Бага насны хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой хортой стресс нь тархины хөгжлийг бүр мөсөн доройтуулж, мэдрэлийн системийг гэмтээж буйг тархи судлалын олон судалгаа нотолж, хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нөхөн сэргээх тусламж үйлчилгээг хурдан, үр дүнтэй үзүүлэхийг чухал гэж үзэж байна. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүд цаашид хүн худалдаалах гэмт хэрэг тэр дундаа бэлгийн мөлжлөгийн хохирогч болох эрсдэл өндөр байдаг тул бэлгийн мөлжлөгийн хохирогчдод үзүүлж байгаа үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, стандартчилах хэрэгцээ тулгамдаж байна.

Хүүхдийг үл хайхрах талаар судалгаа авахад нийт судалгаанд оролцогч нарын 32 хувь нь ажил ихтэй болохоор гэр бүлдээ цаг гаргаж чаддаггүй, 26 хувь нь амралтын өдрүүдээр л цаг гаргаж чаддаг, 14 хувь нь хөдөө орон нутагт ростероор ажилладаг болохоор маш бага цаг зарцуулдаг, 28 хувь нь өдөр бүр цаг гаргадаг гэж хариулсан

байна. Дээрх судалгааны асуулгад оролцсон оролцогч нарын 72 хувь нь гэр бүлийн өдөр тутмын амьдралд оролцож чадахгүй ажил эрхэлж цалин, орлого олж байгаа сайн талтай боловч энэ үл хайхрах хандлага байдал нь гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх нэг шалтгаан нөхцөл болж байна.

2.3. Хүүхдийг үл хайхрах хүчирхийллийн судалгаа

Хүүхдэд өөрийгөө хамгаалах чадваргүй, харин бусдаас хайр, халамж анхаарал шаардагддаг. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн олон хэлбэр байдаг бөгөөд үүнээс бие махбодын болоод сэтгэл санааны хүчирхийллүүд нь түгээмэл илэрдэг. Харин “үл хайхрах” гэсэн хэлбэр нь хүүхдүүдэд мөн л түгээмэл байдаг ч энэ талаар тавих хяналт чамлалттай бага байгаа нь нийгмийн харилцаа, хотжих үйл явцтай холбоотой юм.

Үл хайхрах (neglect-үл хайрах, үл тоомсорлох, үүргээ биелүүлэхгүй байх) хүчирхийлэл гэдгийг нь хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэнд, хөгжил боловсрол, хайр халамж эдлэх, аюулгүй байдлыг нь хангах зэрэг суурь хэрэгцээг нь гачигдуулсны улмаас хүүхдэд гэм хор учруулсан болон учруулахаар завдсан, эсхүл мэдсээр байж хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйг ойлгоно¹ гэж тодорхойлсон бол “хүүхдийн бие махбодын болон сэтгэл зүйн чадавхдаа хүрэхэд нь саад учруулж буй үйлдэл”² гэж онолын хувьд тайлбарлажээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “...хүсэл зоригийн эсрэг ... үл хайхрах, ... болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг сэтгэл санааны хүчирхийлэл гэнэ”³ гэж, Хүүхдэд хамгааллын тухай хуульд⁴ зорилтыг тодорхойлохдоо “хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” тодорхойлсон байдаг. Хүүхдийн Эрхийн тухай Конвенц болон Монгол Улсын Хүүхдийн Эрхийн хуульд хүүхэд Эсэн мэнд амьдрах, Хөгжих, Хамгаалуулах, Оролцох эрхтэй бөгөөд “эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээг авна”⁵ гэр бүл дэх хүүхэд хамгааллын асуудлыг тодорхойлсон.

Эцэг эхчүүд ажлын шаардлагаар хүүхдээ олон цагаар үлдээх нь нийтлэг байдаг. Залуу эцэг эхчүүд тодорхой шаардлагаар уул уурхайд ажиллах, урт цагаар ажиллах, 24 цагаар ажилладаг зэрэг ажлууд байдаг. Өглөө гараад орой ирээд л унтчихдаг ийм тохиолдлууд байна. Иймд ялангуяа бага насны хүүхдүүд хоол унд, тодорхой дулаан байр, хувцас зэрэг зүйлсээр гачигдах нь элбэг. Өсвөр үе буюу дунд насны хүүхдүүд хараа хяналт сулрахаар олон цаг гадуур тэнэх, олон цагаар тоглоомын талбайд тоглох, утас компьютерын тоглоом тоглох. Ахлах насны хүүхдүүдийн хувьд аливаа гаж муу зуршилтай хүмүүст уруу татагдах, сургуулиасаа хөндийрөх асуудлууд тулгардаг. Иймд эцэг эхчүүд хүүхдүүдээ цагийн үечлэлтэйгээр, цагийн хуваариар байлгах хяналт тавьж байх

¹ А.Батхишиг нар. Хүүхдийг Ивээх Сан "Хүүхэд хамгааллын хамтарсан баг". Уб. 2016

² Дети и насилие. Материалы международного семинара "Права ребенка: проблемы насилия над детьми". - МН.: МТС-Пресс, 2000 - 203 с.

³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай. 2017. Төрийн мэдээлэл №5

⁴ Хүүхэд хамгааллын тухай. 2016. Төрийн мэдээлэл №9

⁵ Хүүхэд хамгааллын тухай. 2016. Төрийн мэдээлэл №9

хэрэгтэй. Тодорхой найз нөхөд, ямар хүрээлэлд байна, цахим орчинд ямар хүрээлэлтэй байна, ямар хүмүүстэй уулзаж байна гэх зэрэг хүүхдийнхээ талаар мэдээлэлтэй байх нь чухал.

Багштай хийсэн ярилцлагаас

Сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх үүднээс хүүхдийн хүчирхийлэл, тэр дундаа үл хайхрах хүчирхийлэл нь үргэлж хүчирхийллийн объектын сөрөг туршлага дагалддаг. Тодруулбал, хүүхдүүдэд сэтгэл зүйн хувьд өвдөлт, сөрөг сэтгэл хөдлөл (айдас, үзэн ядалт, бухимдал, стресс, цочрол гэх мэт) болон хувь хүний болон нийгмийн хөгжилд ихээхэн хохирол учруулдаг. Бүхий л төрлийн хүчирхийлэл нь түрэмгийлэлтэй шууд холбоотой (aggressio – Латин хэлнээс дайралт) байдаг бөгөөд, үзэн ядалт, уур хилэн үүсэж, уур хилэнгийн сэтгэл хөдлөлийг илэрхийлэх идэвхтэй хэлбэр нь хүн эсвэл объектод хохирол учруулах замаар илэрдэг¹ талаар судлаачид цохин тэмдэглэжээ.

Судлаач Д.Нямбат “хүүхдийн эрүүл мэндэд хохирол учраагүй байсан ч сэтгэл санааны хохирол учирсан байхыг үгүйсгэхгүй юм. Иймд сэтгэл зүйчийн онош, дүгнэлт нь гэмт хэргийн үйл баримтыг давхар нотлох, сэтгэл заслын эмчилгээний хэлбэр, хугацаа, төлбөр зардлыг тодорхой болгох зэрэг ач холбогдолтой ажиллагаа хангалттай хийгддэггүй²” гэж дүгнэсэн нь үндэслэлтэй. Хүүхдийн сэтгэл санааны хохирол дотор “үл хайхрах” үйлдэл илэрч гарах боломжтой бөгөөд нарийвчилсан судалгаа дутаж байна.

Удаан хугацаагаар хүүхдийг орхиж явсан үед тухайн хүүхдийн хараа хяналт сулраад ирэхээр цахим гэмт хэрэгт орох эрсдэл өндөрсдөг, цахимаар таньж мэдэхгүй хүмүүстэй холбогдож тоглох, гадуур удаан хугацаагаар тэнэх, тоглоомын талбайд удаан тоглох зэрэг тэр хэмжээгээр хүүхдэд үүсэх эрсдэл өндөр болж байдаг. Энэ зүйлүүдийг эцэг эхчүүд тэр болгон мэддэггүй. Ер нь бол тодорхой хугацаанд хүүхдээ эргэж, хяналт тавьж, ярилцаж хаана байгааг нь мэдэж, тодорхой хугацаанд үүрэг даалгавар өгч байх шаардлагатай.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг шүүхээс гэм буруутайд тооцож, ял шийтгэл оногдуулж буй байдлыг зүйлчлэлийн тухайд авч үзвэл “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон” гэх үндэслэлээр 111 хүнд буюу нийт судалгаанд хамрагдсан хэргийн 61 хувьд, “Харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан” үндэслэлээр 37 буюу 20,3 хувь, “Хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан” үндэслэлээр 1 буюу 0,5 хувьд ял шийтгэл оногдуулсан³ нь “үл хайхрах” үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ойлголтгүй, тэдгээр нь нийтлэг ял шийтгэл оногдуулах үндэслэл дотроо дарагдсан, давхардсан, нуугдмал хэлбэрээр төдийлөн дурдагдахгүйгээр явж байгааг харуулж байна.

¹ Гильманов Сергей Амирович, «Профилактика жестокого обращения с несовершеннолетними» -М. 2019. С15

² “Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас хүүхэд хохирсон эсэх судалгаа 2020-2022.03 сар” Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн хяналтын прокурор Д.Нямбат

³ Дурдсан бүтээл

Сэтгэл санааны дарамт учруулах, эдийн засгийн, бэлгийн эрх чөлөө , бие махбодод халдсан зэрэг хэлбэр нь давхардсан тоогоор илэрхийлэгдсэн үзүүлэлт юм. Тухайлбал эдийн засгийн хүчирхийллийн тохиолдолд хохирогчид давхар үл хайхрахаас үүдэлтэй сэтгэл санааны дарамт бий болгодог гэсэн үг юм. Гэр бүлийн хүчирхийлэл нь дан ганц хэлбэрээр үйлдэгддэггүй хоорондоо хамааралтай байдаг байна.


Эцэг эх эсвэл асран хамгаалагч нь анхан шатны хэрэгцээг хангах нэн шаардлагатай, үйлчилгээ, үйл ажиллагаагаар гачигдуулж нэн ялангуяа хайраар дутаах, яриаг нь сонсохгүй байх, харилцан ярихгүй байх, нууцыг нь задруулах, доромжлох, бусадтай харьцуулах гэх мэт үйлдлүүд нь хүүхдийг сэтгэл санааны дарамтад оруулдаг. Харамсалтай нь энэ нь нотлоход хамгийн хэцүү хэлбэр бөгөөд ийм төрлийн хүчирхийллийн хэргүүд ихэвчлэн нуугдмал байдаг.

Нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаас

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн дуудлага мэдээллээс шүүж үзэхэд 2020 онд 111.0 мянга, 2021 онд 26.503 дуудлага ирснээс үл хайхрах төрлийн 710 дуудлага бүртгэсэн¹ байна. Гэтэл үл хайхрах төрлийн 710 дуудлагаас гэмт хэргийн шинжийг агуулж дээр дурдсан ял шийтгэл оногдуулах үндэслэл болоогүй нь үл хайхрахын хувьд насанд хүрээгүй этгээдээс гэрчийн мэдүүлэг авах эсхүл Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан гэр бүлийн гишүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхээ эдэлсэн зэрэгтэй холбоотойгоор зөвхөн гэрчийн статус дор явагдаж байгааг илэрхийлнэ.

2023 оны эхний 9 сард хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээний төвд 78298 дуудлага ирснээс 2022 дуудлага үл хайхрах хүчирхийлэлтэй, 2327 дуудлага сэтгэл санааны хүчирхийлэлтэй холбоотой байна. Харамсалтай нь 2020-2022 онд шүүхээр хүүхдийн эсрэг гэр бүлийн үл хайхрах хүчирхийллийн нэг ч хэрэг хянан шийдвэрлээгүй байна.

Зураг 25. Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагын сүүлийн 3 жилийн тайлан мэдээнд хийсэн судалгаа.



¹Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв (2021 он) цахим эх сурвалж: <https://108.mn/academics/creche-center-2-2/>

Хүүхдийн тусламжийн 108 дуудлагын утсанд ирсэн дуудлагын 38% хувийг бие махбодын хүчирхийлэл, 28% хувийг сэтгэл санааны хүчирхийлэл, 25% хувийг үл хайхрах хүчирхийлэл эзэлж байна.

Үл хайхрахын хэлбэрийг хэд хэдэн төрөлд хувааж авч үздэг олон улсын чиг хандлага байна. Тухайлбал, 1) Бие махбодын хувьд үл хайхрах хүчирхийллийг хүүхдийн наад захын хэрэгцээ болох хоол хүнс, хувцас хунар, орон байраар дутаах, хүүхдэд согтууруулах ундаа, хор, мансууруулах бодис, муудсан хоол, зохисгүй зүйл санаатайгаар, хүчээр идүүлэх. 2) Эрүүл мэндийн хувьд үл хайхрах хүчирхийллийг Хүүхдийг зайлшгүй хамрагдах эмнэлгийн үйлчилгээнд хамруулахгүй, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахгүй, нас сэтгэхүйн хөгжлийн хоцрогдолд санаа тавихгүй байх, биеийн зовуурь шаналгааг тоохгүй, эмчлүүлэхгүй, урьдчилан сэргийлэхгүй байх. 3) Сэтгэл санааны хувьд үл хайхрах хүчирхийллийг хүүхэдтэй хол хөндий харилцах, эсхүл харилцахгүй байх, хайр халамжаар дутаах, хүн гэж тоохгүй байх, хүсэл сонирхлыг нь няцаах, 4) Боловсролын хувьд үл хайхрах хүчирхийллийг хүүхдийн сурч хөгжих боломжийг хаах, хязгаарлах, хичээлийн хэрэгслээр хангахгүй байх, хичээл таслуулах, сургууль завсардуулах, хөдөлмөр эрхлүүлэх 5) Хүүхдийг эрсдэлд оруулах нөхцөл бүрдүүлэх хүчирхийллийг Бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхих, аюултай нөхцөл байдлыг мэдсээр байж, хүүхдийг хамгаалахаас зайлсхийх¹ гэж мэргэжилтнүүд тодорхойлсон бол орчин үед хүүхдийг цахим орчинд хараа хяналтгүй байлгах нь хүчирхийллийн нэг хэлбэр болж байна.

Иргэн А нь фейсбүүкийн хуурамч аккаунт үүсгэн, өсвөр насны 84 охинтой танилцан харилцаа тогтоож, тухайн охидыг сүрдүүлэх, ятгах, гуйх зэрэг байдлаар өөрсдөөр нь нүцгэн зураг, бичлэгийг нь хийлгүүлэн авч улмаар уулзаж, тухайн дүрс бичлэгийг нь олон нийтэд түгээнэ гэж сүрдүүлж, барьцаалж бэлгийн харьцаанд орсон гэмт хэргийг энэ дөрөвдүгээр сард Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс илрүүлэн шалгаж байна².

ЭЦА-ны мэдээлэл

Улсын хэмжээнд энэ төрлийн цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэрэг 2015-2021 онд 101 бүртгэсэн бөгөөд Цахим технологийн хөгжил, нийгэм цаг үеийн байдал, эдийн засгийн хямрал болон эцэг эхчүүдийн бага насны хүүхдэдээ тавих хараа хяналт, анхаарал халамж сул, хүүхдийнхээ юу хийж хэнтэй нөхөрлөж байгаад санаа тавьдаггүй, гэр бүлийн хүрээнд архидалт хавтгайрсан, гэр бүл салалт нэмэгдсэн, гэрлэлт цуцлалтын дараа хүүхдээ асрамжилж байгаа эцэг эх болон хойд эцэг эх нь хамгаалах үүргээ биелүүлдэггүй зэрэг шалтгааны улмаас бага, өсвөр насны хүүхэд сэтгэл санааны болон бие махбодоороо энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсоор байна. Тиймээс эцэг эхчүүд хүүхдийнхээ өмнө хүлээсэн хариуцлага, мэдлэг, анхаарал халамжаа нэмэгдүүлэх шаардлагатай байгаа талаар мэргэжилтнүүд³ анхааруулж байна.

Үл хайхрах хүчирхийллийн хэлбэрүүдийг зодох, санаатайгаар бие махбодын өвдөлтийг үүсгэдэг нөхцөл, хор хөнөөл учруулах үйлдлийг өдөөхөд биеийн хүч

¹ <https://familycenter.mn/> - Гэр бүлийн хүчирхийллийн мэдээлэл, зөвлөгөө, тусламжийн төв

² ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлэл

³ ЦЕГ-ын ЭЦА-ны кибер гэмт хэрэг мөрдөх хэлтсийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Тэмүүлэнгийн олон нийтэд өгсөн мэдээлэл. 2022.04.07

хэрэглэх, доромжлох, эрх чөлөөг нь хасах, хүүхдийг аюултай орчинд зориудаар үлдээсэн тохиолдлыг хэлнэ¹ гэж тайлбарлажээ.

Үл хайхрахын үйлдлийн шинжийг виктимологи судлалын хувьд дэлгэрүүлэн авч үзэх шаардлага гарч байна. Үл хайхрах хүчирхийллийн хохирогчийг дээр дурдсан 4 төрөлд үндэслэн дараах байдлаар авч үзэх шаардлагатай. Үүнд:

1. Бие махбодын хайхрамжгүй байдал: Хүүхдийн зохих ёсны аюулгүй байдлыг хангахгүй, хараа хяналтгүй байх. Хүүхдийн хоол хүнс, хувцас, орон байр зэрэг үндсэн хэрэгцээг хангахгүй байснаар хүүхэд бие махбодын үл хайхрах хүчирхийлэлд өртсөн байна гэж үзнэ. Эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдэд тавих хараа хяналтаа сулруулсны улмаас компьютер тоглоомд донтох, түлэгдэх, цонхоор унах, авто осолд өртөх ноцтой хэлбэрт шилждэг. 6 настай эгчээр нь 2 настай дүүг нь харуулдаг гэтэл дүүгээ харах чадамж тэр хүүхдэд байхгүй учир алдаа гаргах эрсдэл маш өндөр гэтэл үүнийг эцэг эхчүүд бид ингэж л хүн болсон гэж үзэх нь байдаг хандлага байдаг. Гэтэл хүүхдийн осолд өртсөн, өндрөөс унасан, хоол тэжээлийн дутагдалд орсон зэрэг нь эцэг, эх, асран хамгаалагчийн буруутай үйлдлээс болдог.

2. Боловсрол олгоход анхаарахгүй, хайхрамжгүй ханддаг байдал: Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийн боловсрол эзэмших боломж, нөхцөлийг хангаж өгөхгүй байх нь хүүхдийг боловсролын үл хайхрах хүчирхийлэлд өртөж байна гэж үзэх үндэслэл гарч ирнэ.

3. Сэтгэл хөдлөлийн хайхрамжгүй байдал: Хүүхдийнхээ сэтгэл зүй, нийгмийн харилцаанд хяналттай байж анхаарал хандуулахгүй байснаар олон төрлийн эрсдэл, сөрөг үр нөлөө гардаг. Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд ихэвчлэн үл тоомсорлож, гологдсон, заналхийлсэн, тусгаарлагдсан мэт санагддаг байна. Тэдний эцэг эх эсвэл асран хамгаалагч нь айдастай орчныг бүрдүүлж, хүүхдийг хөгжүүлэхэд шаардлагатай анхаарал, нийгмийн харилцаа, сэтгэл санааны дэмжлэгийг үгүйсгэдэг. Гэтэл зөрчил шалган шийдвэрлэх болон мөрдөн шалгах ажиллагаагаар уг үйлдлийг нотлох явдал хангалтгүй, практикт үл тоомсорлодог нь хамгийн хэцүү хэлбэр бөгөөд ийм төрлийн хүчирхийллийн хэргүүд ихэвчлэн нуугдмал байдаг. Улмаар яриаг нь сонсохгүй байх, харилцан ярихгүй байх, нууцыг нь задруулах, доромжлох, хайр халамж мэдрэхгүй байх гэх мэтээр сэтгэл санааны хүчирхийлэлд өртдөг байна.

4. Эрүүл мэндийн хайхрамжгүй байдал: Хүүхэд шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө хэрэгтэй. Эдгээр тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчид нь хүүхдэдээ зохих хэмжээний эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж чадахгүй байх үед эрүүл мэндийн үл хайхрах хүчирхийлэлд өртдөг байна².

Монгол Улсад дийлэнх эцэг эхчүүд “Би багадаа ингэж л өссөн”, “Хүүхдэдээ багаас нь юм үзүүлнэ”, “Эрэгтэй хүүхдийг чанга гараар өсгөх ёстой”, “Би хүүхдээ яахыгаа өөрөө мэднэ” хэмээн х өнцгөөс хандах нь түгээмэл. Хүүхдийг багаас нь шим тэжээлгүй хоол идүүлж, тэжээлийн дутагдалд оруулах, улиралд нь таараагүй хувцас өмсүүлэх, бэлэн бүтээгдэхүүнээр хооллох, гар утас, телевизээр аргацаах, цагт нь унтуулахгүй байх нь түүний эрүүл мэнд, амьдралын хэмнэлд насан туршид нь хор

¹ Маханько А. Предупреждение насилия и пренебрежения детьми: исследования и эффективные решения, базирующиеся на междисциплинарном и межсекторном подходе // Социальная работа. - 2008.-№4. —с.5-9.

² <https://familycenter.mn/> - Гэр бүлийн хүчирхийллийн мэдээлэл, зөвлөгөө, тусламжийн төв

хохирол учруулж байгаа нь үл хайхрах хүчирхийллийн түгээмэл хэлбэр юм. Хүүхдийн эцэг, эх, хамтран амьдрагчаар дамжсан гэр бүлийн хүрээний дам харилцаа үүсэн л бол түүнд тодорхой эрх үүсэж, тухайн субъект хуулийн дагуу хариуцлага хүлээдэг.

"2023 оны гуравдугаар сарын 6-7-нд шилжих шөнө Баянгол дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах хотхоны дугаар тоотод гурван настай, эрэгтэй Б нь бусдад зодуулан гуравдугаар сарын 8-ны 09:40 цагийн орчимд ГССҮТ-д ухаангүй байдалтай ирж, эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж байна. Шалгалтын явцад Л-ийн хамтран амьдрагч Э нь 3-6 насны хүүхдүүдийг гэртээ харж үлдэхдээ гурван настай Б-г зодсон байж болзошгүй байдал урьдчилсан байдлаар тогтоогдсон. Гурван настай хүүг төрсөн эх Л түүний хамтран амьдрагч Э нар эмнэлгийн байгууллагад хүргэсэн байна. Л-ийн хамтран амьдрагч Э нь хүүг эмнэлэгт хүргэсний дараа зугтсаныг цагдаагийн байгууллагаас шуурхай эрэн сурвалжилж, олж тогтоон хойшлуулшгүйгээр баривчлан цагдан хорих арга хэмжээ авах саналыг прокурорын байгууллагад хүргүүлэн мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлж байна¹.

Нээлттэй эх сурвалжаас авсан мэдээлэл

2.4. Контент анализ судалгааны үр дүн

Судалгааны баг цахим орчинд гэр бүл, хүүхэд хүчирхийллийн гэмт хэргийн гаралт, түүний шалтгаан нөхцөлийн талаар гарсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх зорилгоор түүврийн аргаар сонголт хийсэн 58 сайтын 44 нийтлэл, 17 сурвалжилга, 16 ярилцлага, мөн эдгээр мэдээлэлд хандсан 143854 сэтгэгдлийг контент анализын аргаар боловсруулж, үүнээс сонгон авсан нийт 80 мэдээллийн, түүврийн аргаар судалбал зохих дүн сэтгэгдэлд шинжилгээ хийсэн. Нийгмийн сүлжээний онцлог зарим онцлог болох нийгмийг цочроосон хэрэг, үйл явдалтай холбоотойгоор флэйминг (flaming) буюу “маргааны хажуугаар маргаан” дэгдээх², троллинг (trolling) буюу нийгмийн сүлжээнд санаатайгаар өдөөн хатгах арга ажиллагаа³ ихээхэн хэрэглэгддэг учраас мэдээллийн үнэн зөвийн магадлалыг нэмэгдүүлэх зорилгоор эерэг ба сөрөг мэдээллийн хандалтын харьцааг тэнцвэртэйгээр авч үзсэн болно.


Түүврийн аргаар сонгон авсан гэр бүл болон хүүхэд хүчирхийллийн гэмт хэргийн тухай 80 мэдээ, нийтлэлд иргэдийн хариу үйлдэл (reaction)-ийг харьцуулан үзэхэд хүүхэд хүчирхийллийн мэдээлэлд хандалт хийсэн иргэдийн тоо гэр бүлийн хүчирхийллээс 3 дахин их буюу нийт хандалтын 78% хувийг эзэлж байв. (Зураг 1)

¹ <https://ikon.mn/> Мэдээлийн сайт

² Интернет-форум, чат, нийгмийн сүлжээнд мэдээлэл солилцохдоо маргааны анхдагч шалтгаанд хамааралгүй асуудлаар үгээр давшлах, доромжлох замаар хийх.


³ Нийгмийн сүлжээнд хууран мэхлэх, хагарал үүсгэх, зүй бус үйлдэл хийхэд турхирах үйл ажиллагааг хэлнэ.

Зураг 26. Нийт хандалтыг харьцуулсан байдал.



Дээрх мэдээ, нийтлэлд бичсэн иргэдийн 143854 сэтгэгдлийг гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хүчирхийлэл гэсэн төрлөөр ангилан үзэхэд 112144 сэтгэгдэл буюу 88% нь хүүхэд хүчирхийллийн гэмт хэрэгтэй холбоотой мэдээ, мэдээлэлд, 22% нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэлд тус тус сэтгэгдэл бичжээ.

Зураг 27. Иргэдийн сэтгэгдлийг харуулсан байдал.



Гэр бүлийн хүчирхийллийн мэдээ, ярилцлага, контентод иргэдийн бичсэн сэтгэгдлээс гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг хэрхэн дүгнэж байгааг судлах зорилгоор 31710 сэтгэгдлийг дараах нийтлэг шалгуураар ангилан үзлээ.

Өнгөрсөн ням гарагт гурван хүүхэд, эхнэрийнхээ амийг хөнөөгөөд, өөрийгөө егүүтгэсэн аймшигт хэрэг СХД-ийн 26 дугаар хороонд гарсан талаар манай сайт мэдээлсэн билээ. Тодруулбал, тус хороонд суух 39 настай Х гэгч өөрийн 4, 6, 11 настай хүүхдээ, эхнэрийнхээ хамт хөнөөгөөд, өөрийн амиа егүүтгэсэн. Хэргийн газраас 16 настай дагавар охин зугтан гарч, цагдаад дуудлага өгсөн ч хэргийн газарт цагдаа албан хаагчдыг ирэх үед гэр бүлийн дөрвөн хүн аль хэдийн нас барсан байжээ.

Талийгаач эмэгтэй буюу Х-ийн эхнэр Нарангийн хогийн пүү, захиргаа хоорондын автомашины замын үйлчлэгч байсан бөгөөд хамт олон нь хэргийг өчигдөр мэдэж, өнөөдөр ар гэрийнхэнтэй нь уулзсан гэнэ. Хамт ажилладаг байсан 40 орчим насны эмэгтэй “Санаанд багтамгүй аймшигтай хэрэг гарлаа. Үг дуу цөөтэй болохоор ар гэрийнхээ тухай элдэв зүйл ярьдаггүй байсан. Нөхөр нь хөдөө явж, олдсон ажил хийдэг, хааяа барилга дээр ажилладаг байсныг нь мэднэ. Гэхдээ гэртээ цалингаа авчирдаггүй гэж хэлж байсан. Хардаад хэцүү байна, салах юм сан гэж ч ярьдаг байсан.

Өвөл түлшинд нэмэр болно гээд зам цэвэрлэж хураасан самрын ясыг хүртэл гэр лүүгээ аваад явдаг, амьдралаа болгох гэж л зүтгэдэг нэгэн байсан. Бидний ажил хүнд болохоор хааяа ууц нуруугаар өвдлөө гээд чөлөө авдаг байсан. Ирэх намар 6 настай хүүхэд нь сургуульд орох болохоор хичээлийн бэлтгэлийг нь хангах талаар ч ярьж байсан нь санаанд ороод хэцүү байна” хэмээн хоолой зангируулан хэллээ¹.

Нээлттэй эх сурвалжаас авсан мэдээлэл

Тус мэдээлэлд хандсан иргэдийн сэтгэгдлийн 87% нь амь хохирсон 3 хүүхдийг өмгөөлсөн, өрөвдсөн хандлагатай байсан бол 13% нь талийгаач эмэгтэйн талаар харамссан сэтгэгдэл илэрхийлжээ. Үүнээс үзвэл хүчирхийллийн хохирогч нь хүүхэд байвал иргэдийн сөрөг сэтгэгдэл, үзэн ядалт нэмэгддэг байдал ажиглагдаж байна.

Төв аймгийн нутаг дэвсгэрт 2021 оны аравдугаар сарын 23-ны шөнө иргэн С гэгч нь архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэртээ ирж хэрүүл маргаан үүсгэн, гэр бүлийнхэндээ агсам тавьж, биед нь халдах үед эхнэр Х түүний биед нийт есөн удаа хутгалж, толгой тус газарт таван удаа хурц мохоо биетээр цохиж амь насыг нь хохироосон онц ноцтой хэргийн тухай бид өмнө мэдээлсэн.

Тэгвэл эх сурвалжийн мэдээлж буйгаар амь хохирогч С нь өөрийн эхнэр, хүүхдүүдээ олон жилийн турш гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байжээ. Аргалын ард нуугдсан эмэгтэй зодооны чимээгээр гэрт оржээ. Харин гэрт түүний охин нь дөрвөн настай хүүгийн хамт байсан байна. Аавыгаа согтуу байгааг харсан охин, хүүгээ аваад гэрээс гарах гэтэл талийгаач С нь ална хэмээн сүрдүүлж, улмаар зодож эхэлжээ.

Охин болон зээ хүүг нь зодож байгаа чимээг гаднаас сонссон ээж нь төмрийн зүйл бариад гэрт орсон гэх. Үүнийг харсан эхнэр Х нь нөхрийнхөө толгой руу барьсан зүйлээрээ цохисон байна. Улмаар биеэ хамгаалах зорилгоор нөхрийнхөө биеийн хэд хэдэн хэсэгт хутгалж, амийг нь хөнөөсөн аж².

Нээлттэй эх сурвалжаас авсан мэдээлэл

Харин тус хэргийн хохирогч насанд хүрсэн эрэгтэй байсан бөгөөд иргэдийн сэтгэгдлийн 95% нь хохирогчийн талаар сөрөг хандлагатай, үлдсэн 5% нь амь хохирогчийг өмгөөлсөн хандлагатай байна. Үүнээс үзвэл гэр бүлийн гэмт хэргийн хохирогч насанд хүрсэн эрэгтэй хүн байвал иргэдийн сэтгэгдэл өрөвдөж хайрлах бус эрэгтэй хүнийг буруутгах, “өөрөөсөө болсон” гэх хандлагатай байдал ажиглагдаж байна.

Өнгөрөгч есдүгээр сарын 1 буюу хичээлийн шинэ жилийн баярын өдөр өсвөр насны хүүхэд нэгнээ хүчирхийлсэн хэрэг бүртгэгджээ.

Тодруулбал, 12 настай охин, 15 настай хүүтэй Фейсбүүкээр танилцаж, улмаар хүү охиныг ахынхаа эзэнгүй байранд авчирч, хүчээр бэлгийн харьцаанд орсон гэнэ.

Өдгөө хэргийн шалгалтын ажиллагаа үргэлжилж байна. Иймд өсвөр насны хүүхдэдээ тавих анхаарал, хараа хяналтыг сайжруулах, цахим орчны зөв хэрэглээнд нь анхаарал тавиарай³.

Нээлттэй эх сурвалжаас авсан мэдээлэл

Тус хэргийн хохирогч 12 настай охины талаар иргэдийн сэтгэгдлийг судлан үзэхэд 63,5% нь өмгөөлсөн, харин 36,5% нь буруутгасан хандлагатай байна. Үүнээс үзэхэд өсвөр насны эмэгтэй хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон тохиолдолд иргэдийн сэтгэгдэл хуваагдах хандлагатай буюу хохирогчийг буруутгах хандлага ажиглагдаж байна.

¹ <http://www.asuudal.mn/more/790>

² <https://eguur.mn/260375/>

³ <https://eguur.mn/134179/>

Жирэмсэн эхнэрээ зодож, нэг настай хүүхдээ гудамжинд орхиод зугтсан этгээдийг эрэн сурвалжилж байгаа талаар цагдаагийн байгууллагаас мэдээллээ.

Тодруулбал, 2019 оны дөрөвдүгээр сарын 15-ны өдрийн 00 цаг 54 минутад Цагдаагийн байгууллагын 102 дугаарт “Манай нөхөр намайг зодоод нэг настай хүүхдээ нүцгэнээр нь хувцсандаа ороогоод гараад явчихлаа” гэх дуудлагыг цагдаагийн байгууллага хүлээн авч 13 минутын дараа хэргийн газарт очиход Э гэгч нь 3 сартай жирэмсэн эхнэр Т-г зодож, хоолойг нь боож унаган улмаар нэг настай охиноо гудамжинд орхин зугтаж алга болжээ.

Цагдаагийн алба хаагчид хохирогч Т-г эмнэлгийн байгууллагад яаралтай хүргэн өгч, охиныг өвөөгийнх нь асрамжид үлдээн Э гэгчийг ойр орчимд эрэн сурвалжлахад олдоогүй болно. Одоогоор эрэн сурвалжилж байгаа юм байна¹.

Нээлттэй эх сурвалжаас авсан мэдээлэл

Иргэдийн сэтгэгдэл 100% холбогдогчийг буруутгасан хандлагатай байсан бөгөөд нийт сэтгэгдлийн 36% нь “ийм харгис хүчирхийлэгчийн нэрийг зурагтай нь мэдээлэл хийж баймаар байна, таарвал болгоомжилж байх хэрэгтэй шүү дээ” гэх агуулгатай байна.

“NTV” телевиз өчигдөр 10 жилийн турш прокурор нөхрийнхөө хүчирхийлэлд зовсон нэгэн бүсгүйтэй уулзаж ярьсан нь олны анхаарлыг татаж байна. Хамгийн аймшигтай нь прокурор нөхөр нь энэ талаар цагдаагийн байгууллагад мэдэгдэх юм бол “Би чамайг амиа хорлосон болгоод алчхаж чадна шүү” гэх мэтээр сүрдүүлдэг байсан тул энэ олон жил тэвчиж ирсэн байна.

Хүчирхийлэгч нөхөр нь эхнэртээ эхэндээ согтуугаар гар хүрдэг байсан ч сүүлдээ шалтгаангүйгээр хардаж, зоддог болжээ. Тэр ч бүү хэл хүүхдүүдээ ч шөнөөр зодож, тамлах үйлдэл гаргадаг аж. Шаналж зовсон эхнэр нь өөрийгөө хамгаалахын тулд нөхрийнхөө аминд хүрэх, эсвэл өөрөө ч алуулж мэдэх эрсдэл бий болсон учраас бүсгүй анх удаа цагдаагийн байгууллагад дуудлага өгч, хүчирхийлэгчийг олонд илчилсэн энэ аж. Харин сэжигтэн “Би байнга хүчирхийлэл үйлдээгүй. Наадах чинь өөрөө нууц амрагтай учраас зоддог” хэмээн хэнэггүйхэн ярьж байна².

Нээлттэй эх сурвалжаас авсан мэдээлэл

Тус мэдээлэлд иргэдийн бичсэн сэтгэгдэл 100% холбогдогчийг буруутгасан хандлагатай байгаагаас үзвэл гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн холбогдогч нь төрийн албан хаагч, дээд боловсролтой хүн байх тохиолдолд иргэдийн сөрөг хандлага, үзэн ядалт нэмэгдэж байна.

Өвөрхангай аймгийн 1-р цэцэрлэгийн багш нар хүүхдийн эрхийг ноцтой зөрчжээ. Тодруулбал Арвайхээр сумын 1-р цэцэрлэгийн багш Ц, Г нар нь 2 настай хүүхдийг сандал дээр суулган скочоор сандалтай нь хүлж, 30 гаруй минут суулгаж, хүүхдийн эрхийг ноцтой зөрчсөн зөрчил камерын хяналтаар илэрчээ.

Сандал дээр хүлүүлсэн нялх хүүхэд өмдөндөө баасан, мөн хүлээсээ тайлуулах гэж аргаа баран уйлж, тийчилж байхад хоёр багш тоосон шинжгүй 30 гаруй минут дэргэд нь байгаад байгаа нь мөн камерын бичлэгт үлджээ.

30 гаруй минут болсны дараа цэцэрлэгийн арга зүйч орж ирж хүүхдийг сандлаас салгаж авсан ба хэрэв хүн орж ирж аваагүй бол ахиад хэчнээн цагаар ингэж суулгах байсныг хэлж таашгүй юм.

Хүүхдийн эрхийг ноцтой зөрчсөн 2 багшийг тус цэцэрлэгийн удирдлагын зүгээс ажлаас халах арга хэмжээ авсан байна³.

Нээлттэй эх сурвалжаас авсан мэдээлэл

Тус мэдээлэлд иргэдийн 37% нь багшийн ур чадвар, цалин хангамж, багшид тавигдах шаардлага зэрэг боловсролын салбарын бодлогод чиглэсэн шүүмжлэлтэй сэтгэгдэл үлдээсэн байна. Тухайлбал, “хүссэн сургуульдаа тэнцэж чадаагүй нь багш болдог болсон”, “цэцэрлэг, бага ангийн багшийн цалинг өндөр болгож, тэдэнд тавигдах

¹ <http://vip.chuhal.mn/r/42077>

² <http://tovch.mn/n/12y>

³ <http://tovch.mn/n/17y>

шаардлагаа нэмэгдүүлэх хэрэгтэй”, “багшаар ажиллах хүний сэтгэцийг шалгаж баймаар байна” зэргээр хувь багшийн талаарх сөрөг сэтгэгдлээс илүүтээ боловсролын салбарын бодлого дутагдаж байгааг шүүмжилсэн байна. Иймд суурь хүмүүжил тавигддаг, хүний хөгжлийн анхан шат болох цэцэрлэг, бага ангийн боловсролын бодлогыг сайжруулах шаардлага нэн тулгамдсан асуудал болжээ.

4 настай охин гэртээ өлсөж сульдсан байдалтай олджээ¹.

Нээлттэй эх сурвалжаас авсан мэдээлэл

Тус мэдээнд 32 мянган хүн хариу үйлдэл үзүүлж, 1,9 мянган хүн сэтгэгдэл бичиж, 1,9 мянган хүн мэдээг түгээж хуваалцсан байна. Иргэдийн сэтгэгдэл 100% хохирогч хүүхдийг өмгөөлж, хайрласан сэтгэгдэл илэрхийлсэн бөгөөд тэдний 57% нь эцэг, эх байх эрхийг хасах тухай санал бичиж, үзэл бодлоо илэрхийлжээ. Үүнээс үзвэл эцэх эхийн буруугаас бага насны хүүхэд хохирсон гэмт хэрэгт хатуу арга хэмжээ авч байхыг иргэд шаардсан байна.

Бидний хийсэн судалгаагаар дараах томъёогоор тодорхой төрлийн гэмт хэрэгт хохирох тусгай эрсдэлийг тооцож болно. Энэ томъёогоор

$$K_{\text{бхтэ}} = \frac{\text{ГХХ}_T}{\text{ХА}} * 10,000, \quad K_{23-25} = \frac{19776}{1691766} * 10,000 = 116,9$$

Үүнд: $K_{\text{бхтэ}}$ = тодорхой төрлийн гэмт хэргийн тусгай эрсдэлийн коэффициент;
 ГХХ_m = тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогчийн тоо;
 ХА = хүн амын тоо.

Энэ томъёогоор Улаанбаатар хотод гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт эрсдэх хохирогчийн тооцооллыг харуулав.

Гэр бүлийн хүрээнд буюу гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2020-2022 онд нийт 19776 гарсан гэж үзвэл, ирэх 3 жилүүдэд буюу 2023-2025 онд 10,000 хүн тутамд 117 хүн хохирох эрсдэлтэй байна.

Тодорхой төрлийн гэмт хэргийн хохирол учруулах аюулын коэффициентыг дараах томъёогоор бодож олно. 2017-2022 онд нийт гэмт хэрэгт 184785 хүн хохирсон бол үүнээс 7046 хүн гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирчээ. Гэр бүлийн хүчирхийлэлд хохирсон 7046 хүний 6322 нь эмэгтэй, 540 нь хүүхэд байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн аюулын зэргийг дурдсан томъёогоор тооцоолоход:

$$K_{\text{тхуа}} = \frac{\text{ХТ}_T}{\text{ХТ}_{\text{бт}}}; \quad K_{\text{тхуа}} = \frac{184785}{7046} = 26.2$$

Үүнд: $K_{\text{тхуа}}$ = тодорхой төрлийн гэмт хэргээс хохирол учруулах аюулын коэффициент;
 $\text{ХТ}_{\text{бт}}$ = тодорхой төрлийн гэмт хэргийн бодит хохирогчийн тоо;
 ХТ_m = тодорхой төрлийн бүх гэмт хэргийн хохирогчийн тоо.

¹ TV5 Mongolia. Видео мэдээ

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөх аюулын зэрэглэл нь олон улсын жишгээр индекс оноо 20 ба түүнээс дээш бол маш өндөр хэмжээнд гэж үздэг байна.

Веб-сайт Numbeo¹ 2023 оны эхээр дэлхийн улс орнуудын гэмт явдлын болон аюулгүй байдлын индексийг тооцон гаргасан байна. Индекс нь санал асуулга явуулах үндсэн дээр тухайн улсын гэмт явдлын түвшинг үнэлдэг. Рейтинг буюу зэрэглэлийг тогтоогчид нь 20 бол маш бага, 20-40 бол бага, 40-60 бол тогтвортой, 60-80 бол өндөр, 80-аас дээш бол өндөр гэж үзнэ. Индекс нь хэр өндөр байна, тухайн улсын гэмт явдлын түвшин дээгүүр байна гэж тооцдог. Монгол Улс нь гэмт явдлын индексээр 54, аюулгүй байдлын индексээр 46 үнэлгээтэйгээр 142 орноос 41 дүгээр байранд оржээ².

¹ Энэ нь Серб улсад бүртгэлтэй эдийн засгийн болон гэмт явдлын судалгааны чиглэлээр ажилладаг, дэлхийн томоохон мэдээллийн санг ашиглаж мэдээлэл боловсруулдаг, Гүүглийн инженерийн зохион бүтээсэн ВЕБСАЙТ ажээ.

² Рейтинг стран по индексу преступности//<https://www.akchabar.kg/ru/>

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ЯВДАЛД ХҮҮХЭД ЭМЭГТЭЙЧҮҮД ХОХИРОХОД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ

3.1. Хохироход нөлөөлж буй объектив хүчин зүйл, шалтгаан нөхцөл (нийгэм, эдийн засаг, хүн ам зүй, соёл, уламжлал)

Нийгэм-эдийн засгийн хүчин зүйл. ҮСХ-ны тайлангаар Монгол Улсад ядуу таван хүн тутмын хоёр нь 15-аас доош насны хүүхэд¹ байна. Ядуурал өрх дэх хүүхдийн тоо, тэжээгчдийн хувьтай нягт хамааралтай байгаа нь үр хүүхдүүдээ тэтгэх хангалттай тооны хөдөлмөрийн насны хүмүүс дутагдалтай байгааг харуулж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас мэдээлсний дагуу Монгол Улсын нийт хүн амын 8 хувьд буюу 240 мянга орчим хүн хүнсний эрхийн бичиг авдгийн 50 хувь нь хүүхэд² байна. Тэгвэл ядууралд өссөн хүүхдүүдийн хувьд боловсрол эзэмших боломж бага, үүнийг дагаад хүрэлцээтэй цалин хөлстэй хөдөлмөр эрхлэх боломж буурах, улмаар амьжиргааны түвшин доройтсоноос үүдэн гэр бүлийн зөрчил маргаан нэмэгдэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх эрсдэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлнө.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирох хувь хүний эрсдэлийг бодит объектив агуулгын байр сууриас авч үзэх нь энэ үзэгдлийн тухай ойлголтыг гүнзгийрүүлэх боломжийг олгоно. Дийлэнх тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчийн сонирхлыг илүү их татаж, тэдний анхаарлын төвд байдаг бөгөөд янз бүрийн шалтгаанаар гэмт хэрэгтэнд зохих ёсоор эсэргүүцэл үзүүлж чадахгүй хүмүүс байдаг. Тухайлбал, хүүхэд, өндөр настан, мөн сэтгэцийн болон бие махбодын хөгжлийн дутагдалтай хүмүүсийг нэрлэж болно.

Хүн ам зүйн хүчин зүйл. Улаанбаатар хотод өнөөгийн байдлаар 1.709.563 нь буюу 50.7 хувь нь эмэгтэй, 1,213,214 хүүхэд³ эзэлдэг байна.

Хохирогчдын нас, хүйс, сэтгэл зүйн онцлог, гэмт хэргийн уг шалтгааны учир холбогдол нь ялангуяа эмэгтэйчүүд, өсвөр насны хүүхэд болон өндөр настны хохирох эрдлийн шинж чанарт тодорхой илэрч байна.

Монгол хүүхдийн хүүхдийн сэтгэл зүйн онцлогийг харуулсан зарим нэгэн судалгаа бий. Жишээ нь

“.....охидоос ялгаатай бэрхшээл юу байна гэхээр эмэгтэй хүүхдүүдийг бодвол эрэгтэй хүүхдүүд арай илүү сэтгэлийн хаттай бай гэж шахдаг. Өсвөр наснаас эхлээд “эр хүн байж иймэрхүү асуудлыг даваад гарж чадахгүй юм чинь цаашдаа яаж айлыг авч явах юм” гэдэг ч юм уу бид хүн биш зүгээр робот шиг байлгах гээд байдаг үнэхээр дарамттай.

Хөвгүүдийн ярилцлагаас

“Ар гэрийн ажлыг эмэгтэй хүн л хийх ёстой гээд сургачих юм бол том болоод ч хөвгүүд чинь юу ч болсон эмэгтэй хүн л гэрийн ажлыг хийх ёстой гээд толгойд нь суучихдаг. Тэр зүйлээс болоод жендерийн тэгш бус байдал багаасаа үүсдэг юм шиг санагдсан. Хөвгүүдтэй харьцуулах юм бол бид нар хувцас өмсөх болсон ч асуудал тулгардаг. Хүссэн хувцсаа өмсөж болохгүй аль болох боож багласан битүү хувцас өмсөх ёстой байдаг.

Охидын ярилцлагаас

¹ Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ), Дэлхийн Банкны хамтарсан “Ядуурлын дүр төрх” тайлан. Уб. 2020.

² Монгол Улсын Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал. Судалгааны тайлан. Уб. 2021

³ <https://www2.1212.mn/> Үндэсний статистикийн хорооны албан ёсны сайт

Хүүхэд, өсвөр насныхны бие, сэтгэл зүйн онцлог нь сониуч зан, адал явдалд дурлах, итгэмтгий байх, хөөрч сагсуурах, шинэ нөхцөл байдалд дасах чадавхгүй байх, хайр халамж дутагдах, тусламжгүй орхигдох, зарим тохиолдолд биеийн хөгжлийн хувьд сул дорой байх зэрэг нь энэ насны бүлгийн хохирох эрсдэлийг бүрдүүлнэ. Энэ шинж чанарууд нь бас гэмт хэрэгтний боломжийг нэмэгдүүлэх талаар судлаачид онцолдог.


Хүүхдийн хамгийн их хохирдог (виктим) хэсэг нь 12-14 насны хүүхдүүд байдгийг практик нотолж байна. Өсвөр насны хүүхэд нь шилжилтийн энэ үедээ насанд хүрэгчдийн асран хамгаалалтаас чөлөөлөгдөхийг эрмэлзэх, үе тэнгийнхэн болон бусад хүйсийн хүмүүстэй харилцах, мөн тодорхой цаг үед мэргэжлийн чиг баримжаагаа сонгох зэрэг олон асуудалтай тулгарна. Энэ үед бие хүн хамгийн хурдан төлөвшиж, хувь хүний ёс суртахуун нь бүрэлдэн тогтоно. Хүн нь хэлбэрийн хувьд 18 нас хүрч насанд хүрсэн гэж тооцогдох боловч, бодит байдлын хувьд хүн 16-18 насандаа төлөвших, эсхүл 20 насандаа ч төлөвшиж чадаагүй байх нь элбэг байна.

Жендерт суурилсан хүчирхийлэл нь Монгол Улсад тулгамдаж буй асуудал хэвээр байна. Үндэсний статистикийн хороо, Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангаас 2017 онд үндэсний хэмжээнд хийсэн Жендэрт суурилсан хүчирхийллийн тархалтын судалгаагаар эмэгтэйчүүдийн 57.9 хувь нь амьдралынхаа аль нэг үед жендэрт суурилсан хүчирхийллийн ямар нэг хэлбэрт өртдөг байна. Түүгээр зогсохгүй 31.2 хувь нь ойр дотны хүнээсээ бие махбодын болон, эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртдөг бол 7 эмэгтэй тутмын 1 нь хамтрагч бус хүний зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн¹ нь судалгаагаар батлагджээ. Эдгээр тоо баримт нь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг нэн тэргүүнд анхаарч, хохирогчдод цогц дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг онцолж байна. Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хүмүүс хамгийн түрүүнд эрүүл мэндийн байгууллагад ханддаг бөгөөд энэ нь хүчирхийллийн хохирогчдод тулгарсан бие махбод, сэтгэл санаа, нийгмийн үр дагаврыг арилгахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймд эрүүл мэндийн байгууллага нь жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгчдөд үйлчлүүлэгч төвтэй, цогц тусламж үйлчилгээ үзүүлж, дараагийн шатны үйлчилгээ авахад чиглүүлэх үүрэгтэй байдаг².

¹ НҮБ-ын Хүн амын сан. Жендэрт суурилсан хүчирхийллийн тархалтын судалгаа. Уб., 2017

² National Statistics Office, UNFPA, Breaking the silence for equality, 2017 National Study on Gender-based violence in Mongolia, 2018

Зураг 28. Судалгаанд оролцсон иргэдээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байгаа гол шалтгааны талаар илэрхийлсэн саналыг харуулав.



Монгол Улсад нийт 106.4 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн 59.0 мянга нь эрэгтэйчүүд, 47.4 мянга нь эмэгтэйчүүд, өндөр настай 232.029 иргэн¹, 4 хүн тутмын 1 нь сэтгэцийн эмгэгтэй гэсэн судалгаа байгаа нь нийтийн хүн амын 17 хувийг эзэлж байна.

Зарим төрлийн гэмт хэрэгт хохирогчийн яс үндэс, орон нутгийн зан заншлын уламжлал нь гэмт хэрэг виктимологийн ач холбогдолтой байхыг үгүйсгэж болохгүй юм.

Мөн “Шашин нь нэг талаас хүмүүст дуулгавартай ноомой байдлыг, нөгөө талаас энгийн даруу амьдарч хэрэглэхийг номлодог ч энэ нь зарим тохиолдолд хүч хэрэглэх, хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлж байна”² гэж эрдэмтэд үзсэн бөгөөд Монгол Улсын хүн амын 4 гаруй хувийг Мусалман шашинтай Казак үндэстэн эзэлдэг³ тул анхаарч үзэх асуудлын нэг болж байна. Манай улсад энэ талаар хийгдсэн Гэр бүлийн хүчирхийллийн судалгаа одоог хүртэл байхгүй үндэсний цөөнхийн дунд нуугдмал оршиж байгааг үгүйсгэх аргагүй юм. Эдгээр хүмүүст нийгмийн, түүний дотор гэмт хэрэгтнээс хамгаалах хамгаалалт байнга дутагдаж байгааг дурдах нь зүйтэй.

Казак зэрэг хэлтэй цөөнхийн хүүхдүүд Хүүхдийн тусламжийн 108 утаснаас мэдээлэл авч, эрхийн зөрчлөө мэдээлж чаддаггүй байна. Энэ нь хүүхэд хамгааллын талаарх олон нийтэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны ажил, үйлчилгээг хос хэл дээр гаргах хэрэгцээг харуулж байна. Мөн Баян-Өлгий дотроо цөөнхийн цөөнх болсон Тува, Урианхай, Халх хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар судалгаа, мэдээлэл орон нутаг болон үндэсний түвшинд байхгүй байна.⁴

¹ <https://www2.1212.mn/> Үндэсний статистикийн хорооны албан ёсны сайт

² С.М.Иншаков, Зарубежная криминология, М., 1997, стр 5.

³ <https://www2.1212.mn/> Үндэсний статистикийн хорооны албан ёсны сайт

⁴ НҮБ-ын Хүн амын сан, Жендэрийн Үндэсний Хороо, АХБ.2021. Монгол Улсад КОВИД-19 цар тахлын охид эмэгтэйчүүдийн нийгэм эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн судалгаа. <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/-covid-19-impact-on-women-and-girls-in-mongolia--study.html>

1.4. *Хот байгууламж, орон сууцны архитектур ба гэмт явдал.* Хотжилт нь нэг талаас хүмүүс олноор цугласан хот, төвүүдэд гэмт хэрэг үйлдэх боломж өндөр, нөгөө талаас, нийгмийн сул холбоо зэргээр тодорхойлогдож байна. Хотжих үйл явц эрчимжиж хүн амын төвлөрөл нэмэгдэхийн хэрээр гэмт хэргийн гаралт хотын дүүргүүдэд нэмэгдэж, хотын иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал улс бүрийн өмнө тулгамдсан асуудал болоод байна¹.

Криминологийн шинжлэх ухаанд энэ үзэгдлийн шалтгааныг илрүүлэхэд америкийн архитектор Оскар Ньюменийн дүгнэлт чухал ач холбогдолтой юм. Тэр Нью-Йорк хотын олон өрөө тасалгаатай барилгуудад гарсан гэмт явдлын гаралтыг судлаад, гэмт явдлын түвшин байшингийн өндөртэй ойролцоогоор пропорциональ хамааралтай байна гэсэн дүгнэлтэд хүрчээ. Тийм учраас тэр “defensible space” (хамгаалах чадвартай орон зай) бүрдүүлэхийг шаардсан байна. Ньюмений төсөөлснөөр энэ ойлголт нь оршин суугчдаас хариуцлагаа мэдрэх, түүнчлэн нийтийн эзэмшлийн (*хонгил, шат, шуудангийн хайрцгийн байр, барилгын өмнөх талбай зэрэг*) орчныг хамжин хамгаалах боломж бүхий тийм байршил, хэлбэртэй орон сууц, барилга юм. Архитектурын тусламжтайгаар гэмт явдлыг таслан зогсоохын тулд Ньюмен амьдрах болон гадна орчны орон зайг нэмэгдүүлэхийг санал болгосон байна. Оршин суугчид нь өөр хоорондоо танилцахын хэрээр гэмт явдал тухайн иргэнийг өрөөний хаалга хүртэл мөрдөх явдал таслан зогсоогдоно гэж тэр үзжээ².

“Орчин үеийн хотын дүүрэг, дагуул хотууд дахь “өндөр барилгын гэмт явдлыг” тодорхойлж байгаа дараах хүчин зүйлүүдийг: хүн нь зохион байгуулалт муутай олон мянган хүний дунд амьдарч байгаа; орчин тойрны нэг хэвийн, нэг янзын уйтгарт байдал; хүүхэд залуучуудад зориулагдсан орон зай, талбай дутмаг; албан ёсны бус нийгмийн хяналт ач холбогдол багатай байгаа зэргийг хамтад нь, цогцолбороор авч үзэх шаардлагатай юм.

Энэ талаар эрдэмтэд “Гэмт хэрэг нь хотын үзэгдэл болон төлөвшиж, нийгмийн харилцаа хөгжихийн хэрээр нийгмийн ерөнхий үзэгдэл болон хувирч байна”³ гэж тэмдэглэснийг “Хот нь соронз болж, хөдөө орон нутгаас шилжин (гэмт хэргийн идэвхтэй хэсгийг) ирэгсдийг татаж, соёл, хүн ам зүйн байдлыг доройтуулж, амьдралын хэв маягийг аажмаар соёлын доройтолд хүргэж байна”⁴ гэж тайлбарлажээ. Мөн тэрээр хүн ам олон болон тусам амиа бодох үзэл давамгайлж, нийгмийн сөрөг үзэгдэлд хариу өгөх нь буурдаг гэжээ.

Хот дахь хүн амын өсөлтийг ажил, сургууль, цэцэрлэг гэр хоорондын зай холдох тусах гэмт хэрэгт өртгөх эрсдэл нэмэгдэнэ⁵ гэж үзсэн байна. Түүнд гол нөлөөлөх хүчин зүйлийг бид түгжрэл гэж үзэж байна.

Улаанбаатар хотын авто замын сүлжээний урт сүүлийн 10 жилийн хугацаанд 954-1136 км болж 19 хувиар нэмэгдсэн бол, тээврийн хэрэгслийн тоо 234.2 мянгаас 624.8 мянга болж 2.4 дахин нэмэгдээд байна. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар

¹ Б.Энхболд. Хотжилт ба гэмт явдал. Уб., 2011. 20 дахь тал.

² Adler, Miettel, Laufer. Criminology. Second edition. New York., 1995. P 377.

³ Вицин С.Е. Методологические и информационные предпосылки исследования преступности в городах // Предупреждение преступности и обеспечение безопасности в городах. Материалы международной научно-практической конференции. М., 2009. С. 33

⁴ Забрянский Г.И. Городская и сельская виктимизация: сходство и различия // Виктимологические проблемы борьбы с преступностью. Иркутск, 2008. С. 15 - 21.

⁵ Гришин А.Н. Уличная преступность и ее профилактика службой милиции общественной безопасности в условиях крупного города. Автореф. дис. ... канд. юрид. наук. СПб., 2012. С. 10.

хотын авто замын хөдөлгөөнд 570 орчим мянган машин оролцож байгаа нь улсын хэмжээнд бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн 80 орчим хувь бөгөөд оргил цагийн ачааллын үед авто тээврийн хэрэгслийн дундаж хурд 8.9-10.8 км/цаг байна. Эндээс үзэхэд 2030 онд 5 км/цаг, 2040 онд дээд цэгтээ хүрч бүтэн өдрөөр түгжрэх нөхцөл үүснэ гэсэн урьдчилсан судалгааг Олон улсын Жайка¹ байгууллагаас гаргаад байна

2023 оны хувьд нийслэлийн төсвөөс Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд сургууль, цэцэрлэгийн хүртээмж нэмэгдүүлэх, нийтийн тээврийн парк шинэчлэл, явган болон дугуйн замын зарим хэсгийг санхүүжүүлэхээр 15.1 тэрбум төгрөг, гол гудамж замын бүтээн байгуулалтад 29.5 тэрбум төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэсэн.

Эцэг эх хүүхдээ зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, замын хөдөлгөөнд оролцуулахдаа суудлын бүсийг бүслүүлэх, зориулалтын хүүхдийн машины суудал ашиглах, зам хөндлөн гарахдаа ногоон гэрэл цагаан шугамаар хүүхдийн гараас нь хөтөлж гарах гэх мэт үүрэг хүлээдэг. Харин сүүлийн гурван жилд Монгол Улсын хэмжээнд зам тээврийн 1273 осол бүртгэсний 1981 хүүхэд хохирсон буюу 170 хүүхэд амиа алдаж, 1103 хүүхэд гэмтсэн байна. Энэ нэг талаараа эцэг эхчүүдийн хайхрамжгүй байдалтай холбогдох тоон үзүүлэлт юм.

3.2. Хохироход нөлөөлж байгаа субъектив хүчин зүйл

3.2.1. *Хувь хүний зан үйл дэх эрсдэлийн хүчин зүйлүүд.* Гэмт хэрэгт наад зах нь хоёр этгээд: хохирол учруулагч этгээд ба хохирогч этгээд (гэмт хэрэгтэн ба хохирогч) оролцоно. Иймд гэр бүлийн хүчирхийллийн хувьд гэмт хэрэгтэн ба хохирогч хоорондоо субъектив, объектив харилцаатай байдаг. Хохирогчийн зан үйл нь гэмт хэргийг өдөөн хатгасан буюу түүнийг үйлдэгдэх бодит, боломж, тохироог бүрдүүлсэн үед сөрөг, харин гэмт хэрэгтэнд эсэргүүцэл үзүүлэх буюу нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх үед эерэг, харин гэмт хэрэг үйлдэгдэхэд ямар нэгэн нөлөө үзүүлээгүй бол төвийг сахисан байж болно.

Хохирогчийн өдөөн хатгасан зан үйл нь хүнд хохирол учруулах, цаашлаад амь насыг бүрэлгэхэд хүргэдэг байна. Хүний сэтгэцэд байнгын удаан хугацааны сөрөг нөлөөлөл үзүүлэх нь түүнийг үзэн ядалтаар “цэнэглэж”, эцсийн эцэст ямар ч жижиг шалтаг харгис хэрцгий хариу үйлдэлд хүргэж болно. Өдөөн хатгалт нь зарим байдлаас хамаарч ухамсарлагдаагүй байж болно.

Хохирогчийн болгоомжгүй зан үйл. Ирээдүйн хохирогч нь гэмт хэргээс зайлсхийхийн тулд урьдчилан сэргийлэх зохих арга хэмжээ аваагүй, криминоген тохироог бүрдүүлэх боломжид хөнгөн хуумгай хандсан үед хохирогчийн болгоомжгүй зан үйл онцгой анхаарал татдаг.

Архи, согтууруулах ундааны хэрэглээ. Хохирогчийн согтуурсан, мансуурсан байдал нь гэмт хэрэг үйлдэгдэх явдлыг “хөнгөвчилж” болно. Тодруулбал, гэр бүлийн хүчирхийллийн хувьд согтууруулах ундаа хамт хэрэглэх. Монгол Улсад Насанд хүрсэн нэг хүний жилийн дундаж хэрэглээг сараар, нийтлэг савлагааны хэмжээгээр тооцвол, 2018 онд насанд хүрсэн 1 хүн сард дунджаар архи 2 шил (0.5л-тэй), шар айраг 6 лааз (0.5л-тэй), харин 100 мл дарс хэрэглэсэн байна. Энэ нь 2008 оноос 1 шил архи, 3 лааз шар айргаар нэмэгджээ. Согтууруулах ундааны төрлөөр авч үзвэл, сүүлийн 11 жилийн


¹ <https://www.parliament.mn/nn> Улсын их хурлын албан ёсны сайт

хугацаанд насанд хүрсэн нэг хүний жилийн дундаж шар айргийн хэрэглээ 2 дахин, архины хэрэглээ 1.6 дахин өссөн¹ судалгаа гарсан байна. Мөн ҮСХ-ноос 2017 онд улсын хэмжээнд зохион байгуулсан жендерт суурилсан хүчирхийллийн судалгааны дүнгээр бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдээс (судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 29.7 хувь) хүчирхийллийн шалтгааныг асуухад 62.2 хувь нь нөхөр/хамтрагч нь архи ууж согтуу байсан нь хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлсөн² гэж хариулжээ. Эдгээрээс дүгнэхэд согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэснээр гэр бүлийн хүчирхийлэл гарахад нөлөө үзүүлж байна гэж дүгнэх үндэстэй байна.

Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо, Жаргалантын гудамжинд оршин суух 44 настай П гэх эрэгтэй, эхнэр О-г хутгалж, амийг нь хөнөөсөн байжээ. Сэжигтэн П хэрэг үйлдэхдээ согтууруулах ундаа хэрэглэсэн байсан бөгөөд БЗД-ийн 13 дугаар хороонд оршин суух эрэгтэй 33 настай О-г эхнэртэйгээ хардан маргалджээ. Улмаар эхнэрийнхээ цээжин тус газар нь нэг удаа хутгалж амь насыг нь хохироосон байна.

Нээлттэй эх сурвалжийн мэдээллээс

Зураг 29. Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ч хууль сахиулах байгууллагад хандаагүй шалтгаан нөхцөлийг илэрхийлсэн саналыг харуулав.




Иргэдийн дунд явуулсан санал асуулгын дүнгээс үзэхэд гэр бүл салалтаас айх айдас хамгийн өндөр буюу 50 хувийг эзэлж байсан нь гэр бүлийн хохирогчдын буруутай үйлдлийг харуулж байна. Мөн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, дахин ирэх, заналхийлэл, дарамтаас айх, гэр бүл садан төрлийн таарамжгүй харилцаа үүсэхээс айсан үзүүлэлтүүд 33-43 хувийг эзэлж байгаа нь хувийн харилцаандаа сөв суулгахгүй гэсэн хохирогчийн үйлдлийг хамгийн өндөр байгааг харуулж байна.

¹ Үндэсний Статистикийн Хороо Согтууруулах ундааны хэрэглээ, үйлдвэрлэлийн өнөөгийн байдал. Уб. 2019 он

² Үндэсний статистикийн хороо. Жендерт суурилсан хүчирхийллийн судалгаа. 2017

Зураг 30. Монгол Улсад бүртгэсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт, гэрлэлтээ цуцлуулсан байдлыг харьцуулсан судалгаа¹.



Судалгаанаас дүгнэхэд сүүлийн 6 жилд бүртгэсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, гэр бүл цуцлах тохиолдол харилцан хамгаалалтай байгаа нь харагдаж байна. Тодруулбал, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн гаралтын дараагийн жилээс салалт нэмэгдсэн байна. Гэр бүлийн зөрчил, маргаан даамжирснаар салалт бий болдог бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн улмаас салалтын шалтгааны 40.9 хувьтай² байдаг талаар судлаад тэмдэглэсэн бол “тэргүүлэх шалтгааны нэгдүгээрт гэр бүлийн хүчирхийлэл ордог” гэж нийтлэгч, инфлюсерүүд³ дүгнэжээ.

Гэмт хэргийн механизмд суртахуун-сэтгэл зүйн онцлогууд: бэлгийн замбараагүй байдал, мансууруулах бодис ба согтууруулах ундаанд дурлах, сувдаг шунахай, харгис, түрэмгий, бүдүүлэг, хэрцгий, аймхай хулчгар, идэвхгүй, хардамтгай, итгэмтгий, гэнэн хөнгөмсөг, сайхан сэтгэл, шүүмжлэлгүй, хашир, болгоомжгүй, ёс суртахууны тогтвортой, хэрсүү, эелдэг ая зан, эелдэг, зоримог, эрэлхэг, биеийн бэлтгэл сайн, эсхүл сул дорой зэргээр илэрч харагдана. Эдгээр бүх шинж чанарууд нь тодорхой нөхцөл тохироо, зан үйлд илэрч, гэмт хэрэг үйлдэгдэхэд саад болох буюу түүнийг өдөөж, хөгжөөж болно.

Шүүхийн хэлэлцүүлэгт хохирогч, шүүгдэгч нарын “...Хардалтын улмаас маргаан гарч зодсон...” гэсэн агуулга бүхий мэдүүлэг болон хэрэгт авагдсан хохирогч Б.М-ын “...Сайхан амраарай миний хайр гээд миний таньдаг хүнээс мессеж ирсэн байсан. Тэрийг нөхөр харчхаад 2019 оны 12 дугаар сарын 29-ний өдөр нөхөр Э архи ууж орж ирээд үсдээд толгой руу гараараа нэлээн хэдэн удаа цохисон. Дараа нь 2020 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр хөдөөгөөс ирээд ...тэр айлд орчхоод намайг түлхэж унагаасан. Миний харилцаж байсан эрэгтэйн эхнэр бид хоёрын мессеж бичиж байсан

¹ <https://www2.1212.mn/> Үндэсний статистикийн хорооны албан ёсны сайт

² Т.Намжил нар. Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт. Судалгааны тайлан. УБ. 2019 он.


³ www.bur247.mn - Дэлхийгээр тархан ажиллаж байгаа 150 гаруй бүтээлч, нийтлэгчдийн сайт

зургийг үзүүлээд манай нөхөр тэр зургийг дарж аваад энэ явдал чинь үнэн юм байна шүү дээ гээд тэр айлаас гарсан. Машин дотор явж байхад миний хоолойг боогоод хөл рүү өшиглэсэн, мөн гараас зулгаагаад байсан¹.

Шүүхийн шийтгэх тогтоолоос

Зан суртахуун-сэтгэл зүйн онцлог нь тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхэд чухал учир холбогдолтой бөгөөд хохирогчийн хувийн дурдагдсан чанарууд нь гэмт хэрэг үйлдэгдэх арга ба хэрэгслийн үндэс болох буюу гэмт хэргийг өдөөгч болно. Гэмт хэрэгтэн хохирогчийг сонгохдоо, түүний ямар чанарыг ашиглаж болохыг тодорхойлж, урьдчилан тооцдог.

Зураг 31. Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийллийн хор аюулын шинжийг илэрхийлсэн төсөөлөл.




Иргэдийн иргэдийн 51,6 хувь нь бие махбодын хүчирхийлэл, 29 хувь нь эдийн засгийн хүчирхийлэл учрахаас айдаг бол бараг 100 хувь сэтгэл санааны хүчирхийлэл дарамтаас айж байна.

Хамгийн санаа зовниж байгаа асуудал нь хүүхэд өнчин хоцрох, хүүхдийн сэтгэл санаа, бие махбодод гэмтэл учрах бий гэхээс эмээж байна.

Шүүхийн хянан шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн мэдээнээс харахад:


¹ Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. 2020 оны 03 сарын 24 өдөр. Дугаар 278.

Зураг 32. Гэр бүлийн хүчирхийлэл үргэлжилсэн хугацааг харуулсан график.



Энэ байдлаас үзэхэд гэр бүлийн хүчирхийлэл нуугдмал урт удаан хугацаагаар үргэлжлэх байдал илэрч байна.

Зураг 33. Гэр бүлийн хүчирхийллийн давтамжийг харуулсан график.



Зан суртахуун-сэтгэл зүйн сөрөг онцлог нь гэмт хэрэг үйлдэгдэхэд дөхөм үзүүлэх нөхцөл байдлыг үүсгэх байдлаар илэрдэг. Энэ харилцаанд хамгийн тод жишээ нь согтуурал, мансуурал мөн. Архаг архичин, согтууруулах ундааг хааяа хэрэглэдэг хүмүүсийн хооронд ялгаа их боловч, гэмт хэргийн тухайн тохироонд согтуурлын байдлаас биеэ идэвхтэй ба идэвхгүй авч явсан эсэх нь хохирох явдлын хувьд ямар ч ач холбогдолгүй байдаг. Ийм учраас архи гэгч муу нэртэй ундааны үнэлэмж ийм байгаа юм. Архи, мансууруулах бодист дасах нь виктимийн талаас хувийн зан

төлөвийн онцлог шинж байдаг. Согтуу хүнийг “сэгсрэх”, хуурч мэхлэхэд хялбархан учраас тэд гэмт хэргийн хохирогч болохдоо хялбар байдаг.

Хохирогчийн зан суртахуун-сэтгэл зүйн онцлогийн хажуугаар оюун ухааны хөгжлийн янз бүрийн гажуудлыг тооцох хэрэгтэй юм. Эдгээр гажуудлын сөрөг илрэлүүд нь харгис хэрцгий, эсхүл идэвхгүй байдлаар илэрнэ.

Зан суртахуун-сэтгэл зүйн сөрөг чанарууд нь заримдаа хохирогчид өөрт нь ашигтайгаар хэрэгжих нь бий. Энэ нөхцөл байдал нь хохирогчийг “(атипич) сайн дураар хохирогч”, “хуурамч хохирогч” гэсэн бүлэгт ангилах үндэслэл болж байгаа юм. Сайн дураар хохирогчид хохирол учрах механизм зарим онцлог талтай. Сайн дураар хохирогчид: өөрөө үйлдсэн гэмт хэргийнхээ улмаас хохирсон этгээдүүд /цэргийн албанаас зайлсхийх зорилгоор эд эрхтнээ гэмтээх/, өөрөө хүсэж хохирсон /бэлгийн бойжилт олоогүй хамтран амьдрагч/, амиа хорлогч /өөрийгөө хорлох хүртлээ/ зэргийг тооцож болно.

Гэмт хэргийн тохироонд гүйцэтгэх үүргээр нь: а) хэрцгий /тодорхой сонгож авсан буюу аваагүй этгээдэд хүч хэрэглэх болон хэрэглэхгүйгээр бүдүүлэг, хэрцгий авирлан халдан довтолсон, доромжилж гутааж өдсөн зэргийн төлөө “хариу шангаа” хүртсэн;/ б) идэвхтэй /хэдийгээр довтолж, доромжлоогүй боловч, санаатай болгоомжгүйгээр хохирлыг өдөөн дуудсан буюу өөртөө хохирол учруулсан;/ в) санаачилгатай /албан тушаал, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг болон хувийн идэвх санаачилгатай үйлдлийн улмаас хохирсон эерэг зан үйл бүхий хохирогч;/ г) идэвхгүй /объектив субъектив шалтгаанаар гэмт хэрэгтэнд ямар нэгэн эсэргүүцэл үзүүлээгүй;/ д) гэнэн итгэмтгий /сонор сэрэмжгүй, амьдралын тохироог бодитойгоор үнэлэх чадваргүй, итгэмтгий, оюун ухааны хөгжил сул, өндөр настай гэх зэрэг;/ е) төвийг сахисан /гэмт хэрэг үйлдэгдэхэд ямар нэгэн байдлаар өдөөн дуудаагүй, тохиолдлын шинж чанартай, гэмт хэргийн тохироонд түүнийг саармагжуулахын тулд бүхий л бололцоогоо ашигласан/ хохирогч гэж тус тус ангилна. Төвийг сахисан зан үйл гэдэг нь тохиолдлын шинжтэй учраас хатуугаар хэлэхэд гэмт хэргийн улмаас ямар ч хүн хохирч болно гэсэн үг юм.

2.2. Гэмт явдлаас айх нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлүүд. Гэмт явдалтай холбоотойгоор байнга өсөн нэмэгдэж байгаа түгшүүр нь өөртөө хэд хэдэн сөрөг үр дагавар дагуулдаг. Түүний нэг нь - зан үйлийн эрх чөлөөгөө алдах, гээх явдал мөн. Гэмт явдлаас айх асуудал өсөн нэмэгдэж байгаа түвшин нь нийгэмд дезадаптаци буюу үл нийгэмшилт үүсэхэд нөлөөлнө. Энэ асуудал нь иргэдийн нийгэм, эдийн засгийн ханамж, сэтгэл зүйн байдалд сөргөөр үйлчилж, аж байдлын чанарт нөлөөлнө¹.

Айдас нь хувь хүний биологийн буюу нийгмийн оршин тогтохуйд аюул заналтай хамт үүсэж, бодит буюу төсөөлөгдөж буй аюулын эх үүсвэрт чиглэгдэж байгаа сэтгэл хөдлөл юм².

Германы эрдэмтэн Ф.Риманы зааглан авч үзсэн айдсын хэлбэрүүдэд анхаарал хандуулсан байдаг. Түүний үзэж байгаагаар айдсын үндсэн хэлбэр нь:


- “Би” ба хараат бус байдлаа алдахаас эмээж өөрийн амь насаа хайрлах айдас;

¹ Grabosky P.N. Fear of Crime and Fear Reduction Strategies // Current Issues in Criminal Justice. – 1995. – № 7 (1). – P. 7.

² Краткий психологический словарь / Под ред. А.В. Петровского, М.Г. Ярошевского. - М.: Политиздат, 1985. - С. 344.


- Хамгаалалтгүй байдал, ганцаардлаас эмээсэн /“Би”-гийн зогсонги байдал/ өөрийн байр суурийн айдас;
- Өөртөө итгэлгүй байх, хувьсамтгай чанараас эмээсэн, өөрчлөлтийн өмнөх айдас;
- Эрх чөлөөгүй байдал ба төгсгөлөөс эмээсэн зайлшгүй шаардлагын өмнөх айдас.¹

Зураг 34. Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдалтай тэмцэх, “шүгэл үлээх”- эд учирч болох эрсдэлийн талаар иргэд дараах үзэл бодолтой байна.



Мөн адил судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь сэтгэлзүйн шинжтэй эрсдэлийг илэрхийлжээ.

Зураг 35. Судалгаанд оролцогчдын гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийн талаарх гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн үзэл бодол.



¹ Римап Ф. Основные формы страха / Пер. с нем. Э.Л. Гушанского. – М.: Алтея, 1999. – С.24.

Судалгаанд оролцогчдын 31% нь адил хэмжээнд огт буруугүй, тодорхой хэмжээнд ойлголцох боломжтой байсныг илэрхийлжээ.

Гэмт хэргээс айх явдлын нийгмийн үр дагаврын талаар дараах дүгнэлтийг хийж болно. Үүнд:

Нэгдүгээрт, айдас нь нийгмийн сайн сайхан, тааламжтай мэдрэмжийг эвдэнэ.

Хоёрдугаарт, тэр сэтгэцийн хямралын нэг хүчин зүйл учраас түүний байнгын үйлчлэл нь хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.

Гуравдугаарт, айдас нь хүмүүсийн гэмт хэрэгт хохирох эрсдэлийг нэмэгдүүлнэ.

Дөрөвдүгээрт, гэмт явдлаас айх нь харгислалын эх сурвалж болон хувирна.

Эцэст нь гэмт явдлаас айхын хамгийн ноцтой нэг үр дагавар бол нийгмийн тусгаарлалтад хүргэж, эргэн тойронд амьдарч байгаа хүмүүст итгэх итгэлийг сулруулж, нийгмийн харилцан үйлчлэлийн идэвхийг сулруулж, нийгмийн холбоо, эв нэгдэлд сөрөг нөлөө үзүүлнэ. Гэмт явдлаас айх нь зарим талаараа хүн амын дунд гэмт хэрэгтнийг хатуу шийтгэж, залхаан цээрлүүлэх уур амьсгалыг нэмэгдүүлнэ. Хэдийгээр гэмт хэргээс айх явдал тулгамдсан асуудал хэвээр байгаа боловч, манай орны шинжлэх ухаанд хангалттай судлагдаагүй байгаа учраас энэ асуудлыг бүх талаас, гүн гүнзгий судлах асуудал чухал байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид “Стокгольмийн хам шинж” буюу аюултай нөхцөл байдалд орж, сэтгэл зүй нь цочролд орсон үед аюултай байдалд хүргэсэн гэмт этгээдийн гаргасан зарим нэг өгөөмөр зан байдалд нь талархаж, улмаар тагдан, улмаар тэдний талд орох сэтгэцийн эмгэг үүсдэг байна. Тодруулбал, хохирогчид өөрсдийгөө буруутган, хүчирхийллийн тойрогт орсноо мэдэхгүй, хууль сахиулах байгууллагад хандахгүй хүчирхийлэлтэй харилцаандаа үлддэг байна. Энэ нь хүчирхийлэл улам даамжрах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Зарим эрдэмтэд “Зодуулдаг эмэгтэйн хам шинж” буюу зарим эмэгтэй хэт их айсны улмаас эсвэл зугтах ямар ч боломжгүй гэж итгэдэг учраас хүчирхийлэлтэй харилцаандаа үлддэг” гэж тайлбарлажээ. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэй цөхрөх, илтгэл найдвараа алдах, тусламж авах боломжгүй гэж итгэх, хүчирхийллийн эргүүлэгт орж түүнээсээ гарч чадахгүй болох, хэвийн бус харилцаанд энэгшин дасах¹ шинжийг хэлжээ.

Тэдний онолыг бусад гэр бүлийн хүчирхийллийн онолын талаас тайлбарлаж болно. Тодруулбал, нь феминист онолд “Эцгийн эрхт ёс давамгайлсан нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүний эрх мэдлийн харилцаа тэнцвэртэй биш, тэдний нийгэмд гүйцэтгэх үүрэг өөр өөр байдаг, эмэгтэйчүүд хүчирхийлэлтэй харилцаандаа үлддэг шалтгааныг тайлбарласан онолын урсгалуудаас хамгийн түгээмэл нь хүчирхийллийн эргүүлэгт орох, тусламж авах боломжгүй гэж итгэх, зодуулсан эмэгтэйн хам шинж, хэвийн бус харьцаанд ээнэгшин дасах, сэтгэл зүйн хаагдмал байдал”², мөн “Хөрөнгө мөнгө орлого ихтэй, нийгмийн харилцаа холбоо сайтай, эрх мэдэлтэй хүмүүс хүч чадалтай, шийдвэр гаргах эрх мэдэл нь илүү байдаг. Энэ нь эдийн засгийн хувьд эмэгтэй хүмүүс хараат байдалд ороход хүргэдэг”³ хэмээн социологийн онолын үүднээс барууны эрдэмтэд тайлбарлажээ.

¹ Ц.Арвинтариа нар. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ. Уб., 2020 он. 20 дахь тал.

² M.Brewster. Domestic Violence Theories. Research and Practical Implication. NY., 2002. p.26

³ M.Brewster. Domestic Violence Theories. Research and Practical Implication. NY., 2002. p.33

Мөн социологийн онолд “хүмүүс бусдын хийж буй үйлдлийг харж, даган дуурайх замаар шинэ зан үйлийг сурна, хэрэв тухайн зан үйлийг дэмжсэн орчин бүрдвэл тэр зан үйл давтагдана гэж үздэг. Өөрөөр хэлбэл, хүчирхийллийг харсан хүмүүс хүчирхийллийг өөрсдийн харилцаандаа хэрэглэнэ. Хэрэв сөрөг үр дагаваргүйгээр (жишээ нь хууль эрх зүйн арга хэмжээ авагдаагүй тохиолдолд) хүссэн үр дүндээ хүрвэл (хүчирхийллийг зөвшөөрөх ба хариу арга хэмжээ аваагүй тохиолдолд) *тэрхүү үйлдэл нь дахин давтагдах магадлал ихтэй*¹ гэж тайлбарласан нь хохирогч нийгмийн сөрөг үзэгдэл болох гэр бүлийн хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх нь дахин давтагдах шинжийг агуулна гэж үзжээ.

3.3. Хохирогчийн сэтгэл зүйн онцлог (мөрдөн шалгах ажиллагааны явцад анхаарах зарим асуудал)

Хохирогчийн хувийн шинж чанарыг харгалзан үзэхгүйгээр гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан, нөхцөлийг бүрэн илчлэх боломжгүй юм. Учир нь гэмт хэрэгтний гэмт санаа зорилгоо хэрэгжүүлэх сэдэл нь хохирогчийн хувийн онцлог шинж, түүний үйлдэлтэй нягт холбоотой байдаг². Хохирогчийн профил нь түүний хувийн шинж чанар, виктим зан үйлийн онцлогийг тодорхойлох ба профайлер нь хохирох эрсдэл (victim risk, offender risk)-ийг судалж, гэмт хэрэгтэн ба хохирогчийн амьдралын хэвшил, хүмүүсийн хүрээлэл, ажил хөдөлмөр зэргийг мөн судалдаг³.

Хохирогчийн сэтгэл зүйн онцлогийг тодорхойлох үйл явц нь түүний гэмт халдлагад өртөхөөс өмнөх, гэмт халдлагад өртөх үеийн болон гэмт халдлагад өртсөний дараах зан төлөвийн онцлог шинжийг харьцуулан судлахаас эхэлдэг.

Хохирогчийн сэтгэл зүй нь дараах шинж чанаруудаар тодорхойлогддог.

1. Хүчирхийллийн хохирогчийн сэтгэцийн төлөв байдал нь түүний тусгал-зохицуулалтын хүрээнд ихээхэн өөрчлөлтийг үүсгэдэг сэтгэцийн туйлын төлөв (стресс, үзэн ядалт, бухимдал)-т байгаа гэдгийг харгалзан үзэх нь зүйтэй. Энэ нөхцөлд хүний ухамсарт сэтгэхүй хумигдаж, сэтгэл хөдлөл давамгайлах бөгөөд дасан зохицох чадвар нь хязгаарлагдмал байдаг. Тиймээс хохирогчийн цаашдын сэтгэцийн байдлыг гэмт хэргийн улмаас үүссэн сөрөг сэтгэл хөдлөлийн байдал болох "яллах давамгайлсан" хандлагаар тодорхойлж болно. Эхний мэдүүлгийн үед хохирогчид тохиолдсон таагүй үйл явдлыг дахин сэргээн сануулж байгаа учир сэтгэцийн хэт ачаалал нь түүний сэтгэх чадварыг хязгаарладаг болохыг харгалзан хохирогчийн мэдүүлгийг сайтар шалгаж үзэх хэрэгтэй. Харин давтан мэдүүлэг авах явцад сэтгэл хөдлөл буурч, оюуны бүтээмж илүү байна.

2. Хохирогчдын мэдүүлэг нь ихэвчлэн үнэлгээний элементүүдээр дүүрэн байдаг бөгөөд сэтгэл хөдлөлийн шинж давамгайлсан, ихэнхдээ зарим үйл явдлуудыг төсөөллөөр сэргээн босгох байдлаар мэдэгдэхүйц өнгө нэмэн тодорхойлсон шинжтэй байдаг. Хохирогчид ихэвчлэн гэмт хэрэгтэнтэй харьцах үед мэдэрсэн сэтгэл хөдлөл, мэдрэмж (айдас, түгшүүр, цөхрөл, бие махбодын зовиур, тэмцэл)-ээ ой ухаандаа удаан хугацаагаар хадгалдаг ба гэмт хэргийн “гашуун” үйл явдлууд хохирогчийн ухамсраас түрэгдэн гарч, үл ухамсарлагдахуй дахь хамгаалалтын механизмын төлөвт шилждэг. Хохирогчийн мэдүүлэг нь хэрэгт ач холбогдолтой мэдээллийг хүлээн авах

¹ Г.Ганбаатар. Гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбоотой үйлдсэн гэмт хэргийг мөрдөх арга зүй. Уб., 2019. 16 дахь тал.

² Номин-Эрдэнэ, Ш. Гэмт хэрэг илрүүлэхэд профайлинг ашиглах онол, арга зүй. Шинжлэн магадлахуйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2023 он. 144 дэх тал.

³ Нямсүрэн, Ч. Гэмт хэргийн виктимологи. Уб., 2005. 375 дахь тал.

чухал үйл явц тул хувь хүний шинж чанар, тэргүүлэх арга барилаас хамааран түүний ассоциац (холбоослол)-ийн хүрээг өдөөх нь чухал юм.

3. Хохирогчоос тайлбар мэдүүлэг авах, нүүрэлдүүлэн байцаах, туршилт явуулах зэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогчийн сэтгэцийн гэмтлийг давтан сэргээх байдлаар хохирогчид хоёрдогч гэмтэл үүсэх эрсдэлтэй байдаг тул хохирогчийн сэтгэцийн хамгаалах механизм ухамсаргүйн түвшинд өөрийн эрхгүй идэвхэждэг онцлогийг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай юм.

4. Хохирогчийн ухамсарт сэтгэхүй хумигдаж, сэтгэл хөдлөл нэмэгдсэний үр дүнд сэтгэлгээний логик дэс дараалал алдагдсан байдаг онцлогтой. Бие махбод болон сэтгэцийн хувьд учирсан хүчтэй нөлөөллийн үр дүнд цочрол үүссэн байдаг тул түүний сэтгэцэд эерэг болон сөрөг сэдлүүд тэмцэлдэж, хувь хүний дотоод зөрчил эрчимтэй явагдаж байдаг. Иймд хохирогчийн үйлдэл, санаа зорилгоос логик дэс дараалал хайх нь төөрөгдөлд оруулах эрсдэлтэйг харгалзан үзэх нь зүйтэй.

5. Гэмт халдлагад өртсөнөөс хойших хохирогчийн сэтгэхүйд ерөнхийлсөн хандлага онцгой ажиглагдана. “Бүгд хүчиндсэн, бүгд доромжилсон, бүгд муу хүн, бүх эрэгтэй хүн харгис, зэрлэг” гэх мэтээр цочролоос үүдэлтэй мэдрэмжээр бүгдийг ерөнхийлөн дүгнэдэг бөгөөд “үл итгэсэн” хандлага өндөр түвшинд илэрнэ. Иймд мөрдөгчийн хохирогчтой харилцах харилцааны хэв маяг нь хохирогчийн сэтгэцийн гэмтэл авсан, шударга ёсны хамгаалалтыг эрэлхийлсэн төлөвт нийцсэн байх шаардлагатай. Мөрдөгчийн үл тоомсорлосон, сэжиглэж хардсан хандлагыг хохирогчид хурцаар мэдэрдэг бөгөөд энэ нь түүний сэтгэл хөдлөлийн сөрөг байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Тиймээс мөрдөгчийн онцгой үүрэг бол хохирогчийг аль болох тайвшруулж, гэмт хэргийг сайтар, үнэн бодитой, гүйцэт мөрдөн шалгах болно гэдэг итгэлийг өгч, батлах явдал юм.

Гэмт хэргийн үйлдэгдэх шалтгаанд хохирогчийн зан үйлийн үүрэг их байх тусам гэмт этгээдийн нийгмийн эсрэг чиг хандлага бага байдаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Учир нь гэмт хэрэг үйлдэх үеийн сэтгэл зүйн механизмд хохирогчийн сэтгэл хөдлөлийн байдал ихээхэн ач холбогдолтой юм. Тиймээс гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, үр дагавар, гэр бүлийг нийгэмшүүлэх явцад хохирогч болсон эмэгтэйчүүдийн зан үйлийн сэтгэл зүйн шинж чанарын талаарх судалгаа шинэчлэгдэж байна. Энэ нь эмэгтэйчүүдийг хохирогч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохих эрх зүйн хэм хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэлийг бий болгож байна.

Хохирогчийн профайлинг (виктим зайн үйл, хохирогчийн сэтгэц зан үйлийн онцлог, нийтлэг дүршил). ОХУ-ын судлаач С.Н.Эниколопов хүчирхийлэл үйлдэх эрсдэлтэй хүмүүсийн зан чанарын онцлогийг тодорхойлох дагнасан судалгаа явуулсны үр дүнд хүчирхийлэл үйлдэгч гэмт хэрэгтнүүд хүчирхийлэлтэй гэр бүлд өссөн, эцэг эхийн хоорондын түрэмгийлсэн харилцааны гэрч болсон; өөрийгөө доогуур үнэлдэг, бухимдлыг тэсвэрлэдэггүй, өөртөө итгэлгүй, хар тамхи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг¹ гэж тодорхойлжээ.

Нийгэм-түүх, хууль эрх зүйн хүчин зүйлсийн зэрэгцээ нийгэмд түрэмгийлэл, хүчирхийлэлд өртөмтгий хүмүүс сэтгэл зүйн хувьд хохирогчийн шинж чанартай байдаг. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн хүчирхийллийн илрэл нь ихэвчлэн эмэгтэйчүүдийн өөрсдийнх нь зан авир, сэтгэл зүйн онцлогоос шалтгаалсан шинжтэй байдаг.

¹ Ениколопов, С.Н. Современные проблемы психологии семейного насилия // Домашнее насилие в отношении женщин: Масштабы, характер, представления общества. М.: МАКС–Пресс, 2003. С. 96.

Эрдэмтэд хохирогчийн зан үйлийн үзэгдлийг “өдөөн хатгасан байдал”, “эмгэгийн хавсарсан байдал”, “хэт их санаа зоволт”, “харилцааны донтолт”, “сэтгэцийн байдал”, “зан чанарын онцгой шинж чанаруудын цогц”, “сэтгэцийн хамаарал” гэж үздэг. Эмэгтэйчүүдийн хохирогчийн зан үйлийг бий болгох урьдчилсан нөхцөл нь тэдний бага насанд эцэг эхийн анхаарал, халамж дутуу, харилцааны хомсдол, хэрэгцээ, хүсэл, сонирхлоо илэрхийлэхийг хориглох зэрэг эрт нийгэмшүүлэх шинж чанарууд юм. Түүнчлэн эмэгтэйчүүдийн хохирогчийн зан төлөвийг бий болгох урьдчилсан нөхцөл нь бага насандаа тохиолдсон хүчирхийллийн үр дагавар байж болно. Энэ асуудлыг авч үзэхэд А.Н.Елизаров¹ бага насандаа хүчирхийлэлд өртсөн хүмүүст өөрийг нь тарчлаан зовоогч хүчирхийлэгчдээ үнэнч байх, өөрийгөө золиослоход бэлэн байх, сөрөг удирдагчийг сонгох, бусдад хор хөнөөл учруулах, өөрийгөө гэм буруутайг хүлээн зөвшөөрч, хариуцлага хүлээх, бусдын үзэл бодлоос хэт хамааралтай байх гэх мэт зан чанар хөгжиж байгааг тэмдэглэжээ. Хохирогч эмэгтэйчүүдийн нэг онцлог шинж чанар нь амьдралынхаа аль ч талбарт хязгаарлалт тогтоох чадваргүй байдаг. Гэр бүлийн хүчирхийлэл, бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртдөг эмэгтэйчүүд өөрийн юу хүсэж байгаагаа, юунд дуртай, юу мэдэрч байгаагаа, юунд итгэж байгаагаа ойлгож, тодорхойлох чадваргүй байдаг. Тэд бусад хүмүүст “үгүй” гэж хэлж чадахгүй бөгөөд эргэн тойрныхоо хүмүүсээс өөрт нь хандсан шаардлага, даалгавар өгөхийг ухамсаргүйгээр хүлээж байдаг. Тэд юу хүсэж байгаагаа үнэхээр мэддэг байсан ч түүнд хэрхэн хүрэхээ мэддэггүй.

Хохирогч эмэгтэйчүүд бусад хүмүүс өөртэй нь хэрхэн харьцах талаар тодорхой ойлголтгүй, тэдний хувийн зан чанарын хил хязгаар хаана дуусч, хамтрагчийнхаа хувийн хил хязгаар хаанаас эхлэхийг мэддэггүй, өөрийн мэдрэмж, хэрэгцээ шаардлагад анхаарал хандуулдаггүй. Өөрийн төлөөх хариуцлага бусдын төлөөх хариуцлагаар солигддог. Ийм хариу үйлдэл хийснээр хүн өөрийгөө бусдаас ялгаж чадахгүй, өөрийн "би" хаана дуусч, бусдын "би" хаанаас эхэлж байгааг тодорхойлж чадахгүй. Тиймээс, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувьд өөрийн гэсэн хил хязгаар маш бүдэг тул хувийн мэдрэмж, бодол санаа, хүслээ бусдын мэдрэмж, бодол, хүслээс ялгахад хэцүү байдаг².

Эмэгтэй хохирогчдын Эго хил хязгаар тодорхойгүй байдаг³. Тиймээс, зөвшөөрөгдсөн зүйлийг хязгаарлах, хил хязгаарыг тогтоох асуудал ийм хүмүүсийн хувьд хамгийн хэцүү асуудлын нэг юм. Тэд өөрт нь зөвшөөрөгдөх боломжгүй зүйлсийн хил хязгаарыг тодорхойлж сурснаар маш их зүйлийг өөрчилж чадна. Эдгээр хязгаарыг ихэнх хүмүүс бага насандаа тодорхойлж, насанд хүрэгчид өөрсдийн орчиндоо тохирсон хязгаарыг загварчилж сурсан байдаг. Хүүхдийн бусад хүмүүстэй харилцах зөв, бурууг тодорхойлох үндэс нь эцэг эхийн хандлага юм. Гэвч уур амьсгал таагүй, харилцааны хэв маяг тогтворгүй гэр бүлд эцэг эхчүүд өөрсдөө хил хязгаараа мэдэрдэггүй бөгөөд хүүхдэдээ үүнийг зааж сургаж чаддаггүй.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийн зан үйлийн өөр нэг онцлог нь бусад хүмүүсийн, тэр дундаа эрэгтэй түрэмгийлэгчдээс үргэлж айж, эмээх хандлага юм. Сонголт, шийдвэр гаргахдаа тэд юу хүсэж байгаагаа өөрөөсөө асууж чаддаггүй ч хүчирхийлэгч нөхрийнхөө хүсэлтийг л харгалзан үздэг. Тэдний бусдын мэдрэмж, хүслийг үнэлэх зөн совин бага наснаас хөгжсөн байдаг. Бусдын дургүйцлийг төрүүлэх,

¹ Елизаров, А.Н. Социально-психологическая помощь семье, страдающей от насилия // Психология зрелости и старения. Ежеквартальный научно-практический журнал. 2006. № 4 (36). С.32.

² Москаленко, В.Д. Жены больных алкоголизмом. Вопросы психологии. 1991. № 5. С.91

³ Малкина-Пых, И.Г. Психология поведения жертвы: справочник практического психолога. М.: ЭКСМО, 2006. С.1008.

бухимдах, уурлах, тэдэнд хаягдах вий гэсэн айдас нь ийм эмэгтэйчүүдийн зан үйлийн үндэс болдог. Багаасаа болзолт хайранд өссөн хүмүүс бусдын хүслийг биелүүлэх замаар бусдын хайрыг “олж”, өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэхэд бүх хүчээ төвлөрүүлдэг. Ийм эмэгтэйчүүд нөхрийнхөө сөрөг хариу үйлдлийг хүлээж амьдардаг бөгөөд түүний сэтгэл санааны огцом өөрчлөлтөд дасан зохицсон байдаг. Тэд алдаа гаргахаас айж, ямар ч шийдвэр гаргах чадваргүй болдог. Ийм эмэгтэйчүүдийн хувьд ганцаардлаас айх айдас нь хамгийн хүчтэй хүчин зүйл бөгөөд тэд нөхөргүй бол аливаа асуудлыг даван туулж чадахгүй гэсэн итгэл үнэмшлээр өөрсдийгөө хүчирхийллийн байдалд оруулдаг.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн зан үйл нь тэдний сэтгэлзүйн хамгаалах механизмаар тодорхойлогддог. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хамгаалалтын үндсэн механизмын илрэх шинж чанаруудыг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

Үгүйсгэл. Тогтмол стресстэй нөхцөлд амьдардаг эмэгтэйчүүдийн нэг онцлог шинж чанар нь асуудлыг илэн далангүй хэлэлцэж шийдвэрлэхээс татгалзаж, бодит байдлыг үгүйсгэх явдал юм. Ийм эмэгтэйчүүд сэтгэл зүйгээ хамгаалахын тулд түгшүүр төрүүлдэг бодит байдлыг мэдрэхээс татгалздаг. Гэвч А.Фрейд “үгүйсгэх нь хэзээ ч бүрэн хамгаалалт болдоггүй, учир нь цаг хугацаа өнгөрөх тусам илүү их, илүү хүчтэйгээр үгүйсгэх шаардлагатай болдог”¹ гэж онцолсон байдаг. Өөрөөр хэлбэл, бодит байдлыг үргэлж үгүйсгэвэл хожим нь буюу тодорхой цаг мөчид бодит байдлыг ухаарах үед тэрээр ямар нэгэн үйлдэл хийх, шийдвэр гаргах, эсвэл бүр бүгдийг эцэслэх сонголтод тулсан байдаг.

Тунгаан бодох. Тэд өөрт нь өдөр бүр тохиолддог доромжлол, дээрэлхэлтийг хүчирхийлэл гэж үздэггүй. Ийм эмэгтэйчүүд ихэнх тохиолдолд харилцааны хямралаас хямралын хооронд амьдарч, зовуурь, зүдгүүрийг мэдэрдэг боловч юу болж байгааг нухацтай үнэлж чаддаггүй. Түрэмгийлэгчийн хэлсэн бараг бүх зүйлд итгэх нь энэ төрлийн хохирогч эмэгтэйчүүдийн онцлог шинж бөгөөд энэ нь хүчирхийлэл дахин давтагдахад нөлөөлдөг. Хамтрагч нь ийм эмэгтэйг доромжилж, гомдоох үед тэр хурдан түүнийг зөвтгөж, өөрийгөө буруутгаж эхэлдэг бөгөөд удахгүй бүх зүйл өөрчлөгдөж, өөрийг нь ойлгох болно гэж найдаж хүлээсээр байдаг.

Тусгаарлагч. Энэ төрлийн эмэгтэйчүүд ихэвчлэн хүчирхийлэлд өртөж байгаагаа ойлгодог ч сэтгэлийн хөдлөлөөр хариу үйлдэл үзүүлэхээ больдог. Тэд “сэтгэлийн өвдөлт”-ийг дарж, доромжлолыг анзаарахгүй байхад суралцдаг. Тэдний мэдрэмжүүд “хөлдсөн” байдаг бөгөөд энэ нь сэтгэлийн шаналал, зовлонг тэсвэрлэхэд нь тусалдаг.

Орлуулах. Гэр бүлийн хүчирхийлэл, хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүд хүүхдүүдтэйгээ харилцахдаа бэрхшээлтэй тулгардаг, ихэнхдээ “эвдэрч”, улмаар үргэлж сөрөг сэтгэл хөдлөлийг илэрхийлдэг. Энэ нь хүчирхийлэгчийн аюул заналхийлэл нэмэгдэж, түгшүүр төрүүлэх үед идэвхэждэг бөгөөд үүнээс үндэстэй уур бухимдал, зовлонг мэдрэмжээ бусдад гаргах хэлбэрээр илэрдэг. Хохирогч эмэгтэйчүүд уур уцаартай байдал, нөхцөл байдалд сэтгэл дундуур мэдрэмжээ ухамсаргүйгээр өөрт нь аюулгүй, сул дорой объект буюу хүүхэд рүүгээ чиглүүлдэг.

Хүчирхийлэл, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн ашигладаг эдгээр болон бусад сэтгэлзүйн хамгаалах механизмууд нь “Эго”-г сулруулж, тэдний зан авир нь нөхцөл байдлыг хэрхэн хүндрүүлж, хүчирхийлэлд өөрсдөө ямар үүрэг гүйцэтгэж байгааг ойлгоход хэцүү болгодог.

¹ Фрейд, А. Психология «Я» и защитные механизмы. М.: Педагогика-Пресс, 1993. С.144.

Гэр бүлийн хохирогчийн өөр нэг онцлог шинж чанар нь “хатуу” хандлага юм. Эерэг, сөрөг үзэл бодлын хэт туйлшрал нь тэдний сэтгэлгээний байнгын шинж чанар. Аливаа зүйлийг зөвхөн хар эсвэл зөвхөн цагаан гэж хүлээн авдаг бөгөөд бүх үнэлгээ нь "сайн-муу" гэсэн хавтгайд оршдог¹. Эхнэр нөхрийн хүчирхийллийн асуудлын талаарх судалгаанаас үзэхэд гэр бүлийн харилцаандаа хохирогчийн зан авиртай эмэгтэйчүүд гэм буруу, уур хилэн, өрөвдөх сэтгэл гэх мэт аль нэг мэдрэмжийн урхинд орох хандлагатай байдаг. Ийм эмэгтэйчүүд амьдралынхаа туршид тойрог замаар алхаж, ижил нөхцөл байдлыг дахин давтаж, шийдвэрлэх боломжгүй ижил эсвэл ижил төстэй асуудлуудтай тулгардаг. Дээрх шинж чанарууд нь "Эго"-ийн ялгааг илтгэж, үүний үр дүнд өөрийн хэрэгцээ, мэдрэмжийг таньж, тодорхойлоход бэрхшээлтэй байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хохирогч болсон зан үйлийн онцлог шинж чанаруудын өөр нэг онцлог шинж чанар нь *идэвхгүй байдал* юм. Тэд хэрхэн шийдэмгий үйлдэл хийхээ мэддэггүй, ихэвчлэн гомдоллох байдлаар уур бухимдлаа гадагшлуулж, богино хугацааны тайвшрал авах байдлаар бэрхшээлийг даван туулж сурсан байдаг. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээний явцад ийм үйлчлүүлэгчид дараагийн товлосон уулзалтуудад ирдэггүй, зөвлөгөөг дуусгалгүй орхих хандлага ажиглагддаг.

Удаан хугацаанд стресст хүчин зүйлийн нөлөөнд амьдрах, бодит байдлыг үгүйсгэх, сөрөг сэтгэл хөдлөлийг дарах нь гэр бүлийн хохирогчид сэтгэлзүйн төдийгүй бие физиологийн эмгэг үүсэхэд хүргэдэг. Эрдэмтэд хохирогчийн зан авиртай эмэгтэйчүүд психосоматик өвчинд өртөмтгий, ханиад, томуу гэх мэт багахан өвчлөлийг ч удаан хугацааны туршид даван туулж чадахгүй, хүндрүүлэх хандлагатай байдаг гэж үзжээ. Биеийн өвчлөл нь бусдын анхаарлыг татах арга буюу өрөвдүүлэх байдлаар дутагдсан хайр, халамжаа олж авах хэрэгсэл гэж зарим судлаачид үздэг². Учир нь бие махбодын өвчлөлийн асуудал нь хохирогч "Би өвчтэй байна, намайг гомдоохоо боль" гэж хүчирхийлэгч рүү хэлэх цорын ганц нөхцөл байж болох юм. Бие махбод, сэтгэл санааны үл тоомсорлол, хүчирхийлэлд өртдөг гэр бүлд эмэгтэй хүн түүнээс өөрийгөө хамгаалахын тулд дасан зохицох зан үйлийн тогтолцоог бий болгодог бөгөөд энэ нь цаг хугацааны явцад амьдралын хэв маяг болж хувирдаг.

Эмэгтэйчүүдийн виктим зан үйлийн чиглэлээр хийсэн судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлүүдийг судалж үзээд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн сэтгэл зүйн шинж чанарыг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

- сэтгэл хөдлөлийн хоёрдмол байдал, сэтгэцийн түгшүүр, сэтгэл гутрал, бодит байдлаас уран зөгнөлт ертөнц рүү хөтлөгдөх хандлага, идэвхтэй үйлдлээс татгалзах, хэт мэдрэг байдал, эмзэг байдал зэргээр илэрдэг невротик зан үйл;

- нөлөөллийн үйл ажиллагааны эмгэг ("мэдрэмжийг тэглэх" - өөрийн мэдрэмж, хүсэл, хандлагыг үл ойлгох, гажуудуулах, төөрөгдүүлэх хандлагатай. Бусдын түрэмгий хандлагыг халамжийн илрэл; илэн далангүй нээлттэй байдлыг - сул дорой байдлын илрэл; нийтэч, яриасаг байдлыг - өөрийн болгоомжгүй байдал, сул тал; бусдаас дэмжлэг, тусламж авах нь - өөрийн үнэ цэнгүй байдлын нотолгоо гэж тус тус үздэг).

- Сул дорой байдал (гэр бүл болон бусад хүмүүс хоорондын харилцаан дахь сөрөг туршлага нь “би угаас азгүй, бүтэлгүй” гэсэн комплекс үүсгэдэг; өөрийгөө болон хүүхдүүдийнхээ төлөө үргэлж санаа зовнисон айдастай байдаг ба хэрхэн амь зуух вэ гэдэгт анхаарлаа төвлөрүүлдэг; өөрийн үйлдлийн болзошгүй үр дагаврыг урьдчилан

¹ Смит З.У. Внуки алкоголиков / Пер. с англ. М.: Просвещение, 1991. С.125.

² Панок, В.Г. Обиженные дети. Анализ проблемы. К., 1997. С.70.

харах чадваргүй байдал; бусдын доромжлолд тохирсон хариу үйлдэл үзүүлэх чадваргүй байдал);

- Танин мэдэхүйн үйл ажиллагааны эмгэг (өөрийн болон бусдын үйлдэл, түүнчлэн орчны нөхцөл байдлыг буруу ойлгох; эмэгтэй хохирогчид өөрт нь заналхийлж буй аюулд зохих үнэлгээ хийж чаддаггүй; цохих, зодолдох хариу үйлдлээ өөрийн эр зоригийн нотолгоо гэж үздэг; мэдрэлийн сэтгэлзүйн хурцадмал байдал нь үл ойлголцлын илрэл гэж хүлээн зөвшөөрөгддөг; болгоомжтой байхын тулд асуудалтай нөхцөл байдлын талаар сайн бодох шаардлагатай гэж үздэг учир хэт их эргэцүүлэн боддог);

- Өөрийн үнэлэмж доогуур, өөртөө итгэлгүй байдал (бусдын үзэл бодлоос хэт хамааралтай байх ба өөрийгөө харилцааны ур чадваргүй гэж үздэг учир бусадтай харилцаа тогтоохоос эмээдэг.

- Дотоод зөрчил ба үл нийцэх байдал (ийм эмэгтэйчүүд өөрсдийн хувийн хандлагыг хэрэгжүүлэхдээ тохиромжгүй хариу үйлдлүүдийг илэрхийлдэг. Тухайлбал, өрөвдөх сэтгэлээ хошигнох, шоолох, буруутгах байдлаар илэрхийлдэг; нийтэч байдал нь хэт хамааралтай, хараат байдлаар, айдас, түгшүүр нь өөрийгөө гэмтээх, өвтгөх байдлаар гэх мэт).

- Гэмтлийн дараах стрессийн эмгэг (таагүй зүүд зүүдлэх, үйл явдал давтагдах вий гэсэн үргэлжийн айдас, болгоомжлол, гэмтлийг санагдуулж болзошгүй өдөөгчөөс байнга зугтах, зайлсхийх; амьдралын чухал үйл ажиллагаанд сонирхол буурах, дасан зохицох чадваргүй болох).

- "Эго" -ын хил хязгаарыг зөрчих (өөрийнх нь тухай хүчирхийлэгчийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх, түүний бодлыг өөрийнхөө дүр төрхөд шингээх, өөрөөр хэлбэл эмэгтэй хүн гэмт этгээдийн бүх буруутгалыг аажмаар хүлээн зөвшөөрч, улмаар өөртөө итгэх итгэлээ алддаг).

- бага насны сэтгэцийн гэмтэл, эцэг эхийн зан үйлийн хэв маяг (хүүхэд насандаа эцэг эхийн сэтгэл зүйн хүчирхийллийн золиос болж, сэтгэл хөдлөл, мэдрэмжээ үргэлж дарах явдал нь өөртөө итгэх итгэлийг дарангуйлж байдаг ба дотоод хоосрол, цөхрөл, сул дорой байдлын шалтгаан болж байдаг.).

Үүнээс үзвэл хохирогчийн виктим зан үйл нь олон төрлийн сэтгэл зүйн шинж чанараар тодорхойлогдох бөгөөд тэдгээрийн шалтгаан нь гадаад болон дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр үүсдэг.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд нийгэмд охидыг виктим зан үйлээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн асуудал, бэрхшээлд орсон эмэгтэйчүүдэд сэтгэл зүйн туслалцааг цаг алдалгүй, хүртээмжтэй хүргэх, нөхөн сэргээх хөтөлбөрийг нэвтрүүлэх, түүнчлэн түүнд чиглэсэн сэтгэл зүйн болон практик арга хэмжээний тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСАД ХҮҮХЭД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВИКТИМОЛОГИЙН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

4.1. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх виктимологийн нийтлэг ажил, арга хэмжээ

Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх виктимологийн нийтлэг ажил, арга хэмжээний талаар судалгаа хийхэд энэ чиг үүрэг бүхий зарим байгууллагуудын ажлын тайлангийн мэдээлэл авахад хүндрэлтэй байсныг судалгааны баг тэмдэглэж байна. Энэ нь гэмт хэрэгт хохирохоос урьдчилан

сэргийлэх буюу гэмт явдлаас урьдчилан сэргийлэх виктимологийн ажил арга хэмжээний талаар ойлголт багатай байсан, зарим байгууллага мэдээлэл өгөхөөс татгалзсан зэрэг нь энэ бүлгийн судалгааг бүрэн хэрэгжүүлэхэд бэрхшээл учирч байсан.

Гэмт явдалтай тэмцэх арга хэмжээний нэг бүрэлдэхүүн хэсэг бол гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажил мөн. Криминологи, виктимологийн шинжлэх ухаанд: prevention (урьдчилан сэргийлэх гэсэн утгатай латин үг) ба prophylactic (урьдчилан хамгаалах гэсэн утгатай грек үг) гэсэн хоёр нэр томъёо хэрэглэж байна. Ихэнх эрдэмтдийн тайлбар, толь бичигт энэ хоёр ойлголтыг ижил утгатай гэж байгаа боловч, гэмт хэрэгтэй тэмцэх практикт “превенци” гэдэг нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ, харин “профилактика” нь урьдчилан сэргийлэх ажил, өөрөөр хэлбэл урьдчилан сэргийлэх цогцолбор арга хэмжээ¹ гэсэн утгаар голлон хэрэглэгдэж байна.

Виктимологийн урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийгмийн тогтолцооны хүрээнд багтаж, гэмт хэргийн далд хохирогчийн хамгаалалтын боломжийг идэвхжүүлэх, тэдний аюулгүй байдлыг хангах, виктим, өртөмтгий сөрөг чанар, зан үйлийг арилгах замаар хувь хүний болон хамтын хохирох эрсдэлийг багасгахад чиглэгдсэн нийтлэг болон тусгай арга хэмжээний дэд тогтолцоо юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ гэж “иргэдийн материаллаг амьдралын байдал, соёл боловсролын хэмжээг дээшлүүлэх замаар гэмт явдлын шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн дэс дараалалтай цогцолбор үйл ажиллагаа, чиг шугамыг”² хэлнэ. Монгол Улсын хууль тогтоомжид зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээнд: “гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахуун, хүмүүжлийн болон зохион байгуулалтын шинж чанартай нийтлэг арга хэмжээнүүдийн” чиглэлийг тогтоож өгсөн юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээний хүрээнд виктимологийн урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ хэрэгжинэ. Хохирох явдлаас урьдчилан сэргийлэх ерөнхий ажил нь хүн ам, түүний нийтлэгүүдийн нөлөөлж, гэмт хэрэг хохирох зан үйл магадлал, хохирох явдлын эрсдэлийг бий болгож байгаа эдийн засаг, нийгмийн болон бусад нөхцөл, учир шалтгааныг арилгахад чиглэсэн арга хэмжээнүүдийн тогтолцоо мөн.

Хохирох явдлыг нийтээр урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нийгмийн эдийн засаг, нийгэм, улс төр ба оюун санааны хүрээг эрүүлжүүлэх бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Виктимологийн судалгаанд үндэслэн хүн амыг хохирох явдлаас урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээг хохирох өндөр эрсдэлтэй нийгмийн бүлэг, үйл ажиллагааны хүрээ, объект зэргээр төрөлжүүлэн авч үзнэ. Эдгээрт эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүүхэд, өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй иргэд багтана.

Энэ нь гэмт явдлаас урьдчилан сэргийлэх криминологийн нийтлэг ажил, арга хэмжээтэй тохирдог.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай³ Монгол Улсын хуулийн 10 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаарх Монгол Улсын Засгийн газрын бүрэн

¹ Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. УБ.,2005.

² Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль//2019. Төрийн мэдээлэл №42

³ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль//2019. Төрийн мэдээлэл №42

эрхийг заажээ. Үүнд: Монгол Улсын Засгийн газар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар:

1) гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

2) төрөөс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр¹-т гэр бүлийн хүчирхийлэл, түүний дотор хүүхэд эмэгтэйчүүдийг энэ төрлийн гэмт явдлаас хамгаалах чиглэлд:

1) Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана.

2) Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

3) Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.

4) Эх газрын эрх зүйн бүлийн хэв шинж, философид суурилсан Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд нийцсэн, хүний эрхийг дээдэлсэн, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн урт хугацааны “Эрх зүйн шинэтгэл II” арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.

5) Гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, хүүхдийн тэтгэмж тогтоох болон газар өмчлөх эрх нь хөндөгдсөн төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

6) Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно² гэсэн зорилго, зорилтуудаа дэвшүүлсэн.

УИХ-аас 2016 онд шинэчлэн баталж, 2017 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай³ хуулиар гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцон, хүчирхийлэл үйлдэгчидтэй тооцох хариуцлагыг чангатгахын зэрэгцээ тэдэнтэй ажиллах зан үйлд нөлөөлөх албадан сургалтаар дамжуулан дахин хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай зан үйлийн болон сэтгэл зүйн зөвлөгөө тусламжийг үзүүлэх, түүнчлэн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах тогтолцоог бий болгох, олон нийтийн хандлага, сэрэмжийг дээшлүүлэх, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг нийгэмд төлөвшүүлэхэд багагүй ахиц гарч байна.

4.2. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх виктимологийн тусгай ажил, арга хэмжээ

Виктимологийн тусгай арга хэмжээний нэг төрөл нь тодорхой төрлийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажил мөн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Тодорхой төрлийн арга хэмжээг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Гэмт хэргээс урьдчилан

¹ Монгол Улсын Их Хурлын Тогтоол. 2020. дугаар 24.

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211219&showType=1>

³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль//2017. Төрийн мэдээлэл №5

сэргийлэх зөвлөл зохион байгуулна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар¹ дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

1) гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг энэ хууль болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу зохион байгуулах;

2) гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж болон хүчирхийлээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

3) салбарын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

4) гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

5) хууль сахиулагчийг бэлтгэх сургалтын хөтөлбөр, стандартад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэглэх ур чадвар эзэмшүүлэх агуулгыг тусгах;

6) харьяа агентлаг, байгууллагын ажилтны ажлын байрны тодорхойлолтод энэ хуульд заасан чиг үүргийг тусгасан байдалд хяналт тавих;

7) хуульд заасан бусад зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай² хуулийн 12 дугаар зүйлд зааснаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1) гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;

2) гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, чиглэл өгөх, хяналт тавих;

3) гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналыг боловсруулах;

4) гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журмын дагуу холбогдох мэдээллийг нэгтгэн боловсруулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

5) хохирогчид хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг батлан мөрдүүлж байгаа эсэх, холбогдох дүрэм, журмын хэрэгжилт болон ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт тавих хяналтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

6) улсын төсвийн хөрөнгөөр түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

7) хуульд заасан бусад.

¹ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль//2019. Төрийн мэдээлэл №42

² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль//2017. Төрийн мэдээлэл №5

Харин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар:

1) харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчид энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвт тусгуулах саналыг тухайн шатны Засаг даргад уламжлах;

2) хохирогчид энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

3) орон нутгийн төсвийн хөрөнгөөр түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

4) хамтарсан багийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, туслалцаа, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, чиглэл өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ¹.

Хүүхдийн асуудлаар иргэд хүүхдийн тусламж 108 төвд хандах эрхтэй. Дээр нь тодорхой асуудлууд байвал хөршийн дуудлага мэдээлэл, цагдаагийн 102 утсанд мэдээлэл өгч болно.

108 төв дуудлага мэдээллийг хүлээн авч тэр даруйд нь арга хэмжээ авдаг. Хэрвээ шуурхай тусламж хэрэгтэй гэвэл цагдаад хандаж, цагдаа болон 108 машин очиж хүүхдүүдийг авч, тусгаарлах байранд авчирдаг. Дуудлага мэдээллийг хүлээн аваад аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл залуучуудын хөгжлийн газар руу шилжүүлдэг. Тэндээс хамтарсан баг руу шилжүүлж хамтарсан баг яаралтайгаар тухайн айлд очиж нөхцөл байдлын үнэлгээ хийдэг.

Цагдаагийн ажилтны ярилцлагаас.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2023 оны эхний 10 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн 28.625 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өнгөрсөн жилийн мөн үеэс 9.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс энэ хугацаанд 1261 тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэж, 8478 тохиолдолд зөрчлийн хэрэг үүсгэж, бусад тохиолдлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зэрэг эрх зүйн актыг баримтлан хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, хороо, сумын хамтарсан багийн хяналтад өгөх, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зарим шаардлагатай иргэдийг архины сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулах санал хүргүүлэх зэргээр хуульд заасан үндэслэл журмын дагуу шийдвэрлэж байна.

Харамсалтай нь статистик мэдээллээс харахад бүртгэсэн 2 хэрэг тутмын нэг нь архидан согтуурсан үедээ гэр бүлийн хамаарал бүхий нэгнийхээ бие, эрх чөлөөнд халдсан байна.

Цагдаагийн байгууллага нь Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаас гадна гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх талаар дараах үүргийг хүлээнэ:

1.Хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн талаарх бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглах;

2.Гэр бүлийн хүчирхийлэл илэрсэн буюу үйлдсэн мэдээллийг хүлээн авч, шаардлагатай тусламж, зөвлөгөө өгөх, холбон зуучлах утас 24 цагаар ажиллуулах зэрэг.

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль//2017. Төрийн мэдээлэл №5

Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно.

Мөн цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн тухай мэдээллийг хүлээн авч, шаардлагатай тусламж, зөвлөгөө өгөх, холбон зуучлах нэгжийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах, үйлчилгээ үзүүлэх ажилд сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтныг оролцуулах үүргийг хүлээнэ.

Тус газраас сүүлийн 3 жилийн хугацаанд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” дэд зөвлөлтэй хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогч иргэдийг хамгаалах, ажилтан, алба хаагчдыг сурган дадлагажуулах, иргэд, олон нийтэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиг хандлагыг төлөвшүүлэх, хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ, бүтээн байгуулалтын чиглэлээр Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, Дэлхийн зөн Монгол зэрэг олон улсын байгууллага, Швейцарын хөгжлийн агентлаг болон төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан. Үүнд:

ЦЕГ нь 2021 онд Нэгдсэн үндэстний байгууллагын “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд “Би ... байна”, “Хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай” урьдчилан сэргийлэх, ерөнхий, соён гэгээрүүлэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулсан.

Дээрх арга хэмжээний хүрээнд хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл нэмэгдэж, түүний хор уршгийн талаар иргэдийн ойлголт, мэдлэг, насанд хүрээгүй хүн хохирсон хүчиндэх гэмт хэргийн илрүүлэлт 6.4 хувиар өссөн, сургуулийн орчинд гэмт хэрэг бүртгэгдээгүй зэрэг үр дүнтэй нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулагдсан.

Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, иргэдийн мэдээлэх үүргийг нэмэгдүүлэх зорилгоор Цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарын утсанд “МЕССЭЖЭЭР” мэдээлэл хүлээн авах, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн www.e-khutuch.mn цахим хуудсыг ашиглан интернэт орчинд гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийг цагдаагийн байгууллагад мэдэгдэх ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, IDLO Олон Улсын хөгжлийн эрх зүйн байгууллага, Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран үүсгэн байгуулан ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/265 дугаар тушаалын дагуу гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх алба хаагчдын чадавхжуулах сургалтыг Өвөрхангай, Ховд, Дорнод, Дорноговь, Дархан-уул аймагт бүсчилсэн байдлаар зохион байгуулж, 216 алба хаагчийг хамруулсан¹.


Энэ онд нийгмийн ажилтан, сум, багийн 543 хамтарсан багийг чадавхжуулах, эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүчирхийлэл үйлдэгчдэд нэг бүрчилсэн хяналт тавих аргачлал сэдвээр давхардсан тоогоор 1858 удаагийн цахим уулзалт, сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж, 1283 төрлийн 25600 ширхэг зурагт хуудас, 228 төрлийн богино хэмжээний бичлэгийг 621 телевиз, 233 радио, 7110 сайтаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг үр дүнтэй зохион байгуулсан.

¹ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/265 дугаар тушаал

Тус газар нь 2022 онд Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан хамтран хэрэгжүүлж буй “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн Удирдах хорооны хуралд оролцож, цагдаагийн байгууллагаас уг төслийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, 2023 онд хамтран хэрэгжүүлэх ажил, түүнд зарцуулах төсвийн саналыг танилцуулж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, НҮБ-ын ХАС-ийн суурин төлөөлөгч нар 2020-2023 онуудад хамтран ажиллах гэрээ байгуулж, 2022 онд хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөө баталсан.

Төслийн хүрээнд Жендерийн үндэсний хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сантай хамтран Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан Жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаарх ойлголт мэдлэгийг олон нийтэд хүргэх, эрэгтэй, эмэгтэйчүүдэд тулгарч буй жендерийн асуудлыг мэдээлэх, холбогдох төрийн байгууллагад хүргэх, олон нийтийн дуу хоолойг сонсох, асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор зохион байгуулсан “Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд “Хайраа хайрлая, хандлагаа өөрчилье, хамтдаа үлгэрлэе” уриан дор хамтран оролцсон.

Зураг 36. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох ажлын үр дүн ямар байгууллагаас хамаарах талаар иргэдийн саналыг харуулав.



Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/83 дугаар тушаалаар баталсан “Аюулын зэргийн үнэлгээ хийх журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн бүртгэлийн “Гэр бүлийн хүчирхийллийн улмаас” сонголтод “Өндөр”, “Дунд”, “Бага” гэсэн сонголтыг нэмж, тайлан мэдээнд тусган оруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, өөрчлөлт хийгдсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” /код-326/-д нэмэлт өөрчлөлт оруулахаар гэр бүлийн болон

хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэж болзошгүй хүнд нэг бүрчилсэн хяналт хэрэгжүүлэх, хяналтын бүртгэлийн 13 маягт, мэдээний хүснэгтийг шинэчлэн боловсруулж, Хуулийн хэлтэст албан бичгээр хүргүүлэн танилцуулсан.

Цагдаагийн албаны тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах 4 бүлэг, 19 төрлийн зөвлөмжийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлсэн.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангаас энэ оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс 10-ны өдрийн хооронд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байранд хохирогчид шууд тусламж, үйлчилгээ үзүүлдэг 50 ажилтан, алба хаагч нарт Дархан, Хөвсгөл аймгийн Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцуулах, туршлага судлуулах ажилд тус хэлтсээс 2 алба хаагч оролцож, оролцогч нарт “eGBV дата системийн менежмент, хэрэглээ, мэдээлэлд байгаа асуудал” сэдвээр мэдээлэл өгч, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.

Дэлхийн гэр бүлийн өдөр 05 дугаар сарын 15-нд зориулж гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөл арилгах зорилгоор нийгэмд эерэг байдлаар нөлөөлөх зорилгоор гэр бүлийн халуун, дулаан уур амьсгалыг харуулсан, орчин үеийн буюу “Z” үеийн залуучуудад зориулсан хүчирхийлэлгүй нийгмийн хандлагыг төлөвшүүлэх зорилготой 3 шторк, 11 постер, ФМ радиогоор цацагдсан аудио бичлэг, хэвлэлийн 2 мэдээ бэлтгэж, хэлтсийн пэйж хуудас, Go go.mn, Toim.mn, Zaluu.com, Arslan.mn сайт, ФМ-104.5, ФМ-88.9 радиогоор түгээхэд давхардсан тоогоор 482,506 хүн үзэж, 37493 хүн бусадтай хуваалцсан.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд “Гэр бүлийн үнэ цэнэ” өдөрлөгийг Гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн газартай хамтран зохион байгуулж, урлагийн тоглолт, бүтээлийн үзэсгэлэн, хүүхдүүдийн дунд уралдаан, тэмцээн, спорт эмчилгээ, хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ зэрэг арга хэмжээг явуулж, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл өгч ажилласан.

Тус өдөрт зориулж “IDLO” Олон улсын байгууллагатай хамтран 1 видео, 10 зурагт постер хийх хуулийн этгээдийн үнийн судалгааг хийж, видео, постерийн зохиолыг хянуулан зураг авалт, бичлэг хийх ажлыг гүйцэтгүүлж, хүлээн авч иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.

Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл, зөрчлийг шалгах алба хаагч нарт зориулсан гарын авлагыг эхийг боловсруулж, 2500 ширхэг хэвлүүлэн алба хаагчдад тараасан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” хамтарсан багийн Үндэсний чуулганы бэлтгэл ажил, зохион байгуулалтад оролцож, энэ оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулахад цагдаагийн 476 алба хаагч оролцсон.

Гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “Нандин бүхнээ хамгаалъя” урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, аян, арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж, төлөвлөгөөг боловсруулан төрийн болон төрийн бус

байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран энэ оны 11 дүгээр сарын 25-наас 16 хоногийн арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

Арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулахаар 175.456.000 төгрөгийн төсвийг Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүн амын сан, Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслийн төсвөөс шийдвэрлүүлсэн.

Тус арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, зөвлөмжийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагч байгууллагуудын төлөөлөл нээлтийн мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллагуудыг оролцуулан шууд дамжуулалт хийж, иргэд олон нийтэд хүргэсэн. Арга хэмжээний ковер, баннер, пост, видео, зурагт хуудас, гарын авлагыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хийж, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Дээрх арга хэмжээний талаар хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, нийтийн цахим сүлжээгээр тавигдсан мэдээ, мэдээлэл, контент нь иргэд, олон нийтийн талархлыг хүлээн, иргэдээс эерэг сэтгэгдэл илэрхийлж, арга хэмжээний хугацаанд 107 тусгай дугаарын утсанд нийт 927 дуудлага, мэдээлэл бүртгэсэн нь өмнөх оны мөн үеэс 117 нэгж буюу 12.6 хувиар өссөн байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сантай хамтран “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Хүүхэд хамгааллын, Хүүхдийн эрхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, дуудлага, мэдээлэл шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх, чадавхжуулах зорилгоор 2 хоногийн бүсчилсэн сургалтыг Увс, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Орхон аймаг, Улаанбаатар хотод зохион байгуулж, Нийслэлд 110, орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсээс 176 алба хаагчдад нийт 286 алба хаагчдыг хамруулсан.

Мөн Жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор 370 төрийн болон төрийн бус байгууллага, 110 аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран нийт 1026 удаагийн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж, 41778 иргэн, 14310 багш, нийгмийн ажилтанд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэдвээр, 75624 ерөнхий боловсролын сургуулийн сурагч, оюутнуудад “Үе тэнгийн дээрэлхэлт”, “Цахим гадуурхал”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт”, “Аюулгүйн дүрэм” зэрэг насны онцлогт тохирсон сэдвээр тус тус мэдээлэл сургалтыг зохион байгуулсан.

Бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Баян-Өлгий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д 3 ажлын байрны орон тоо, цалинд 40.0 сая төгрөг, Булган аймгийн цагдаагийн газраас “Түр хамгаалах байр”-ны цэвэр, бохир, дулааны шугамын холболтод 50 сая, Сүхбаатар аймгийн орон нутгийн төсөвт 130.0 сая төгрөгийн төсөв хүргүүлж, 90.0 сая төгрөг батлуулж, “Хамгаалах байр”-ны үйл ажиллагааг чанартай, тогтмол явуулах зорилгоор бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг нөхөн сэргээх “Үжин төв”-тэй хамтран ажиллах “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулж, “Түр хамгаалах байр” болгон ажиллуулсан.

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албатай хамтран 5.2 сая төгрөгийн санхүүжилтээр “Гэр бүлийн хүчирхийллийн

хоширогч төвтэй хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх нь” сургалт, мөн Булган аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 22 хамтарсан багийн үйл ажиллагаанд 6.6 сая төгрөг, мөн Сүхбаатар аймгийн Засаг дарга 1.3 сая төгрөг, Хөвсгөл аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 14 хамтарсан багийн дунд болзолт уралдааныг зохион байгуулж, 2.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус шийдвэрлүүлэн ажилласан байна.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 19 удаагийн чадавхжуулах сургалт, 1 хэлэлцүүлэг, 1 болзолт уралдааныг тус тус зохион явуулж, хамтарсан багийн 1753 дарга, гишүүдийг хамруулсан.

Мөн цагдаа, прокурор, шүүгч, өмгөөлөгч, шүүхийн шинжилгээний байгууллагын 1172 алба хаагчдыг чадавхжуулах чиглэлээр 2, мэргэшүүлэх чиглэлээр 21 удаагийн сургалт, зөвлөгөөнийг тус тус зохион байгуулан ажиллажээ.

Гэр бүлийн боловсрол, эрүүл эерэг харилцаа, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл, зөвлөгөө, тусламж үзүүлэх <https://familycenter.mn> цахим хуудсыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах ажлын алба, www.e-khutuch.mn цахим хуудсыг Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран үйл ажиллагаандаа ашиглах ажлыг эхлүүлсэн.

Мөн цагдаагийн байгууллагаас иргэдийн эрхийг хамгаалах, цагдаагийн байгууллагын ажлыг шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор мессежээр дуудлага мэдээлэл хүлээн авах, өргөдөл гомдол, мэдээлэл өгсөн иргэнд шалгалтын үйл явц, хаана, хэн хариуцан ажиллаж байгаа талаар мэдээллийг мессежээр илгээх, дүрсээр /видеоколл/ мэдээлэл хүлээн авах, баримтжуулах, хаяг байршлаа хэлж мэдэхгүй иргэдэд зориулсан “what treewords Mongolia” апп-аар хаяг байршил тогтоон очиж ажил үйлчилгээг үзүүлэх зэргээр техник технологийн дэвшлийг нэвтрүүлэн ажиллаж байна.

2023 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр шинэлэг инновац, бүтээж ашиглах, сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулах талаар төслийн санал боловсруулж, 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 2/51 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдад хүргүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа “баривчлах байр”, “баривчлах төв”-д гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэн шийтгэл эдэлж буй иргэдийг шуурхай хүлээлгэн өгөх, тэдгээр иргэд Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд зааснаар хэдэн удаа баривчлагдаж ирж байгаа бүртгэлийг цахимжуулах болон бусад чиглэлээр хамтран ажиллах талаар албан хүсэлтийг 2021, 2022 онд нийт 2 удаа хүргүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд “Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд нийслэлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, аймаг, суманд цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ. Цагдаагийн байгууллага баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх чиг үүргийг энэ зүйлд заасан хугацааны дотор үе шаттайгаар шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад шилжүүлнэ” гэж заасан боловч, тухайн хуулийн 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн өөрчлөлтөөр шилжүүлж дуусах хугацааг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл гэж өөрчилж, хойшлуулсан. Орон нутагт өнөөдрийн байдлаар Баян-Өлгий, Дорноговь, Завхан, Ховд, Хэнтий, Архангай зэрэг 16 аймаг, 4 сумын төвд 301 хүний багтаамжтай, 59 өрөө бүхий 20 байранд баривчлах шийтгэл

оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэх чиг үүргийг цагдаагийн байгууллага хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 01 дүгээр сард Булган, Дорнод, Дундговь, Увс, Орхон аймаг дахь баривчлах чиг үүрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлж өгсөн. Албадан сургалтын чанарыг дээшлүүлж ажиллах талаар хэрэгжүүлэх 2 санал бүхий танилцуулгыг Тэргүүн дэд даргад энэ оны 03 дугаар сарын 10-ны өдөр бичгээр танилцуулсан.

Монголд Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албатай хамтран Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/123 дугаартай тушаалын дагуу Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, орон нутгийн 14 цагдаагийн газар, хэлтсийн нийт 27 сэтгэл зүйчдэд 2023 оны 05 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд онол, дадлага, мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээ, сэтгэл зүйн багц хэрэглэгдэхүүн бүхий цогц мэдлэгийг олгох сургалтыг зохион байгуулж, Улаанбаатар цагдаагийн хүрээний 27 сэтгэл зүйчийг Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаментын хүүхэд хамгааллын компакт гэрээний төслөөс санхүүжүүлэн арттерапии гарын авлагаар ханган ажилласан.

Жендерт суурилсан хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл, үйлдэгчийн бүртгэл, хяналтыг сайжруулж, гэмт зан үйлээс татгалзуулах, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “Бүртгэл” ерөнхий арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд өдөрлөг 6, сургалт 20, тэмцээн уралдаан 1 тус тус зохион байгуулсан ба Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Гүйцэтгэх ажил явуулах /код 307/ журам”-д заасны дагуу алба хаагчдаас 291 /нийслэл 67, орон нутаг 224/ илтгэх хуудас бичиж ирүүлснээс 15 гэмт хэрэг, 4 зөрчлийн шинжтэй мэдээллийг тогтоон илрүүлсэн, мөн “Судалгаа хяналт сан”-д гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч 585 иргэний мэдээллийг бүртгэж ажилласан.

Арга хэмжээний хүрээнд нийслэлийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй иргэдийн бүртгэл судалгааг гаргаж, дуудлага мэдээллийн давтамж, хүчирхийллийн хэлбэр зэргийг харгалзан үзэж, 752 иргэнд нэг бүрчилсэн хяналт тавьж, 240 иргэнийг хяналтаас хасаж, харьяаллын дагуу 19 иргэний мэдээллийг шилжүүлж, шинээр 282 иргэнийг нэг бүрчилсэн хяналтын бүртгэлд авч, хувийн хэрэг нээж ажилласан.

Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25.1.1-д заасны дагуу гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн талаарх бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мөн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх /код-326/ журам”-д заасны дагуу гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг нийт 1547 иргэдэд нэг бүрчилсэн хяналт тавьж, үүнээс 2 буюу түүнээс дээш удаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 585 этгээдэд шинээр хяналтын хувийн хэрэг нээн бүртгэлд авч, 254 иргэний хяналтын хувийн хэргийг хааж ажилласан байна.

Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сантай хамтран “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зүй” сэдэвт бүсчилсэн сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд Сүхбаатар, Дорноговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Баян-Өлгий, Улаанбаатар хотод бүсчилсэн байдлаар зохион байгуулж, орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсээс 205 /цагдаагийн газар, хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн дарга, мөрдөгч, Нийтийн хэв журам хамгаалах

тасгийн дарга, Шуурхай удирдлагын тасгийн дарга, эрүүгийн мөрдөгч, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч, /Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа газар, хэлтсээс 88/ дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн дарга, ахлах мөрдөгч, мөрдөгч, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагч, байцаагч, Шуурхай удирдлагын тасгийн дарга, эрүүгийн мөрдөгч, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэргэжилтэн, хэсгийн байцаагч/, нийт 293 алба хаагчийг хамруулсан.

Цагдаагийн ерөнхий газар нь Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэй “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн нэгдсэн сан” үүсгэн, 2018 оны 04 дүгээр сараас ажиллуулж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн сан нь цагдаагийн байгууллагад бүртгэсэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлсэн тусламж үйлчилгээ, хүчирхийлэл үйлдэгч этгээдийн талаарх мэдээллийг нэгтгэсэн, Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байранд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, гэр бүлийн гишүүд, хүүхэд бүртгэсэн талаарх мэдээллийг агуулсан дахин ашиглах боломжтой цахим мэдээллийн бааз.

Мэдээллийн сан нь Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны мэдээллийг агуулсан, веб сайт буюу цахим хуудас хэлбэрт суурилсан программ хангамж учир нууцлалын зэрэгт хамаарах бөгөөд зөвшөөрөгдөөгүй хандалтаас хамгаалагдсан байна.

Мэдээллийн санд нэвтрэх эрхийн жагсаалтыг Цагдаагийн байгууллагаас батлах бөгөөд энэ эрхийн хүрээнд цагдаагийн байгууллагын мэдээллийн санд нэвтрэх эрх нууц кодоор дамжуулан олгогдож, цагдаагийн байгууллагын дарга нар нэвтрэх эрхийн кодын ашиглалт, нууц хадгалалтад хяналт тавих бөгөөд алба хаагч кодыг ажлын байрны зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд ашиглаж, бусад зорилгоор ашиглах, бусдад шилжүүлж ашиглуулахыг хориглоно.

Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн сан үүсгэж байгаа нь энэ төрлийн статистик мэдээллийг нарийвчлан гаргах, төрийн болон төрийн бус байгууллагуудын мэдээллийг харилцан солилцох, дүн шинжилгээ хийх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг зөв тодорхойлох боломжтой болсон.

Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэргийн болон хохирогчид Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байраар үзүүлсэн тусламж үйлчилгээний талаарх <https://gbv.police.gov.mn/> мэдээллийн нэгдсэн санг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны ETuslamj мэдээллийн сантай холбох ажлыг Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сангийн санхүүжилтээр мэдээллийг давхардуулан бүртгэхгүйгээр, байгууллага хоорондын мэдээллийг шуурхай солилцох боломжтой болгон өөрчилж ашиглалтад оруулсан.

Цагдаагийн байгууллага НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэй Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд дуудлага, мэдээллийн “ECS” систем болон бусад мэдээллийн санг шинэчлэх ажлыг үе шаттай хийсээр ирсэн. Энэ удаад иргэний регистрийн дугаарыг дуудлага, мэдээлэл дээр газар дээр нь очиж ажилладаг эргүүлийн цагдаагийн алба хаагч, түүнд хяналт тавьдаг дарга, ахлахуудын ашигладаг албаны таблет төхөөрөмж, компьютерт нь шууд холбож өгснөөр гэр бүлийн

хүчирхийлэл үйлдэгч этгээдийн өмнөх түүх, дуудлага, мэдээллийн давтамж, хүчирхийлэл үйлдэгч, хохирогч, тэдний гэр бүлийн боломжит бүхий л хувийн болон хэрэг, зөрчлийн мэдээллийг ганц хоёрхон сонголтоор дарж гаргаж ирэх боломжтой болсноороо онцлог юм.

“ECS” программын шинэчлэлийн хамгийн чухал ач холбогдол нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн регистрийн дугаараар шууд мэдээлэл авдаг болсон ба энэ нь Монгол гэр бүл, тухайн гэр бүл дотор байгаа хүүхдийн дахин, дахин хүчирхийлэлд өртөх эрсдэлийг бууруулах, цагдаагийн алба хаагчаас богино хугацаанд оновчтой зөв шийдвэр гаргах, цаашлаад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээд ямар нэгэн шийтгэлгүй өнгөрөх явдлаас сэргийлэх, хууль зөрчсөн үйлдэл бүрийг мэдээллийн санд бүрэн гүйцэд бүртгэж, хариуцлага заавал байх хуулийн зарчмыг хэрэгжүүлэх, Монгол гэр бүлийн амар тайван аюулгүй байдлын төлөө хийгдсэн ажил юм.

Мөн холбогдогч, хохирогчийн урьд өмнө өгсөн дуудлага мэдээллийн түүх, удаа дараагийн давтан үйлдлийг нэгдсэн сангаас регистрийн дугаараар авч, гэмт хэрэг зөрчлийн нөхцөл байдлыг бодитоор тодорхойлох, өөрийн болон хохирогчийн аюулгүй байдлыг хангаж, хяналтыг сайжруулах, өмнөх гаргасан зөрчлийг нотлох баримтаар ашиглах, шийдвэрлэлтийн үр дүнг ахиулах зэрэг ач холбогдолтой болсон.

4.2.2. Орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон төрийн удирдлагын байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1) харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

2) хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

3) орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

4) орон нутгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон төлөвлөгөөний төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5) хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;

6) хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

7) гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх;

8) гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах;

9) хуульд заасан бусад.

2016 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (шинэчилсэн найруулга)-аар гэр бүлийн гишүүдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, шаардлагатай үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий хамтарсан багийн эрх зүйн үндсийг тогтоожээ.

Хамтарсан багаас Гэр бүлийн тухай, Хүүхдийн эрхийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, түүний үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/173, А/251, А/380 дугаар тушаалаар “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”¹-ыг баталжээ. ГБХТ тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой 32 журмыг төрийн эрх бүхий байгууллагуудаас батлан хэрэгжүүлж байна.

Хамтарсан баг нь өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахална.

Хамтарсан баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1) гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах;

2) хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;

3) нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

4) хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;

5) хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх;

6) хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаарх статистик мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх.

Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журмыг нийгмийн хамгааллын, хууль зүйн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг” гэдэг нь хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд ГБХТ тухай хуульд заасан үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэр бөгөөд гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт шатанд илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг нөхөн сэргээхэд чиглэсэн цогц үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтнүүдийн баг юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар сум,

¹ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/173, А/251, А/380 дугаар тушаал

хороонд хамтарсан баг байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих үүргийг аймаг нийслэл, сум, дүүргийн ИТХ-д хүлээлгэсний дагуу мониторингд хамрагдсан хороо, багийн түвшинд хамтарсан багийг байгуулах шийдвэрийг тухайн баг, хороо, дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол болон Засаг даргын захирамжаар гаргасан байна. Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журмаар сум, баг, хорооны эрүүл мэндийн нийгмийн ажилтан, нийгмийн бодлогын мэргэжилтэн, шаардлагатай бол цэцэрлэгийн арга зүйчийг оролцуулахаар бүрэлдэхүүнийг нэмж өргөжүүлжээ¹.

Хамтарсан багт орж ажиллаж байгаа бүх мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтод хамтарсан багт ажиллахад гүйцэтгэх үүргийг нь тусгаж өгөх, уг ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ хэр биелүүлсэнтэй холбон ажлыг нь үнэлж дүгнэх шаардлагатай. Үүнээс гадна хамтарсан багийн гишүүний дээд шатанд ажиллаж байгаа төрийн захиргааны байгууллагын албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод тусгахгүй, зөвхөн доод шатны ажилтны тодорхойлолтод тусгах нь ач холбогдол багатай байна.

Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс

Хамтарсан багийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, албан тушаалын тодорхойлолтыг батлан мөрдүүлэх чиглэлд зарим ахиц гарсан боловч удирдах шатны албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолтод хамтарсан багт ажиллах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг тусгагдаагүй учир өөрийн үндсэн үүрэг бус, нэмэлт ажил гэж үзэж байгааг судлаачид тэмдэглэсэн байна².

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-ын хэрэгжүүлсэн “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хамтарсан багийн хүлээсэн үүргийн хэрэгжилт” мониторингийн тайланд дараах зөвлөмжийг өгсөн боловч энэ зөвлөмж өнөөг хүртэлх бүрэн хэрэгжээгүй байна гэж бид үзлээ. Үүнд:

1) Хамтарсан багуудын үйл ажиллагаа явуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хохирогчтой ганцаарчлан уулзах тусгай өрөө бий болгох, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах;

2) Хамтарсан багийн гишүүд, түүний удирдах албан тушаалтантай байгуулах үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод ГБХТ тухай хуулиар хүлээсэн чиг үүргийг тодорхой тусган батлах;

3) Хамтарсан багийн үйл ажиллагааны төсөв, санхүүжилтийн асуудлыг хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй нь уялдуулан нэг мөр шийдвэрлэх;

4) Хамтарсан багийн нарийн бичгийн даргаар мэргэжлийн нийгмийн ажилтнуудыг ажиллуулах, тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлэх урамшууллын систем бий болох;

5) Хамтарсан багийн түвшинд хөтөлж буй судалгааг нэг мөр болгож, мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоонд оруулан цаашид бодлого тодорхойлоход ашигладаг болох;

6) Хамтарсан багийг мэргэжлийн арга зүйгээр хангах, сургах, чадавхжуулах ажлыг тасралтгүй, системтэй зохион байгуулж, сургалтын нэгдмэл тогтолцоог бүрдүүлж ажиллах;

7) ГБХ, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагуудыг орон нутагт хүрч ажиллахад дэмжлэг үзүүлэх;

¹ ХНХ-ын сайд, ХЗДХ-ийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/173, А/259, А/380-р тушаалаар батлагдсан “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам 2.1. дэх заалт

² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хамтарсан багийн хүлээсэн үүргийн хэрэгжилт (Мониторингийн тайлан). Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ. Уб., 2021.

8) ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг архидан согтуурахтай тэмцэх ажилтай уялдаатай явуулах зэрэг.

4.2.3. Төрийн байгууллагын зэрэгцээ төрийн бус байгууллагууд түүний дотор олон улсын байгууллагууд тодорхой ажлыг зохион байгуулж байна. Монгол дахь Японы “Хүүхдийг ивээх сан”-гаас Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж, үүрэг хүлээгчдийг чадавхжуулах чиглэлээр 2022 онд идэвхтэй бөгөөд амжилттай ажиллалаа. Энэ сан нь кейс менежментийн чанарын үнэлгээг хийж, хамтарсан багуудыг сурган, сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч, даван туулагчид ээлтэй үйлчилгээ үзүүлэх арга зүйг мэргэжилтнүүдэд танилцуулж, хүмүүжлийн эерэг аргыг түгээхийн зэрэгцээ, хүүхэд хамгааллын судалгаануудыг хийж гүйцэтгэлээ.

НҮБ-ын Итгэлцлийн сангийн санхүүжилттэй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийг Улаанбаатар хотын нийгэм, эдийн засгийн түвшин доогуур 5 дүүргийн 12-18 насны охидыг КОВИД-19 цар тахлын хүчин зүйлийн улмаас хүндэрсэн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэлээс эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан хамгаалах зорилгын хүрээнд хэрэгжүүлж байна.

Японы Олон Улсын Хамтын ажиллагааны агентлагийн (ЖАЙКА)-гийн санхүүжилттэй “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хоёрдугаар үе шатыг бүс, орон нутгийн түвшинд хүүхэд хамгааллын хамтарсан багийг чадавхжуулахад ажлын байранд зөвлөгөө өгөх, кейс хурал зохион байгуулах, кейс менежмент хийх чиглэлээр үргэлжлүүлэн хэрэгжүүлж дуусгалаа. Түүнчлэн эцэг эх, асран хамгаалагч, сурган хүмүүжүүлэгч нарт хүмүүжлийн эерэг аргын сургалтыг зохион байгуулж, Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулиудын хэрэгжилтийг дэмжин ажиллаж, хүчирхийлэл хэрэглэхгүйгээр хүүхдийн хүмүүжил, суралцахуйг чиглүүлэхийг сурталчлан ажиллалаа¹. Хүүхэд хамгааллын энэхүү хоёр төслийн хүрээнд “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн суурь судалгаа, Нөхцөл байдлын үнэлгээ, Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн стандартыг үнэлэх судалгаа, “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн эцсийн үнэлгээ, Кейс менежментийн чанарын үнэлгээ зэрэг нийт 5 судалгаа хийж, сургалтын нийт 16 модуль боловсруулж, 130 иргэний нийгмийн байгууллага, 150 төрийн, олон улсын болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж бид шууд 14,000, шууд бусаар сая гаруй хүнд хүрч ажиллажээ.

Виктимологийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд нь практик үйл ажиллагаанд зохих ёсоор зохион байгуулагдсан, холбогдох мэдээллээр хангагдсан байх ёстой. Иймд зохион байгуулалтын дараах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай юм:

1) Виктимологийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэлээр мэргэжилтнүүдийг бэлтгэх (энэ зорилтыг шийдвэрлэхийн тулд юуны өмнө Хууль зүйн үндэсний төвд виктимологийн сургалтын тусгай нэгж байгуулах);

2) Хууль зүйн албанд виктимологийн мэргэжлийн сонголт хийх (Сонгон шалгаруулалтад оролцогчдын сэтгэл зүйн шинж чанар, мэргэжлийн үүргээ биелүүлэх явцад аюултай тохироог зохих түвшинд баримжаалах чадварыг тооцох хэрэгтэй юм;

¹ Хүүхдийг ивээх сангийн 2022 оны үйл ажиллагааны тайлан//УБ

3) Хуулийн байгууллагын олон нийттэй харилцах болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алба нэгжийн хүрээнд зөвлөгөө өгөх болон сэтгэл зүй-сурган хүмүүжүүлэх нэгжийг нэгтгэн зохион байгуулж, түүний бүрэлдэхүүнд гүйцэтгэх албаны туршлагатай ажилтнууд, хамгаалалтын техник, сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэх салбарын мэргэжилтнүүдийг заавал оруулах шаардлагатай. (Зөвлөгөө өгөх ажлын: а/ эд хөрөнгийг хамгаалах техник хэрэгслийн талаар зөвлөгөө өгөх; б/ виктимологийн түгшүүртэй нөхцөл байдал үүсэх үеийн зан үйлийн баримтлах чиг шугамын талаар зөвлөгөө өгөх зэрэг хоёр үндсэн чиглэл байж болно. Зарим этгээдэд нөлөөлөх явцад сэтгэл зүйн маш нарийн төвөгтэй тохироонд орох нь цөөнгүй учраас сэтгэл зүйн мэргэжилтнүүд нь эрүүгийн эрэн сурвалжлах ажлын бүрэлдэхүүнд туслаад зогсохгүй, мөн хохирогчийг мэргэжлийн талаас нь судлах ажлыг зохион байгуулж чадна);

4) Гэмт хэргийн улмаас урьд нь хохирсон, бодитойгоор хохирч болох этгээдүүдийн гэмт хэрэгт өртөгдөх эрсдэлийн урьдчилан сэргийлэх тоо бүртгэлийг /виктимологийн тоо бүртгэл/ зохион байгуулах (Гүйцэтгэх ажлын шугамаар сонирхол татаж байгаа этгээдүүдийн урьдчилан сэргийлэх тоо бүртгэлийн өнөөгийн тогтолцоо нь виктимологийн шинж чанарыг тооцоогүй учраас мэдээллийн бодит эх сурвалж болж чадахгүй байгаа юм. Мөн гэмт хэрэгт хохирч болох өндөр эрсдэл бүхий хуулийн ажилтнууд анхаарлын төвөөс гадна үлдэж байна. Хэрэв хохирч болзошгүй этгээд нь гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдтэй “холбогдож, эхэлсэн” нь хуулийн байгууллагад илэрхий болбол тохиолдол бүрийг бүртгэн авах шаардлагатай);

5) Виктим харилцааны хувьд хамгийн аюултай газар орон зай, объектын тухай мэдээллийн тусгай санг /бүртгэлийн карт, хэрэг нээж хөтлөх/ бүрдүүлэх (Эдгээр баримт бичгүүд нь: а/ тухайн газар нутаг, тухайн объектод үйлдсэн гэмт хэргийн тоо болон чанарын үзүүлэлтүүд; б/ тухайн газар нутаг, объектод бат тогтвортой “дасан зохицсон” гэмт хэрэгтэн, тэдгээрийн хохирогчдын нийтлэг хэв маяг; в/ эрүүгийн тохироо үүсч хэрэгжих хамгийн нийтлэг хэв шинж зэрэг. Эдгээр баримт бичгүүд нь гэмт хэрэг, гэмт хэрэгтэн, хохирогчийн тухай дэс дараатай мэдээллээр бүрэн баяжиж байх ёстой. Энэ мэдээлэлд тулгуурлан гэмт хэргийг шууд таслан зогсоохын хамт, гэмт хэргийн хохирогчийг “бэлтгэн нийлүүлж” байгаа этгээдүүдийн тооны өөрчлөлтөд тулгуурлан байдлыг тогтворжуулж, эрүүлжүүлэхэд тус дэм өгч болно);

6) Хуулийн бүх байгууллага, албад өөр хоорондоо буюу төрийн бусад ба төрийн бус байгууллагатай байнгын нягт хамтын ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх (Энэ нь юуны өмнө “ил” боломжуудын зэрэгцээ, шуурхай эрэн сурвалжлах арга хэрэгслүүдийг мэдээллийн эх үүсвэр, хохирч болзошгүй этгээдэд нөлөөлөх хэрэгслийн хувьд ашиглах боломжийг олгоно) зэрэг.

ТАВДУГААР БҮЛЭГ
МОНГОЛ УЛСАД ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ГЭР БҮЛИЙН
ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРСОН ХОХИРОГЧИЙН ЗӨРЧСӨН
ЭРХИЙГ НӨХӨН СЭРГЭЭХ НЬ

5.1. Гэмт хэрэгт хохирсон иргэдийн аюулгүй байдлыг хангах

НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын арван нэгдүгээр зүйлд: "...хуулийн дагуу гэм буруутай нь тогтоогдох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй" гэсэн зарчим нь Монгол улсын үндэсний хууль тогтоомжид нарийвчлагдан тусгагдсан билээ. Харин "Аливаа этгээдийн гэм бурууг батлах зорилгоор хэн нэгнийг гэм буруутан болгож болохгүй" гэсэн зарчим нь олон улсын болон үндэсний хууль тогтоомжид тусгалаа олоогүй, хэрэгжилт тодорхойгүй байсаар байна. Энэ нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын дунд хамгийн түгээмэл хэлбэрээр илэрч байгаа бөгөөд гэмт хэрэгт хохирохын хамт, гэрчлэхээс айсны төлөө "шийтгэл" хүлээж давхар хохирох тавилан ямар хэцүү байх бол¹ гэдгийг хэн бүхэн тааварлаж, төсөөлж чадах нь ойлгомжтой.

Өнөөгийн хууль зүйн практик, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сэтгэл зүйд эрүүгийн процессын ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах, хамгаалах асуудал зэрэгцээ хоёр шугамаар явагдаж байгаа нь нууц бишээ. Өмгөөлөх, шүүхийн байгууллага нь сэжигтэн, яллагдагчийн хууль ёсны эрх, эрх ашгийг илүүтэй хөндөж ярьдаг бол (энэ нь арай хурц тавигдаж байгаа), хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурорын байгууллагууд нь хохирогч, гэрчийн эрх ашгийг хамгаалах асуудлыг голчлон анхаарч байгаа нь хэнд ч нууц биш байгаа юм. Нэг тал нь яллах, нөгөө тал суллах хоёр тэмцэл бодитойгоор өрнөж байна гэхэд хилсдэхгүй. Энэ уралдаан өрсөлдөөний дунд хүний эрх хохирч байгаа юм.

Хохирогчийн аюулгүй байдлыг хангах, дахин хохирох явдлаас урьдчилан сэргийлэх, хамгаалахад хууль цаазын үзэл баримтлалыг боловсруулахад зарим анхдагч эхлэл, үндэслэлүүдийг нарийн тооцох хэрэгтэй юм. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлын талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль², Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль³, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль⁴, эдгээр хуулиудын хүрээнд дагалдан гарсан журам⁵-уудын хүрээнд зохицуулж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуульд зааснаар: 1) түр хамгаалан байрлуулах; 2) нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх; 3) Гэрч, хохирогчийг хамгаалах тухай

¹ Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. УБ., 2005. 482 дахь тал

² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль//2017. Төрийн мэдээлэл №23

³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль //2017. Төрийн мэдээлэл №5

⁴ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль// 2013.Төрийн мэдээлэл №30

⁵ Аюулын зэргийн үнэлгээ хийх журам; Биечилсэн хамгаалалтын журам; Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам; Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ журам; Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам; Гэрч хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах, аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам; Түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журам; Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзах уулзалтыг зохион байгуулах журам; Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага; Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам; Гэрч, хохирогчийг хамгаалах журам гэх мэт

хуульд заасан хамгаалалтын арга хэмжээнд хамруулах талаар хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Эдгээр хамгаалалтын арга хэмжээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан сонгож хэрэглэдэг. Шаардлагатай гэж үзвэл аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэж болох бөгөөд хамгаалалтад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр хуульчилсан.

Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын аюулгүй байдлыг хангах, хамгаалах арга хэмжээг дараах байдлаар авдаг байна. Үүнд:

1. *Төрөл садан, ойр дотнын хүний түр хамгаалалтад өгөх*¹. Аюулын зэргийн үнэлгээ хийгдсэний дараа “Өндөр” үнэлэгдсэн шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээ.

2. *Нэг цэгийн үйлчилгээ*. Эмнэлэг, төрийн бус байгууллагын харьяанд байрлах нэг цэгээс 1). аюулгүй байдлын хамгаалалт; 2). эмнэлгийн тусламж, үйлчилгээ; 3). сэтгэл зүйн үйлчилгээ; 4). нийгмийн халамжийн үйлчилгээ; 5). хүүхэд хамгааллын үйлчилгээ; 6). эрх зүйн туслалцаа; 7). холбон зуучлах үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй үзүүлэх төвийг хэлнэ.

3. *Түр хамгаалан байрлуулах*. Хохирогчийн амь нас, эрүүл мэндэд нөлөөлж болох этгээдийн зүгээс тодорхой цаг хугацаанд шууд тусгаарлах, эсхүл хайж олох боломжгүй тухайн цаг үеийн шаардлага, аюулгүй байдлын бодит нөхцөл байдалд нийцсэн эрх бүхийн төрийн байгууллагын болон ТББ-ын харьяанд байгаа байрлуулах арга хэмжээ.

4. *Урьдчилан сануулах*. Гэрч, хохирогчийг алах, бие мах бодид гэмтэл учруулах, тарчлаах, айлган сүрдүүлэх, дарамтлах, мөнгө, эд зүйл амлах болон бусад гэмт хэргийг үйлдэхээр заналхийлсэн нь тогтоогдвол тухайн этгээдэд хүлээлгэх ял шийтгэлийн талаар шүүгч, прокурор, мөрдөгч бичгээр урьдчилан сануулж гарын үсэг зуруулна.

5. *Тодорхой үйлдлийг хязгаарлах*. Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээнд гэрч, хохирогчтой уулзах, харилцах, харилцаа тогтоохыг оролдох, дагаж мөшгөх болон бусад хэлбэрээр харилцахыг хориглох арга хэмжээ хамаарна.

6. *Биечилсэн хамгаалалт*. Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авна. Биечилсэн хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлж болно.

7. *Мэдээллийн нууцлалыг хангах*. Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн овог, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөлд нь байгаа үл хөдлөх хөрөнгө, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаар зэрэг мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ авна. Шаардлагатай тохиолдолд халхавч нэр хэрэглэх, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаарыг өөрчлөх зэрэг арга хэмжээг эрх бүхий албан тушаалтан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

8. *Хувийн хамгаалалтын хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах*. Гэрч, хохирогчийг “Хувийн хамгаалалтын тухай хууль”-д заасан 1). Гав; 2). Хүлэг; 3). Резинэн ба цахилгаан бороохой; 4). нулимс асгаруулагч,

¹ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны а/37 дугаартай тушаалын хавсралт. Хохирогчийн аюулын зэргийг үнэлэх аргачлал

амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр; 5). Резинэн ба хуванцар сумтай буу зэрэг нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангаж шаардлагатай тохиолдолд түүний биед болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулж болно.

9. *Аюулгүй газарт түр байрлуулах.* Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогч тэдний хамаарал бүхий этгээд, гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, эсвэл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.

10. *Нүүлгэн шилжүүлэх.* Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлнэ. Гэрч, хохирогчийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэхэд түүний болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийн ажил, сургууль, амьдрах орон байр болон шаардлагатай бусад асуудлыг хамтад нь шийдвэрлэж болно.

11. *Баримт бичгийг солих.* Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн иргэний бүртгэлд өөрчлөлт оруулж, баримт бичгийг солино. Гэрч, хохирогчийн баримт бичгийг солих аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ (иргэний болон тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, гадаад паспорт, гэрлэлтийн баталгаа, диплом болон бүх төрлийн зөвшөөрөл зэрэг албаны баримт бичиг; эрүүл мэндийн болон нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж, цэргийн бүртгэл, эдгээртэй адилтгах нийгмийн хамгаалал, халамжтай холбоотой бусад баримт бичиг; хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрхийн гэрчилгээ; шаардлагатай бусад баримт бичиг зэрэг нь баримт бичгийн өөрчлөлт хамаарна) авдаг байна.

12. *Гадаад төрхийг өөрчлөх*¹. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалалтын өөр арга хэмжээгээр хангах боломжгүй тохиолдолд түүний зөвшөөрснөөр гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчилж болно. Гэрч, хохирогчийн гадаад төрхийг мэс заслын бус аргаар өөрчлөх (үс засалт, нүдний өнгийг өөрчлөх гэх мэт) хамгаалалтын арга хэмжээ авч болно².

“Статистикийн мэдээнээс үзэхэд дөрвөн гэрчийн нэг нь эрүүгийн процессын ажиллагааны явцад өөрийн мэдүүлгээс буцдаг байна. Хамгийн нягт нямбай мөрдсөн хэрэг ч энэ хугацаанд үр дүнгүй болох нь бий”³ гэх судалгаа байдаг бөгөөд “Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, хохирох болон дахин хохирохоос урьдчилан сэргийлэх, хууль цаазын үзэл баримтлалыг боловсруулахад зарим эрх зүйн онол, хууль зүйн практик, нийгмийн хэрэгцээ шаардлага, олон улсын эрх зүйн хөгжлийн чиг хандлага зэргийг нарийн тооцох хэрэгтэй”⁴ гэж зарим эрдэмтэд онцолжээ. Энэ нь хамгаалалтын арга хэмжээг олон төрлөөр авч, хохирогчид аюулгүй байдлыг хангах

¹ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль// 2013.Төрийн мэдээлэл №30

² Батбаатар, П. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлын онол, практикийн асуудал. -Уб., 2021. 153-155 дахь тал.

³ Нямсүрэн, Ч. Гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдлын зарим асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. -Уб., 2013. 31 дэх тал.

⁴ Батбаатар, П. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлын онол, практикийн асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. -Уб., 2021. 75 дахь тал.

баталгаа гаргаж байна гэж хамгаалуулагчийн зүгээс хуулийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлж байгаа тул “Төр ба иргэний харилцан хариуцлага хүлээх эрх зүйт төрийн зарчим мөн”¹ гэж үзжээ.

Гэсэн хэдий ч зарим тохиолдолд хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ хангалтгүй байгаа нь хууль, хүчний байгууллагад иргэд итгэх итгэлийг бууруулж байна.

Монгол Улсын шүүх засаглалд итгэх иргэдийн тоо багассаар. Хохирогчид болон ялангуяа хүүхдийг гэмт этгээдтэй нүүр тулгахгүйгээр шүүх хуралдаанд оролцуулдаг бөгөөд тоотой нэг, хоёрхон шүүхэд гэрч, хохирогчийн өрөөг бэлдэн, онлайн хэлбэрээр хүүхдийг шүүх хуралд оролцуулдаг байна. Ихэнх шүүхийн байранд хүүхэд болон гэрч, хохирогчийг тусгаарлан онлайн хэлбэрээр шүүх хуралд оролцуулах өрөө байдаггүй. Гэтэл хохирогчид шүүхийн байранд ирэхдээ эсхүл шүүх хуралдаан эхлэхийг хүлээж байх явцдаа амь нас нь эрсдэх, эрүүл мэндэд нь аюул учрах тохиолдол гарахыг үгүйсгэхгүй. Өмнө нь ч гарч байсан. Жишээлбэл, Гэрлэлтээ цуцлах гэж байсан гэр бүлийн нөхөр нь хамгаалах байрнаас шүүх хуралдаанд ирж байсан эхнэрээ 20 гаруй удаа хутгалж, амь насыг нь хохироож байсан харамсалтай тохиолдол гарч байсан².

Нээлттэй эх сурвалжаас

Энэ талаар судалгааны тайлангуудад³ дурдагдаж байсан ч ямар нэгэн дорвитой арга хэмжээ өнөөдрийг хүртэл авагдаагүй байна. Аюулгүй байдлаа бүрэн хамгаалуулж чадахгүйг мэдсэн хохирогчийг буруутгах арга байхгүй юм.

5.2. Хохирогчдын эмнэлэг, нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг

Хүчирхийллийн улмаас хүүхэд эмэгтэйчүүд нийгэм, эдийн засгийн амьдралд оролцох эрхээ бүрэн эдэлж чадахгүй, хохирогчийн бие махбод, сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байдаг. Мөн криминологи, виктимологийн шинжилгээ судалгааны явцад хохирогч нь гэмт хэргийн ёс суртахууны үр дагавар болох сэтгэцийн зовуурь, сэтгэл зүйн эмгэг, гэмтлийн дараах сэтгэцийн эмгэг хямрал (сэтгэцийн хямрал, мэдрэмжгүй болох, итгэл найдваргүй, ганцаардмал, доромжлогдсон байдалд орох гэх зэрэг), сэтгэцийн өвчин, эмгэг зэрэгт хамгийн их өртдөг байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрөл, байгууллагуудын эрх, үүргийг дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд: 1) Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт: “Нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий ажилтныг давтан сургах хөтөлбөр болон сургалт зохион байгуулах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих, үйлчилгээ үзүүлэх ажилтныг бэлтгэх, арга зүйгээр хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх”, 2) Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт: сэтгэл заслын үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх 3) Хамтарсан багт: “хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад

¹ Сальников, М.В. Право и закон в правовом государстве. //Правоохранительная деятельность и правовое государство. -СПб., 1995. С.24.

² https://judcouncil.mn/site/news_full/13463 - Шүүхийн ерөнхий зөвлөлийн веб сайт

³ ОУХЭЗБ (IDLO). Мониторингийн тайлан: Монгол улс дахь гэр бүлийн хүчирхийллийн хэргийн шүүх хуралдааны ажиглалт 2020. Уб. 2021

үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах, хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх”, 4) Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт: “сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх, асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээнд холбон зуучлах, хяналт тавих журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих”, 5) Төрийн бус байгууллагын чиг үүрэгт: “хохирогчид үйлчилгээг үзүүлэх үүрэг бүхий ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн арга зүйгээр хангахад дэмжлэг үзүүлэх” гэж зохицуулсан байна.

5.2.1. Хохирогчдод үзүүлэх эмнэлгийн тусламж. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Хувь хүний нууцын тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон дээрх хуульд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт, зааврыг баримтлан ажиллана.

Тодруулбал, Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам, Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, журам, Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам, Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам зэрэг байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль¹д: “Эмнэлгийн яаралтай тусламжаас бусад үйлчилгээг хохирогчийн байнга, эсхүл түр оршин сууж байгаа газрын нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага, хэрэв хохирогч эрүүл мэндийн байгууллага, хамгаалах байранд байгаа бол уг байгууллагын оршин байгаа газрын нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага үзүүлдэг байна. Тодруулбал, 1) Хүний амь насанд аюултай өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэхээс сэргийлэхэд чиглэсэн хойшлуулшгүй үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж, 2) Гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ; 3) Өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ зэрэг багтана.

Харин гадаадын хөгжилтэй орнуудад гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламжийг (а) хохирогчийг илрүүлэх; (б) анхны тусламж; (в) гэмтлийн яаралтай тусламж; (г) хүчингийн дараах цогц тусламж үйлчилгээ; (д) сэтгэцийн эрүүл мэндийн үнэлгээ, тусламж, (е) эмнэлэг - хуулийн баримтжуулалт зэргийг багтаан тодорхойлсон² байна. үүнийг хуулиар тодорхойлсон ЖСХ-д өртсөний дараа хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль //2017. Төрийн мэдээлэл №5

² UN Women, UNFPA, WHO etc., Essential Services Package for Women and Girls Subject to Violence, Core Elements and Quality Guidelines: Module 2: Health Services, 2016

хэтэрхий ерөнхий бөгөөд ДЭМБ-ын удирдамжтай бүрэн нийцтэй бус байна¹ гэж тодорхойлжээ.

Үүнийг судлаачид “Хүчирхийллийн эсрэг эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээг цаашид эрчимжүүлэхэд эрх зүйн зохицуулалт талаас олон улсын жишигт нийцүүлэн сайжруултал зохих зарим асуудлууд байгаа”² гэж тодорхойлсон байна.

Эрүүл мэндийн тусламж үзүүлэгч үйлчлүүлэгч нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн талаар цагдаад заавал мэдэгдэхийг олон улсын зөвлөмжүүдэд дэмждэггүй. Зөвхөн тухайн эмэгтэй хүсч байгаа тохиолдолд л эрүүл мэндийн тусламж үзүүлэгч холбогдох байгууллагад мэдэгдэхийг зөвлөдөг. Эрүүл мэндийн тусламж үзүүлэгч хуулийн дагуу мэдээлэх үүрэгтэй бол тэд мэдээлэхээсээ өмнө хохирогчид нууцлалын хязгаарлагдмал байдлыг үйлчлүүлэгчид тайлбарлах ёстой³.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 23, 27 дугаар зүйлд заасны дагуу эрүүл мэндийн тусламж үзүүлэгчид нь гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг холбогдох байгууллага цагдаад мэдээлэх үүрэг⁴ хүлээдэг. Хүчирхийллийн талаар цагдаагийн байгууллага болон бусад холбогдох байгууллагад мэдээлэхдээ хохирогчийн шийдвэрийг харгалзах, заавал мэдээлэх үүрэгтэй байх бол нууцлалын хязгаарлагдмал байдлын хохирогчид тайлбарлах асуудлууд одоогоор хуульд байхгүй⁵ талаар дурдсан байна.

5.2.2. Хохирогчид үзүүлэх нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг. Нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг нь үйл явдалд хувь хүний нийгэм болон сэтгэл зүйн аль аль хэрэгцээг хангахад чиглэсэн дэмжлэгийн цогц хэлбэр юм⁶. Нийгэм-сэтгэл зүйн дэмжлэгийг хямралд өртсөн хувь хүн, бүлэг болон олон нийтэд аливаа бэрхшээлтэй, аюултай, ямарч хүнд нөхцөлтэй тулгарахад даван туулахад туслах, хувь хүний чадварыг нэмэгдүүлдгээрээ бусад үйл ажиллагаанаас онцлогтой байдаг.

Нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг нь хүн амьдралаа дахин босгох, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлнэ. Хүчирхийллийг даван туулахад дэмжлэг үзүүлэхийн тулд хохирогчдод цаг хугацаанд нь тусламж үзүүлэх эрх зүйн зохицуулалт, арга, технологи, үр дүнгээс ихээхэн хамаардаг. Хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээ, дэмжлэгийг эмнэлэг, нийгэм сэтгэл зүйн гэж ангилж байна.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/394 дугаартай тушаалаар “Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”, “Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам”, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон, сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам”-ыг баталж, хэрэгжүүлж байна. Тодруулбал, Сэтгэлзүйн цочмог хариу урвалууд илэрсэн, сэтгэц, зан үйлийн эмгэг (айдсын эмгэг, сэтгэл түгших, нойрны, биеийн хэлбэрийн, сэтгэл гутрах ба сэтгэл хөөрөх эмгэг, гэмтлийн дараах стрессийн эмгэг, дасан зохицохуйн эмгэг, хувирах

¹ World Health Organization, Responding to intimate partner violence and sexual violence against women, WHO clinical and policy guidelines, Geneva, 2013

² Д. Баярболд. Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээний бэлэн байдал- үнэлгээний тайлан. УБ., 2023.

³ World Health Organizations, Strengthening health systems to respond to women subjected to intimate partner violence or sexual violence: a manual for health managers, Geneva, 2017

⁴ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль //2017. Төрийн мэдээлэл №5

⁵ Д. Баярболд. Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээний бэлэн байдал- үнэлгээний тайлан. УБ., 2023.

⁶ <https://redcross.mn/> - Монголын улаан загалмайн нийгэмлэгийн сайт

болон хуваагдах эмгэг, солиорох эмгэг)-т өртсөн хохирогчид сэтгэл заслын тусламж, үйлчилгээг үзүүлэх¹-ээр зохицуулсан байна.

Хүчирхийллийн хохирогчид нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, хамгаалах үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор явуулах хамтын ажиллагаа юм.

Хохирогчийн нийгмийн тусламжийн эрх нь: нийгмийн халамж, тусламж авах тухай мэдэх эрх; эд хөрөнгийн тусламж авах эрх; эмнэлгийн тусламж авах эрх; сэтгэл зүйн тусламж авах эрх; нийгмийн туслалцаа авах эрх; эрх зүйн туслалцаа авах эрх (байцаан шийтгэх ажиллагааны үед өөрийн эрх үүрэг, туслалцаа авах тухай мэдээлэл); дахин хохирох явдлаас урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл авах эрх зэргээс бүрдэнэ.

Нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай эрсдэлт нөхцөлд байгаа үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцүүлэн шууд үзүүлэх дэмжлэг, холбон зуучлалаар дамжуулан цаг хугацаанд нь тохиромжтой хэлбэрээр, системтэй шийдвэрлэх мэргэжлийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх арга зам юм².

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид кейс менежментийн аргаар замаар үйлчилгээ үзүүлж, жишиг нэгэнт тогтсон байна. Кейс менежментийг 1) Үйлчлүүлэгчтэй харилцаа холбоо тогтоох, илрүүлэх, 2) Нөхцөл байдлын үнэлгээ хийх, 3) Үйлчилгээг төлөвлөх, 4) Үйлчилгээг хүргэх, хэрэгжүүлэх, 5) Үйлчилгээг үнэлэх, 6) Үйлчилгээг хаах нь үйлчлүүлэгчид хэрэгтэй байгаа үед байнга үргэлжлэх процесс бөгөөд гол зорилго нь үйлчлүүлэгчийг шаардлагатай үйлчилгээнд нь холбон зуучилж, үйлчлүүлэгчийн уян хатан чанар, бие даасан байдлыг хөгжүүлдэг урт ба богино хугацааны аргыг хамарсан байдлаар тусламж³ үзүүлдэг байна.

5.3. Зөрчсөн эрхийг нөхөн сэргээх асуудал

Хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх асуудлын талаарх виктимологийн судалгаа харьцангуй сүүлд судлагдаж эхэлсэн⁴ ч ихэнх судлаачид зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чухал хэсэг үзжээ. Одоогийн албан ёсны “цээрлүүлэх” тогтолцоо буюу гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэлийг нь оногдуулах нь төр, нийгмийн ашиг сонирхлыг илүү өндөрт тавьж, гэмт хэрэгтний үйлдсэн гэмт хэргийг нотлох, түүнийг цээрлүүлэхэд илүү анхаарч, харин тэднээс үйлдсэн хэргийнхээ төлөө хүлээх хариуцлагаа ухамсарлах, үйлдлийнхээ үр дагаврыг арилгахад нь тусалж чадахгүй.

Зөрчигдсөн эрхийг сэргээх асуудлыг “Сэргээн босгох буюу шүүн таслах ажиллагааны хамгийн чухал ач холбогдол нь гэмт хэрэгт ял шийтгэл талаас нь бус харин талуудыг эвлэрүүлэх, хохирлыг арилгах байдлаар хандахад оршино”⁵ гэж виктимологичид тодорхойлжээ. Сэргээн босгох үзэл баримтлалын зорилго нь эрүүгийн

¹ Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/394 дугаартай тушаал “Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам”

² Нийгмийнажлын нийтлэг шаардлага MNS 6949:2021

³ З.Ундрах нар. ХЭҮТ-Кейс менежмент. Гарын авлага. Уб., 2023.

⁴ Алексеев А.И., Журавлев М.П., Миньковский Г.М. Проблемы уголовно-правовой и процессуальной защиты жертв преступлений // Актуальные проблемы управления и правового регулирования деятельности органов внутренних дел. – М.: Академия МВД России, 1994.

⁵ Нямсүрэн, Ч. Гэмт хэргийн виктимологи. Уб., 2005. 315 дахь тал.

процессын ажиллагааны төвд хохирогчийг тавьж, гэм буруутай этгээдэд өөрийн хийсэн үйлдлийнх нь төлөө хариуцлага хүлээлгэж, хүмүүс, байгууллагад учирсан гэм хорыг арилгахад санаа тавихад оршино.

НҮБ-ын “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн хохирлыг арилгах асуудалтай холбоотой заалтууд нь 1975 оны есдүгээр сард Женев хотод хуралдсан НҮБ-ын гэмт явдлаас урьдчилан сэргийлэх болон эрх зүй зөрчигчтэй харилцах талаарх V конгрессын төгсгөлийн баримт бичигт мөн тусгалаа олжээ. Мөн “Хүч хэрэглэн үйлдсэн гэмт хэргийн хохирогчийн хор уршгийг нөхөн төлөх тухай” 1984 оны Европын конвенц; “Эрүүгийн эрх зүй ба байцаан шийтгэх ажиллагааны тогтолцоо дахь гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдлын тухай” НҮБ-ын “Гэмт явдалтай тэмцэх асуудлаарх” Европын хорооны зөвлөмж; 1985 онд Милан хотод хуралдсан НҮБ-ын “Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх болон эрх зүй зөрчигчтэй харилцах талаарх VII конгрессын шийдвэр зэрэг баримт бичгүүд батлагдан, хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

1985 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн шийдвэрээр баталсан “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай Тунхаглал”-д хохирогч этгээдэд учирсан хор хохирлыг арилгах асуудлыг шийдвэрлэхэд зарчмын ач холбогдолтой “Засгийн газар нь хохирол арилгах явдлыг эрүүгийн ял шийтгэлийн нэгэн төрөл болгон хуульчлах талаар авч үзвэл зохино” зэрэг заалтуудыг тусгасан.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар төр нь “хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх” үүрэгтэй. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн зөрчсөн эрхийг сэргээн эдлүүлэх асуудал, нарийвчилсан зохицуулалтууд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Нийгмийн хамгааллын тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг дагалдан гарсан журмуудаар тодорхой зохицуулагдсан байна.

Энэ талаар судлаачид “Нэг хууль доторх зүйл, заалтуудын хоорондын уялдаа холбоо, бүр цаашилбал, тодорхой нэг хуульд байгаа заалт холбогдох өөр бусад хуулийн зохицуулалттай хэрхэн нарийн холбогдож байгааг олж харахад төвөгтэй”¹ талаар тодорхойлжээ.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид учирсан хохирлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу нөхөн сэргээх ажиллагааг явуулж байна. Гэсэн хэдий ч хохирлын үндэсний тогтолцоо судалгаагаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын 60 хувь нь хохирлоо нэхэмжилсэн байх бөгөөд улсын хэмжээнд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг 2017 онд 243 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 240 хүнд 91,068,000 төгрөгийн хохирол учирч, 54.5 хувь буюу 49,723,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ. Харин 2018 онд 210 хэрэг бүртгэгдэж гэмт хэргийн улмаас 202 хүнд 93,560,000 төгрөгийн хохирол учирч, 83.3 хувь буюу 77,980,000 төгрөгийн

¹ Н.Арвинтара нар. Хохирогчийг хамгаалах цогц тогтолцоо ба салбар дундын зохицуулалт-Мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага. УБ., 2019

хохирол нөхөн төлөгдсөн байна. Мөн судалгааны үр дүнд “гомдол, саналгүй, нэхэмжлэх зүйлгүй” гэсэн мэдүүлэгт үндэслэн хөнгөн, хүндэвтэр гэмтэлтэй гэмт хэрэгт хохирлын хэмжээг тогтоох ажиллагаа хийлгүйгээр шийдвэрлэжээ. Мөн сэтгэл зүйн болон бэлгийн хүчирхийллийн, эдийн засгийн хүчирхийллийн хэлбэрийг хэрхэн нотлох, ямар хохирол хэрхэн учирсныг үнэлэх арга зүйд сургах нь зүйтэй¹ гэж дүгнэжээ.

Шүүх шинжилгээний хууль² батлагдсанаар эрүүгийн хэрэгт “сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох” эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалаар “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”-ыг баталсан нь гэмт хэргийн хохирогчийн хувь хүний сэтгэцийн хариу урвалын байдал болон гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөл, эд хөрөнгөө алдсанаас хохирогчид учрах эрүүл мэндийн хохирол, сэтгэцийн түр зуурын, эсхүл байнгын шинжтэй эмгэг өөрчлөлт, хэвийн амьдрал алдагдсан байдал, шаардагдах эмчилгээний дундаж хугацаа, хөдөлмөрийн чадвар алдалт зэрэг шалгуур үзүүлэлтийг харгалзан тогтоосон. Гэсэн хэдий ч хэрэгжилтийн байдал нарийвчилсан судалгаа хийж, дүгнэх нь зүйтэй юм.

Виктимологийн хувьд хохирогч төвтэй хандлагаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нь хамгийн үр дүнтэй арга болохыг барууны эрдэмтэд тэмдэглэсэн байна. Хохирогч төвтэй хандлага гэдэг нь үйлчлүүлэгчийн бие даасан байдлыг хүндэтгэн, түүний амьдралд тохиолдсон зовлон бэрхшээлтэй хүнд үеийг даван туулах, өөрийн үнэлэмжийг нэмэгдүүлж, өөртөө итгэлтэй шинэ дүр төрхийг олж, цаашид амьдралаа үргэлжлүүлэх чадвартай болох хүртэл гэр бүлийнх нь онцлог, хэрэгцээнд тохирсон дэмжлэг үзүүлэхийг хэлнэ.⁶ Хохирогч төвтэй хандлагын нэг илрэл нь хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэхдээ тэдний хэрэгцээ шаардлагыг нэн тэргүүнд тавьж буй явдал юм³.

¹ Ч.Нямсүрэн, Г.Эрдэнэбат нар. Хохирлын үндэсний тогтолцоо - тодорхой төрлийн гэмт хэргийн хохирол, хор уршгийн нөхөн төлүүлэлт. Цуврал судалгаа №2. УБ. 2020

² Шүүх шинжилгээний тухай хууль //2017. Төрийн мэдээлэл №5

³ Гэр Бүлийн Хүчирхийллээс Урьдчилан Сэргийлэх, Үр Дүнтэй Тэмцэх Олон Агентлагийн Үр Дүнтэй Хамтын Ажиллагаа, 2015. Роза Логар, Бранислава Марванова Варгова

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ХҮҮХЭД ЭМЭГТЭЙЧҮҮД ӨРТСӨН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ЭНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОЛОН УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ТУРШЛАГА

6.1. Олон улсын эрх зүйн хэм хэмжээ

Олон улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр НҮБ-ын 1979 оны Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Олон улсын хүний эрхийн байгууллагууд 1993 онд Вена хотод хуралдаж гэр бүлийн харилцаанд эмэгтэйчүүдийг хүчирхийлэх бүх хэлбэрийг устгахыг уриалсан Венийн тунхаглал, НҮБ-ын Хүний эрхийн комисс 1994 онд эмэгтэйчүүдийн хүчирхийллийн асуудлаар илтгэх тусгай илтгэгч томилсон шийдвэр, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны зүйл бүхий эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг тунхаглал, Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг 1995 оны Бээжингийн тунхаглал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хүчирхийллийн асуудал нь эрүүл мэндийн салбарын тэргүүлэх ач холбогдол өгөх зүйл болохыг онцолсон 1996 оны тогтоол, 1997 оны хүчирхийлэлд өртсөн хүнд тусламж үйлчилгээ үзүүлэх удирдамж зэрэг эрх зүйн актууд үйлчилж байна.

Улсуудын үндэсний хууль тогтоомжид энэ асуудлын талаар өөр өөрийн онцлогтой. Гэвч гэр бүлийн гишүүдийг хүчирхийллээс хамгаалах ойлголт, хууль зүйн үндсэн арга хэрэгслийн талаар 1996 онд НҮБ-аас дэмжиж баталсан “Гэр бүл дэх хүчирхийллийн тухай” загвар хуулиар үндэслэжээ. Олон улсын хууль тогтоомжоор гэр бүлийн хүчирхийллийг зөвхөн гэр бүлийн хүрээгээр хязгаарлахгүй нийгмийн эсрэг чиглэсэн нийгэмд аюултай гэмт халдлага (англ. «domestic violence» гэж тодорхойлжээ¹. Гэр бүл дэх хүчирхийллийн тухай загвар хуульд гэр бүлийн хүчирхийлэл ам хэлээр доромжлохоос гадна айлгаж ичээх, орон сууцанд хууль бусаар буюу хүчээр нэвтрэх зэргээр эрүүл мэндэд нь хүнд гэм хор хүргэх хүртэл зодохоор заналхийлэх; мөрдөн мөшгөх; далайлган сүрдүүлэх; эд хөрөнгийг устгах, галдан шатаах; хулгайлах; гэр бүлийн харилцааны хүчиндэх; бүсгүйг хүнд өгөх авахтай холбоотой хүчирхийлэл; эмэгтэй хүний бэлгийн мэсээр халдах (генитали); биеийг нь үнэлүүлэхээр албадах; гэртээ зарцлах гэх зэрэг сэтгэцийн, бие махбодын болон бэлгийн шинжтэй бүхий л харгис үйлдлийг хамааруулахаар хуульчилсан байна².

Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай үндэсний хууль тогтоомжид янз бүрээр нэрлэж байна. Олон улсын баримт бичгээр гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлалтай эмзэг оролцогчдын эсрэг хүчирхийллийг дараах төрлийг ангилан авч үзэж байна.

1) Хүүхдийн эсрэг хүчирхийлэл: хүүхдийн сэтгэцийн дарамт сөргөөр үзүүлэх, сэтгэл зүйн, бие махбодын, бэлгийн нөлөөлөл, халамж дутаах, үл хайхрах, худалдаалах болон хүүхдийн эрүүл мэндэд гэм хор учруулах, түүнд бодит хор уршигт

¹ Модельное законодательство о насилии в семье. Рекомендации ООН // Вестник «Новые возможности для женщин». М.: ИЦ НЖФ, 1997. № 10. С. 22

² Мөн тэнд үзнэ үү.: С 23.

хүргэхүйц мөлжлөгийн бусад хэлбэр¹, ялангуяа кибер орон зайд болон ОНМХ-ээр хүүхдэд хүчирхийлэл үйлдэх гэх зэрэг²;

2) Өндөр настны эсрэг хүчирхийлэл: бие махбодын хүчирхийлэл, сэтгэцийн болон сэтгэлзүйн хатуу хандлага, санхүүгийн болон материаллаг хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, халамж дутаах³ гэх зэрэг;

3) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл: сэтгэцийн, бэлгийн болон бие махбодын хүчирхийлэл үйлдэх бүхий л үйлдэл, түүний дотор бие махбодын гэмт халдлага харгислал, сэтгэл зүйн дарамт, бэлгийн хүчирхийлэл, гэр бүл найз нөхдөөс нь тусгаарлах, гарч орох эрх чөлөөг нь хязгаарлах, мэдээлэл болон туслалцаа авахыг хориглох гэх зэрэг.

Дэлхий нийтийн практикаас үзэхэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох практикт хоёр үндсэн хандлага ажиглагдаж байна.

Нэгдүгээрт, ресторатив (буюу нөхөн сэргээх-эвлэрүүлэх), хандлага нь эмнэл зүй-сэтгэцийн тусламж үзүүлэх корrekцийн хөтөлбөр, медиацын буюу эвлэрүүлэн зуучлах технологийг ашиглан гэр бүлийн дотоод сөргөлдөөнийг зохицуулах замаар гэр бүлийг дэмжих, хадгалахад чиглэсэн; хоёрдугаарт цээрлүүлэх буюу гэр бүлийн сөргөлдөж буй гишүүдийн харилцааг салгах замаар хүчирхийллийн механизмыг устгахад чиглэсэн зэрэг.

2011 оны тавдугаар сарын 11 өдөр Туркийн Стамбул хотод хуралдсан Европын Зөвлөлийн хуралдаанаар цаашид Станбулын конвенц хэмээн алдаршсан энэ хуралдаанаар “Гэр бүл дэх хүчирхийлэл ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай” Европын зөвлөлийн Конвенцыг (*Council of Europe Convention on preventing and combating violence against women and domestic violence – CDCE № 210*)⁴ хэлэлцэн баталсан. Энэ нь бүс нутгийн баримт бичиг хэдий ч “Гэр бүл дэх хүчирхийлэл ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай” Европын зөвлөлийн Конвенцыг хүлээн зөвшөөрөх, нэгдэн орох нь сонирхогч улсуудад нээлттэй төдийгүй хүний эрхийн энэ салбарт бусад бүс нутгийн байгууллагуудаас тогтоосон стандартыг өргөжүүлж баяжуулж байна⁵.

Конвенцын агуулгаас харахад оролцогч улсууд нь дараах үүргийг өөртөө хүлээсэн байна:

1) Эмэгтэйчүүдийг дахин хохирохоос хамгаалах хууль зүйн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2) эмэгтэйчүүдийг хүчирхийллийн үйлдлээс ангижрах, нөхөн сэргээхэд дөхөм үзүүлэх үйлчилгээ үзүүлэх. Тухайлбал, хууль эрх зүй, сэтгэл зүйн зөвлөгөө, эрүүл мэнд, санхүүгийн тусламж дэмжлэг үзүүлж, амьдрах орон байраар хангах, хүчиндэх

¹ Bross D. World perspectives on child abuse: the fourth international resource book. Denver, 2000; Report of the Consultation on Child Abuse Prevention, 29-31 March 1999, WHO, Geneva. Geneva, 1999(document WHO/HSC/PVI/99.1).

² Доклад Всемирной неправительственной организации ЕСПАТ «Насилие над детьми в киберпространстве. 2006» // Криминальное насилие против женщин и детей: международные стандарты противодействия: Сб. документов / Сост. В.С. Овчинский. М., 2008. С. 728-736.

³ What is elder abuse? Action on Elder Abuse Bulletin, 1995. 11 (May_June). UK // URL: http://www.who.int/violence_injury_prevention/violence/global_cam-paign/en/chap5.pdf. (хандалт- 2023. 09. 28).

⁴ <http://conventions.coe.int/Treaty/Commun/QueVoulezVous.asp?NT=210&CM=1&CL=ENG/>.

⁵ 2 Межамериканская конвенция по предотвращению, наказанию и искоренению насилия в отношении женщин 1994 г. (Convention of Belem do Para); Протокол к Африканской хартии прав человека и народов о правах женщин в Африке 2003 г. – Протокол Мапуту (The Protocol to the African Charter on Human and Peoples' Rights on the Rights of Women in Africa – Maputo Protocol).

гэмт хэргийн хохирогчдод бэлгийн харилцааны шинжтэй гэмтлээс нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх шууд утас ажиллуулах;

3) ганцаараа эсвэл бусадтай хамт гомдол гаргах үед туслан дэмжих, иргэний эрх зүйн хамгаалалт авах боломжийг олгох, гэрч хүүхдийг хамгаалах арга хэмжээ авах;

4) хүчирхийлэл үйлдсэн буруутай этгээдээс нөхөн төлбөр авах боломжийг олгох;

5) албадан гэрлэлтийг цуцлуулах, хүчингүй болгох арга хэмжээг хууль тогтоомжид заасан хэлбэрээр авах;

6) насанд хүрээгүй хүүхдийг хүчээр гэрлүүлэх, эмэгтэйчүүд, хүүхдийн зөвшөөрөлгүй, тэдэнд бүрэн ойлголт өгөлгүй бэлэг эрхтэн, хэлүүг тайрах уламжлалт мэс ажилбар хийсэн, албадан үр хөндүүлсэн, өндгөн эсний суваг боосон, бэлгийн дарамт учруулсан гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх. Эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт тэдний “Нэр төрийг хамгаалах”¹ зорилгоор үйлдсэн гэх тайлбар нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх үндэслэл болохгүй;

Конвенцод зааснаар эмэгтэйчүүдийг (18 хүртэл насны охид) хүчирхийллийн бүх хэлбэр, тэр дундаа нийтийн болон хувийн амьдрал, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах; энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхээр зорилго болгосон байдаг.

Уг конвенцод ашигласан “ялгаварлан гадуурхах” гэсэн нэр томъёог Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай конвенцын 14 дүгээр зүйл, уг конвенцын 12 дугаар протоколд заасантай ижил утгаар ойлгоно. Европын Хүний эрхийн шүүхийн жишгийг үндэслэн Станбулын конвенцын төслийг боловсруулагчид 4 дүгээр зүйлдээ ялгаварлан гадуурхах үзэл баримтлалыг хүйс, бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, нас, эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл, гэр бүлийн байдал, цагаач, дүрвэгсэд, эсвэл бусад чиг хандлагаар ялгаварлан гадуурхах үзэл баримтлалыг өргөжүүлж, шаардлагатай тохиолдолд нэмэх боломжтой гэж үзжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тусгай хуулиуд удаан хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж ирсэн Европын орнуудад гэр бүлийн хүчирхийллийг хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлоогүй бөгөөд хууль сахиулах практикт томъёолдог байна.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа хууль тогтоох эсвэл засгийн газрын түвшинд (Их Британи, Герман, Канад, Польш, АНУ, Франц гэх мэт) зохицуулдаг улсын хувьд шууд утас, хамгаалах байрны үйл ажиллагааг олон нийтийн байгууллагууд санхүүжүүлдэг байна.

Европын олон оронд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод болон бусад хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд хамгаалах байр, хууль зүй, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эрүүл мэнд, шууд утасны үйлчилгээ болон бусад шаардлагатай туслалцаа, дэмжлэг үзүүлэх үйлчилгээний дийлэнх хувийг олон жил төрийн бус болон олон нийтийн байгууллагууд удирддаг байна.

Европт гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зориулсан үндэсний сүлжээнээс гадна Эмэгтэйчүүдийн асуудлаар зохион байгуулсан IV бага хуралд Бээжинд (1995) бэлтгэх үеэр Европын сүлжээ (WAVE) байгууллага ажилладаг бөгөөд

¹ Стамбул. 2011. Гэр бүл дэх хүчирхийлэл ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай.

одоогоор дэлхийн 44 оронд дээрх сүлжээг төлөөлөн 90 гаруй байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Конвенцын агуулгаас харахад оролцогч улсууд нь дараах үүргийг өөртөө хүлээсэн байна. Үүнд:

1) Эмэгтэйчүүдийг дахин хохирохоос хамгаалах хууль зүйн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2) эмэгтэйчүүдийг хүчирхийллийн үйлдлээс ангижрах, нөхөн сэргээхэд дөхөм үзүүлэх үйлчилгээ үзүүлэх. Тухайлбал, хууль эрх зүй, сэтгэл зүйн зөвлөгөө, эрүүл мэнд, санхүүгийн тусламж дэмжлэг үзүүлж, амьдрах орон байраар хангах, хүчиндэх гэмт хэргийн хохирогчдод бэлгийн харилцааны шинжтэй гэмтлээс нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх шууд утас ажиллуулах;

3) ганцаараа эсвэл бусадтай хамт гомдол гаргах үед туслан дэмжих, иргэний эрх зүйн хамгаалалт авах боломжийг олгох, гэрч хүүхдийг хамгаалах арга хэмжээ авах;

4) хүчирхийлэл үйлдсэн буруутай этгээдээс нөхөн төлбөр авах боломжийг олгох;

5) албадан гэрлэлтийг цуцлуулах, хүчингүй болгох арга хэмжээг хууль тогтоомжид заасан хэлбэрээр авах;

6) насанд хүрээгүй хүүхдийг хүчээр гэрлүүлэх, эмэгтэйчүүд, хүүхдийн зөвшөөрөлгүй, тэдэнд бүрэн ойлголт өгөлгүй бэлэг эрхтэн, хэлүүг тайрах уламжлалт мэс ажилбар хийсэн, албадан үр хөндүүлсэн, өндгөн эсний суваг боосон, бэлгийн дарамт учруулсан гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх. Эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт тэдний "Нэр төрийг хамгаалах" зорилгоор үйлдсэн гэх тайлбар нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх үндэслэл болохгүй;

Конвенцод зааснаар эмэгтэйчүүдийг (18 хүртэл насны охид) хүчирхийллийн бүх хэлбэр, тэр дундаа нийтийн болон хувийн амьдрал, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах; энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхээр зорилго болгосон байдаг.

Уг конвенцод ашигласан "ялгаварлан гадуурхах" гэсэн нэр томъёог Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай конвенцын 14 дүгээр зүйл, уг конвенцын 12 дугаар протоколд заасантай ижил утгаар ойлгоно. Европын Хүний эрхийн шүүхийн жишгийг үндэслэн Станбулын конвенцын төслийг боловсруулагчид 4 дүгээр зүйлдээ ялгаварлан гадуурхах үзэл баримтлалыг хүйс, бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, нас, эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл, гэр бүлийн байдал, цагаач, дүрвэгсэд, эсвэл бусад чиг хандлагаар ялгаварлан гадуурхах үзэл баримтлалыг өргөжүүлж, шаардлагатай тохиолдолд нэмэх боломжтой гэж үзжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тусгай хуулиуд удаан хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж ирсэн Европын орнуудад гэр бүлийн хүчирхийллийг хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлоогүй бөгөөд хууль сахиулах практикт томъёолдог байна.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа хууль тогтоох эсвэл засгийн газрын түвшинд (Их Британи, Герман, Канад, Польш, АНУ, Франц гэх мэт) зохицуулдаг улсын хувьд шууд утас, хамгаалах байрны үйл ажиллагааг олон нийтийн байгууллагууд санхүүжүүлдэг байна.

Европын олон оронд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод болон бусад хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд хамгаалах байр, хууль зүй, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эрүүл мэнд, шууд утасны үйлчилгээ болон бусад шаардлагатай туслалцаа, дэмжлэг үзүүлэх үйлчилгээний дийлэнх хувийг олон жил төрийн бус болон олон нийтийн байгууллагууд удирддаг байна.

Европт гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зориулсан үндэсний сүлжээнээс гадна Эмэгтэйчүүдийн асуудлаар зохион байгуулсан IV бага хуралд Бээжинд (1995) бэлтгэх үеэр Европын сүлжээ (WAVE) байгууллага ажилладаг бөгөөд одоогоор дэлхийн 44 оронд дээрх сүлжээг төлөөлөн 90 гаруй байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

6.2. Гадаад улс орнуудын сайн туршлага

Гадаад улсуудад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор криминологийн янз бүрийн практикийг хэрэглэж байна. Жишээ нь Австри улсад гэр бүлийн деликтийн (зөрчлийн) хэргийг халамжийн шүүхээр, Япон, Англи, Бельги, Люксембург, Польш, АНУ, Франц зэрэг улсуудад гэр бүлийн шүүхээр хянан шийдвэрлэж байна. Орчин үеийн гэр бүлийн шүүхийн номлолоос үзэхэд энэ шүүх эрүү, иргэн, захиргааны чиг хандлагыг илэрхийлсэн цогц түгээмэл шинжтэй шүүн таслах ажиллагаа юм. Гэр бүлийн үнэт зүйлсийг хадгалах хүрээнд эрх зүйг бүтээх чухал эх сурвалж бол Европын шүүхийн практик¹ мөн.

Зарим улсад (Ирланд, Непал, Финлянд, Япон) гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн нууцыг хадгалахад чиглэсэн шүүх хуралдааны загварчилсан журам үйлчилж байна. Жишээ нь шүүх хуралдааны танхимд бусдыг орохыг хязгаарлаж, видео холбооны тусламжтайгаар хүчингийн хохирогчийн талаар гэрчийн мэдүүлэг өгөх боломжийг олгодог байна. Европ болон АНУ-д гэмт этгээд гэмт үйлдэл гаргах буюу гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг нэмэгдүүлж байгаа тохирооны арга хэмжээг багтаасан урьдчилан сэргийлэх тусгай ажиллагааны тогтолцоог амжилттай хөгжүүлж байна².

Гадаад улсын хууль хэрэглээний практикт “хамгаалах ордер” гэж нэрлэх гэр бүлийн доторх хүчирхийллийг таслан зогсоох хууль зүйн хэрэгслийг өргөнөөр амжилттай хэрэгжүүлж байна. Эрх зүйн хамгаалалтын энэ хэрэгсэл нь гэмт хэрэг, хүчирхийллийн аюул заналаас шууд хамгаалах, хүчирхийллээс хараат байгаа этгээд болон хүчирхийлэлд өртөж болзошгүй этгээдийн аюулгүй байдлыг хангах баталгаа төдийгүй тэдний хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгийг хадгалах, мөн хариуцагчийн зүгээс тэдэнд эд хөрөнгийн дэмжлэг үзүүлэх тодорхой баталгаа болдог байна. НҮБ-ын Загвар хуульд заасан “шүүхийн ордер”, “хамгаалах түр ордер” зэрэг эрх зүйн хэрэгслийн зэрэгцээ үндэсний хууль тогтоомжид заасан хамгаалах ордерын институтийн хүрээнд “Хамгаалах тухай шүүхийн тушаал” (Бразил), “Хамгаалах заавар” (Казакстан), “Хамгаалах тушаал” (АНУ), “Хамгаалах тухай тушаал” (Турк), “Албан ёсны анхааруулга” гэсэн агуулгын хувьд адил ч өөр өөр нэртэй хэрэгслүүд үйлчилж байгааг тэмдэглэх хэрэгтэй юм.

¹ Харламов В.С. Отечественный и зарубежный опыт противодействия криминальному насилию в семье. СПб, 2014. с. 281-286

² Доклад Всемирной неправительственной организации ЕСПАТ «Насилие над детьми в киберпространстве. 2006» // Криминальное насилие против женщин и детей: международные стандарты противодействия: Сб. документов / Сост. В.С. Овчинский. М., 2008. С. 728-736.

Гэр бүлийн хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай Европын Зөвлөлийн Конвенцод мөн “Хамгаалах захирамж” гэсэн өөр нэгэн хэрэгслийг зааж өгсөн байна¹. Хууль тогтоогч нь хамгаалах ордер гардуулах нь тусгай буюу тусгай арга хэмжээ гэж тооцдог байна.

Улсуудын үндэсний хууль тогтоомжид хууль зүйн хамгаалалтын дурдсан арга хэмжээ үйлчлэх хугацааг гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, хамгаалах ордер гардуулах талаарх шүүх, цагдаа, хууль зүйн бусад байгууллагын эрх хэмжээнээс хамаарч янз бүрээр заасан байдаг. Зарим улс (Их Британи, Финлянд) эхний үед хохирогчийг хамгаалах асуудлыг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн үйлдлийг иргэний эрх зүйн арга хэмжээгээр хязгаарлана. Өөр зарим улсууд (Мексик, Никарагуа, Кипр) хамгаалалтыг хангах иргэний процессын болон эрүүгийн процессын арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлнэ.

Гурав дахь улсуудад (Австри, Швец, Шинэ Зеланд) хамгаалах ордер хэрэглэхийн тулд дотоод хэргийн байгууллагуудад нэмэлт бүрэн эрх олгодог байна. Жишээ нь хохирогчид аюулгүй байна гэдгийг шүүх тогтоох хүртэл хүчирхийлэгч болон хохирогчийг уулзаж болохгүй байх талаар дотоод хэргийн зохих ордер олгох эрхтэй. Австри улсад гэмт заналхийлэл бодитой байх буюу дахин хүчирхийлэл үйлдэж болзошгүй үндэслэл байвал гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг 10 хүртэл хоног баривчлах эрхийг цагдаагийн байгууллагад олгосон байдаг. Швед улсад гэмт этгээд хохирогчийг уулзуулахгүй байх боломжийг хангахын тулд хохирогчид шинэ баримт бичиг олгох, эсхүл шаардлагатай үед орон байрыг болон өөрийг нь цахим хэрэгсэл, эсвэл бие хамгаалагчаар хангах арга хэмжээг авчдаг байна².

Австрали, Нидерланд зэрэг улс орнуудад цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг гэрээс нь хөөн гаргах эрхтэй. Түүнээс гадна эдгээр улсуудын шүүх нь хүчирхийлэгчийг хохирогчтой нэг гэрт байхыг түр хориглосон захирамж гаргах, хэрэв тухайн орон сууцанд хүүхэд амьдардаг бол гэрийн ойролцоо ирэхийг хориглох (гудамжны хориг тавих гэж нэрлэх) захирамж гаргах эрхтэй ажээ. Хамгаалах ордерын журмыг зөрчсөн тохиолдолд эрүүгийн болон захиргааны санкц хэрэглэнэ. Тухайлбал, Киргиз улсад хамгаалалтын түр ордерын шаардлагыг зөрчсөн бол захиргааны хариуцлага хүлээнэ. Бусад зарим улсад (ӨАБНУ, Испани, Турк, Их Британи) хэрэв дурдсан журмыг зөрчвөл хорих хүртэл эрүүгийн хариуцлага хүлээнэ. Турк улсад 3 сараас 6 сар хүртэл хорих ял шийтгэнэ. Гэр бүл ахуйн хүрээнд эрх зүйн дэг журмыг хангах талаарх гадаадын улсуудын зарим туршлага үр нөлөөтэй байгааг тэмдэглэх хэрэгтэй юм. 1996 оноос Австри улсад Гэр бүл дэх хүчирхийлэлтэй тэмцэх Агентлаг гэсэн хууль сахиулах бие даасан бүтэц ажиллаж байна.

1997 оноос Лос-Анжелесын (АНУ) цагдаагийн газрын дэргэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цагдаагийн хэлтэс ажиллаж байна. Их Британид гэр бүлийн хүчирхийллийн үйл баримтыг мөрдөн шалгах цагдаагийн офицерын тусгай орон тоог

¹ Конвенция Совета Европы от 11 мая 2011 года по предотвращению и борьбе с насилием в отношении женщин и насилием в семье // Официальный сайт Совета Европы // URL: <http://conventions.coe.int/Treaty/EN/Treaties/Html/210.htm> (Хандалт-2023.10.15).

² Lars Nylen & Gun Heimer, Sweden's response to domestic violence, Swedish Institute (1 April 2000).

бий болгосон¹. Бразил, Энэтхэг зэрэг улсуудад цагдаагийн эмэгтэй станц гэж нэрлэх гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох нэг ажилладаг².

Эцэст нь тэмдэглэхэд бидний үзэж байгаа криминологийн практикт гэр бүлтэй ажиллах салбар дундын тогтолцоот загвар амжилттай нэвтэрч байна.

Италид олон хэлээр зөвлөгөө өгөх зориулалттай 1522 дугаартай тусламжийн утас байдаг. Уг утсаар төлбөрийн чадваргүй ядуу хүмүүс, тэр дундаа гадаадын иргэдийг иргэний болон захиргааны шүүхэд эрх ашгийг нь хамгаалах зорилготой бөгөөд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан гарах зардал, хохирогчийн сонгосон өмгөөлөгчийн зардлыг төрөөс бүрэн хариуцдаг байна.

Герман улсын хуулиар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч гурван сарын дотор цагдаагийн байгууллагад мэдэгдэж болдог байна. Хэрэв хууль сахиулах байгууллагын ажилтнууд гэмт хэргийн газарт шууд дуудагдсан ирсэн бол хохирогчийн өргөдөлгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэдэг байна. Түүнчлэн, цагдаа нар газар дээр нь хязгаарлалт тогтоох арга хэмжээ авч болдог бөгөөд уг арга хэмжээг зөрчвөл эрүүгийн хариуцлага хүлээдэг байна. Цагдаа нар прокуророор ахлуулсан урьдчилсан мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах үүрэгтэй бөгөөд хохирогч нь хэргийн ахиц дэвшилд саад болохгүй (жишээлбэл, тэрээр мэдүүлгээ буцааж авах боломжгүй)³.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн даруй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хууль сахиулах байгууллагууд бие даан явуулж, эрүүгийн хэрэг үүсгэн шалгах нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх онцгой үр дүнтэй арга бол чадвар юм. Шведэд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийг хохирогчийн гомдлоос үл шалтгаалан мөрдөн шалгах ажиллагаа явуулж шалгадаг байна. Цагдаагийн байгууллагаас прокуророор ахлуулан мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүрэгтэй бөгөөд хохирогч хэргийн шалгалтын явцад саад хийх боломж (жишээлбэл, тэрээр өргөдлөө буцаан авах)-гүй байдаг. Мөрдөн шалгах ажиллагаа явуулахын тулд гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх хангалттай үндэслэлтэй байх ёстой. Өөрөөр хэлбэл, мөрдөн байцаалтын ажиллагааг эхлүүлэхийн тулд гэмт хэргийн шинж тэмдэг байгааг тогтоох шаардлагатай байдаг. Жишээ нь гэр бүлийн гишүүний учруулсан гэмтлийн улмаас үүссэн хөхрөлт, шарх, бусад гэмтэл байж болдог байна. Мөн цагдаа нар хохирогчийг хамгаалалтад авах шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд заналхийлэл, эрсдэлийн үнэлгээ хийдэг. Аюул заналхийллийн ноцтой байдлаас хамааран зөвлөгөө өгөх, хамгаалах янз бүрийн техник хэрэгслээр хангах (GPS-тэй дуут дохиолол бүхий түргэн тусламжийн утас) зэрэг хамгаалалтын олон төрлийн арга хэмжээ авдаг байна. Аюулгүй байдлын талаар зөвлөгөө өгөх зорилгоор хохирогчтой холбоо барих хүнийг томилдог байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүнийг шүүхэд хандсаны дараа хамгаалалтад авах нь сайн талтай байдаг. Жишээлбэл Францад гэр бүлийн шүүгч хэргийн материал болон хоёр талын мэдүүлэгтэй танилцсаны дараа хүчирхийлэл гарсан гэж үзвэл хамгаалалтын арга хэмжээ авах захирамж гаргаж (эхнэртээ ойртохыг хориглосон хязгаарлалт тогтоох), уг захирамжид хүүхдүүд хэний асрамжид байх, орон сууцыг хэн

¹ Joyce Plotnikoff & Richard Woolfson, Policing Domestic Violence: Effective Organisational Structures (1998).

²Харламов В.С. Отечественный и зарубежный опыт противодействия криминальному насилию в семье. СПб, 2014. С 228.

³ А.С. Архипова. Международный опыт противодействия семейному насилию. г. Ростов-на-Дону. Юридические науки - (дата обращения 1.06.2018)

ашиглах, санхүүгийн ямар үүрэг хүлээлгэх талаар түр зуурын арга хэмжээ авах талаар дурддаг байна.

Францын хуулиар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх нь хүндрүүлэх нөхцөл байдалд тооцогддог бөгөөд үйлдсэн гэмт хэргээс хамааран хорих ялыг нэмэгдүүлж оногдуулдаг байна. Хүний амь хөнөөсөн хэрэгт хохирогчтой гэр бүлийн холбоогүй бол 30 жилийн хорих ял, харин эхнэрийнхээ амийг хөнөөсөн бол бүх насаар нь хорих ял оногдуулдаг байна¹.

Их Британид гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах олон төрлийн арга хэмжээ байдаг. Тухайлбал, хүчирхийлэл үйлдсэн гэх этгээдийг цагдаа 48 цагийн турш саатуулах, эрүүгийн хэргийн шүүхээр хамгаалалтад авах тухай захирамж гаргуулж 28 хоногийн хугацаанд гэрт нь ирүүлэхгүй байх арга хэмжээ авдаг байна. Энэ хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч гэртээ аюулгүй байж, тусламж, хамгаалалт авах боломжийг олгодог байна. Мөн иргэний хэргийн шүүхэд хандаж хүчирхийлэл үйлдэгч, хохирогчтой харилцахыг хязгаарлах арга хэмжээ авах хүсэлт гаргаж болдог. Их Британид гэр бүлийн амьдралынхаа аюулгүй байдлыг хангахын тулд гэрлэх, хамт амьдарч эхлэхээсээ өмнө цагдаад хандаж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байсан эсэхийг шалгаж болдог байна².

Олон улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цогц ажил, арга хэмжээг явуулж байгаа нь судалгааны үр дүнд харагдаж байна. Тодруулбал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлыг гэр бүл бий болгох, гэр бүлийн харилцаанд түрэмгийлэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах, гэр бүлийн дарангуйлагч, хүчирхийлэл үйлдэгчийг соён гэгээрүүлэх зэрэгт илэрч байна.

Хөрш ОХУ-д гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үр дүнтэй дараах аргуудыг ашиглаж байна. Үүнд:

– Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийг хувийн яллах³ хэргийн ангиллаас хассан;

– Шүүхэд хамгаалалт тогтоох тухай захирамж⁴ гаргах эрх олгосон. Уг захирамжаар гэр бүлийн хүчирхийллийн холбогдогчийг хохирогчтой утсаар, захидал харилцааны хэрэгслээр холбогдох, бэлэг сэлт өгөх, эсвэл биечлэн уулзах хэлбэрээр харилцахыг хориглодог. Мөн уг захирамжид холбогдогчийг хохирогчид ойртох, эсвэл хохирогчийн ажил, сургууль зэрэг газарт очихыг хязгаарладаг байна;

- ОХУ-ын Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлд заасан ялын төрөлд, нэмэлт шийтгэл хуульчилсан;

- Мансууруулах бодис, архинд донтох өвчнийг эмчлэх албадан эмчилгээнд хамруулах.

¹ Подройкина И.А. Система уголовных наказаний в истории России и в современном зарубежном законодательстве: монография. – М.: Юстицинформ, 2017. – 112 с.

² Подройкина И.А. Зарубежный опыт и преемственность при построении системы наказаний в России // Бизнес. Образование. Право. Вестник Волгоградского института бизнеса. 2012. № 4 (21). С. 247-250.

³ Хохирогчийн гомдол, өргөдөлгүй эрүүгийн хэрэг үүсгэн шалгагддаг хүндэвтрээс дээш ангиллын хэргүүд.

⁴ хүчирхийллээс хамгаалах, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод зохих хэлбэрийн хууль зүйн туслалцаа үзүүлэх зорилготой эрх зүйн баримт бичиг

ДОЛООДУГААР БҮЛЭГ
ХҮҮХЭД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ
ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВИКТИМОЛОГИЙН АЖИЛ, АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТУЛГАМДСАН АСУУДАЛ, САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

7.1. Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал

Монгол Улсын иргэн бүр аливаа хүчирхийллээс ангид байх ёстой бөгөөд жендерийн тэг бус байдал нь зөвхөн гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагч хосуудын асуудал биш. Энэ бол нийгмийн асуудал, цаашлаад улс орны хөгжлийн асуудал бөгөөд сүүлийн жилүүдэд нийгмийг цочирдуулсан хэргүүд гарч байгаа нь Монгол үндэсний баялаг болох хүнийг (этгээдийн хүсэл зориг, түүний илэрхийлэл нь бие хүний хөгжилтэй хамааралтайгаар илэрч байгааг харгалзан тодорхойлох) социологи, эрх зүйн сэтгэлгээ, эдийн засаг, эрх зүй, гэр бүл судлал (хүн судлал, сэтгэл судлал, хууль зүйн шинжлэх ухааны ойлголтыг цогц ойлголт) зэрэг нийгмийн бусад шинжлэх ухааны үзэл баримтлал, ойлголт, арга замтай уялдуулан цогц байдлаар судлах нь тайлбалан таниулах шаардлагатай байна.

Дэлхий нийтэд “Гэр бүл нь нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй” хэмээн тунхагладаг нь эцсийн бүлэгт нийгмийн тогтвортой байдлыг хангах явдал бөгөөд гэр бүлийн харилцааны хэвийн байдлыг хангах, хамгаалах нь төрийн бодлогын хамгийн чухал асуудлуудын нэгэнд зүй ёсоор тооцогддог¹.

Аливаа нийгмийн зохион байгуулалт гэр бүлээр эхэлдэг төдийгүй гэр бүл нь төр улс бүрэлдэх үндэс болдог. Нийгмийн суурь нэгж болох гэр бүлийн гишүүдийн жам ёсны эрхийг зөрчиж байгаа хамгийн түгээмэл хэлбэр нь хүчирхийлэл, түүний дотор ураг төрлийн холбоотой хүмүүсийн хооронд үйлдэгдэх ахуйн шинж чанартай гэр бүлийн хүчирхийлэл байгаа нь манай оронд ч мөн сүүлийн үед түгээмэл ажиглагдах хандлагатай болж байна.

Гэр бүлийн харилцаан дахь жендер буюу гэр бүлийн хүчирхийллийн тэгш байдлын баталгааны суурь зохицуулалтыг Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 14 дүгээр зүйлд хуульчлан тогтоосон бөгөөд бусад нарийвчлан зохицуулсан хууль, Улсын их хурал, Засгийн газрын тогтоол зэрэг эрх зүйн хэм хэмжээний актаар тусгайлан зохицуулан хамгаалж, төр иргэнийхээ хүний эрх, иргэний эрхийг хангана. Үүнд;

1. Гэрлэгчид, төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүн ямар нэг байдлаар эхнэр, нөхөр, хамтын амьдралтай байгаа хүнээ мэргэжлээрээ ажиллах, бусад хэлбэрээр нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох эрхийг хязгаарлах, саад учруулахыг хориглоно.

2. Эрэгтэй, эмэгтэй хүний гэрлэх, гэрлэлтийн гэрээ байгуулах, өөрчлөх, гэрлэлтээ сайн дураараа цуцлуулах, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн харилцаанд оролцох зэрэг хүний эрх, эрх чөлөөг зөрчихийг хориглоно.

3. Эхнэр, нөхөр нь хүүхдийн тоо, төрөлт хоорондын хугацаа зэргийг хамтран шийдвэрлэх, хүсээгүй жирэмслэлтээс хамгаалах адил тэгш эрх, үүрэгтэй.

4. Эх, эцэг хүүхэддээ нийгмийн үүрэг, хариуцлага, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх хамтын эрх тэгш оролцоо болон жендерийн эрх тэгш байдлын тухай ойлголт, хүнийг

¹ Амарсайхан О. нар. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль, түүний хэрэгжилт. Уб., 2009. 6 дахь тал.

хүйсийн шинжээр үл ялгаварлах үзэл, зан үйлийг өөрсдийн үлгэр дууриал, гэр бүлийн хүмүүжлээр олгох үүрэгтэй.

5. Дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс гэр бүлийн гишүүнд ногдох хувь хөрөнгийг тогтооход оролцох, түүнийг захиран зарцуулах, орлого олох, гэр бүлийн бусад хэрэгцээг хангах үйл ажиллагаа явуулах гэр бүлийн гишүүний эрхийг хүйсийн шинжээр хязгаарлаж үл болно.

6. Эхнэр, нөхрийн гэрлэснээс хойш гэр ахуйн ажил ба өрхийн аж ахуй эрхэлсэн, хүүхэд, ахмад настныг асарсан зэрэг гэрийн хөлсгүй хөдөлмөрийн үнэлгээг нийгмийн баялаг бүтээх болон өрхийн эдийн засагт оруулсан хувь хэмээн тооцно.

Гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй асуудлыг хүний эрхийн зөрчил гэж үзэн иргэний хэрэг, маргаан, зөрчил, гэмт хэрэг гэсэн цогц хүрээнд судлах авч үзэх нь зүйтэй байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар¹ дараах этгээдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд хүчирхийлэл гэж үзнэ. Үүнд, Эхнэр, нөхөр; Гэр бүлийн бусад гишүүн; Хамтран амьдрагч²; Асран хамгаалагч³; Харгалзан дэмжигч⁴; Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд; Тухайн гэр бүлд амьдарч байгаа этгээд; Тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү; Гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр; Хамтран амьдарч байсан, хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд.

Зөрчлийн тухай хуульд⁵ хүүхэд, гэр бүлийн хамаарал бүхий хүний эсрэг хүчирхийлэл үйлдснийг хамааруулан заасан.

Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт⁶ гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнээс үйлдсэн үйлдэл хамаарах ба уг этгээдэд

- Гэр бүлийн гишүүд;
- Бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа хүн;
- Гэрлэлт нь цуцлагдсан хүн;
- Бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн;

¹ Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль //Төрийн мэдээлэл. 2017. №5. 3 дугаар зүйл.

² Гэрлэлтээ бүртгүүлээгүй ч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамтран амьдарч байгаа этгээд

³ бага насны /14 нас хүрээгүй/ бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний бага насны хүүхэд, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний бага насны хүүхэд, сэтгэцийн өвчний улмаас шүүхээс иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон хүнд асран хамгаалагчийг иргэний шүүхээс тогтооно.

⁴ насанд хүрээгүй /14-өөс 18 хүртэлх насны/ бүтэн өнчин хүүхэд, эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний насанд хүрээгүй хүүхэд, эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа буюу хорих газарт ял эдэлж байгаа зэрэг аргагүй шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний насанд хүрээгүй хүүхэд, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэсний улмаас иргэний эрх зүйн эрхийн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүн, эрүүл мэндийн байдал болон өндөр настай болсны улмаас иргэний эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй болсон хүнд харгалзан дэмжигчийг иргэний шүүхээс тогтооно.

⁵ Монгол Улсын Зөрчлийн тухай хууль //Төрийн мэдээлэл. 2017. №24. 6.20, 8.8, 5.4 дүгээр зүйл.

⁶ Монгол Улсын Эрүүгийн хууль //Төрийн мэдээлэл. 2016. №7.

- Асран хамгаалагч;
- Харгалзан дэмжигч;
- Асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хүн;
- Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн асрамжид байгаа хүмүүсийн хоорондын харилцааг хамааруулан өргөн хүрээнд тодорхойлсон.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу гэр бүл, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, цахим орчин, олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ гээд нийгмийн бүхий л орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагааг хүүхэд хамгаалал гэх ба эцэг эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээ авна¹ хэмээн гэр бүлийн хүрээнд хүүхэд хамгааллыг тодорхойлсон нь хүүхдийн хөрөнгийн эрх, хуваарьт хөрөнгийн эрхийг хэрэгжүүлэх, хамгаалахад баримтлах үүрэг гэж үзэж байна.

2016 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний (эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд; тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү; гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсвэл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд) амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршдог ба уг хуулийн 4 дүгээр бүлэгт Хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах гэсэн тусгайлсан зохицуулалтаар хамгаалж байна².

2017 оны Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг хуульчилсан бөгөөд 1.3³-д гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга ... хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан.

Зөрчлийн тухай хуульд хүүхдийн эрхийг зөрчих⁴, бусдын эд хөрөнгийг хууль бусаар устгах, гэмтээх⁵, гэр бүлийн хамаарал бүхий хүний хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан⁶ зэрэг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна. Тухайлбал, 6.20 дугаар зүйлийн 2.2-д “хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, өв залгамжлах, эсвэл ажил үйлчилгээний хөлс, урамшуулал авах эрхийг хязгаарласан; 2.3-д ... хүнийг

¹ Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль //Төрийн мэдээлэл. 2016. №9. 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт.

² Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль //Төрийн мэдээлэл. 2017. №5.

³ Монгол Улсын Эрүүгийн хууль //Төрийн мэдээлэл. 2016. №7.

⁴ Монгол Улсын Зөрчлийн тухай хууль //Төрийн мэдээлэл. 2017. №24. 6.20 дугаар зүйл.

⁵ Мөн тэнд. 8.8 дугаар зүйл.

⁶ Мөн тэнд. 5.4 дүгээр зүйл.

нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэжээ. Мөн хүүхдийн хуваарьт хөрөнгөд хамаарах хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсвэл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулахаар, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулахаар тус тус заажээ.

Хуулийн хүрээнд хүн төрөлхийн эрх чөлөөг адил тэгш хамгаална гэдэг нь аливаа нийгмийн үндсэн зорилго¹ бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцт: “Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй”², “Гэрлэгсэд гэрлэхдээ, гэрлэсний дараа болон гэрлэлтээ цуцлах үед тэгш эрхийг эдэлнэ”³ гэж гэр бүлийн харилцааны суурь зарчмуудыг тунхаглан баталгаажуулсан байх бөгөөд эдгээр хэм хэмжээнүүд нь улс орон болон нийгмийн гишүүн бүрийн, гэр бүлийн гишүүдийн, хүн бүрийн чандлан сахих ёстой нийтлэг стандарт болон тогтжээ.

Хүн бүр амьдарч буй орчин, гэр бүлдээ айх аюулгүй, аливаа хүчирхийлэл, дарамтаас ангид байх эрхийг Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, түүний нэмэлт протокол, Эхчүүдийг хамгаалах тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 103 дугаар конвенц, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглал зэрэг олон улсын хүний эрхийн баримт бичигт баталгаажуулж, хүний эрхийг хамгаалалтыг бэхжүүлэх үндсийг бий болгож, олон улсын гэрээг соёрхон баталсан буюу нэгдэн орсноор үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилж байна.

Зарим конвенцод хүний эрх, эрх чөлөө, аливаа хүчирхийллийн талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал:

1 дүгээр зүйлд “хүн төрсөн цагаасаа эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна ...”,

2 дугаар зүйлд “... эрх, эрх чөлөөг ... эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой”,

3 дугаар зүйлд “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”,

7 дугаар зүйлд “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй”,

12 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон

¹ Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн криминологи. Судалгааны тайлан /2018-2020/. УБ., 2021. 27 дахь тал.

² Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. НҮБЕА. 1966. 23 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг.

³ Хүний эрхийн түгээмэл Тунхаглал. НҮБЕА. 217/A/III тогтоол. 1946. 16 дугаар зүйл. 1 дэх хэсэг.

нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй”,

16 дугаар зүйлийн 16.2-т “Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй”,

17 дугаар зүйлийн 17.1-т “Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй”,

28 дугаар зүйлд “Хүн бүр энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг бүрэн эдэлж болохуйц нийгмийн болон олон улсын дэг журамд аж төрөх эрхтэй” гэж

2. Иргэний болон улсын төрийн эрхийн олон улсын факт¹:

“Харилцан бүрэн зөвшилцөөгүй аливаа гэрлэлт байж үл болно. Оролцогч улс бүр ... гэрлэгчдийн эдлэх эрх, хүлээх хариуцлагыг тэгш хангах зохистой арга хэмжээ авах, хүүхдийг яс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон төрсөн байдлаар алагчлахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйн хувьд шаардлагатай бүхий хамгаалалт эдлэх эрхтэй”,

17 дугаар зүйлд² “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно” гэж тунхаглан гэрлэгчдийн эдлэх эрх, хүлээх хариуцлагыг тэгш хангах зохистой арга хэмжээ авах, хүүхдийг яс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон төрсөн байдлаар алагчлахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйн хувьд шаардлагатай бүхий хамгаалалт эдлэх эрхтэй” болохыг болон гэрлэлт цуцлах тохиолдолд аливаа хүүхдийг хамгаалах талаар шаардлагатай заалт гаргах ёстойг анхааруулжээ.

3. Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын факт³:

7 дугаар зүйлд “... гэр бүлийн гишүүдэд хангалуун амьдрах боломж олгох”,

10 дугаар зүйлд “Нийгмийн жам ёсны үндсэн нэгж болсон гэр бүлд, ялангуяа түүнийг үүсэх үед бие дааж дамжаагүй хүүхдийг халамжлах, хүмүүжүүлэх хариуцлага хүлээж байгаа үед, боломжийн хэрээр халамжлан хамгаалж тусална”,

4. Хүүхдийн эрхийн тухай конвенц⁴:

2 дугаар зүйлд “... эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийг ... нийгмийн гарал, эд хөрөнгө, төрсөн болон бусад байдлаас шалтгаалан аливаа хэлбэрээр алагчлахгүй”,

19 дүгээр зүйлд “Эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авах” -ыг үүрэг болгосон,

34 дүгээр зүйлд “Хүүхдийг бэлгийн замаар ашиглан мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах үүрэг хүлээнэ”,

¹ “Төрийн мэдээлэл” эмхтгэл, Тусгай дугаар, Монгол Улсын олон улсын гэрээ, I боть.

² Үүнээс гадна Хүний эрхийн тунхаглалд заасан хүний эрх, эрх чөлөөнийг эрхийг мөн адил баталгаажуулсан болно.

³ “Төрийн мэдээлэл” эмхтгэл, Тусгай дугаар, Монгол Улсын олон улсын гэрээ, I боть.

⁴ Хүүхдийн эрхийн тухай конвенц. 1989.

37 дугаар зүйлд “Нэг ч хүүхдийг тамлан зовоож, хэрцгий харгисалж, хүний ёсноос гадуур харьцаж, эсвэл нэр хүндийг нь гутааж юм уу шийтгэхгүй байх” гэж эрүү шүүлтийн эсрэг заалт,

Мөн хүүхдийг халамжлах, хамгаалах үүрэг бүхий газар, алба, байгууллагыг тухайн тодорхой салбарт аюулгүй байдал, хүүхдийн амьдрах, эсэн мэнд өсөж, хөгжих бололцоог хангах зорилгоор ажиллагсдын орон тоо, чадавхад хяналт тавих үүднээс эрх бүхий байгууллагаас жишигт нийцсэн нөхцөлөөр хангах шаардлагатай болохыг ч анхааруулжээ. Конвенц оролцогч улсууд нь:

- Хүүхдийг бэлгийн хууль бус аливаа ажиллагаанд татан оролцуулах буюу шахалт үзүүлэх;

- Хүүхдийн биеийг үнэлүүлэх буюу бэлгийн хууль бус бусад ажиллагаанд ашиглан мөлжих;

- Хүүхдийг садар самуун үзүүлбэр болон зүй бус байдлыг сурталчилсан материалд ашиглах зэргээр хүүхдийг бэлгийн замаар мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүүхдийг үл хайхрах, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилсон харьцаа, хандлагын ... хохирогч хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгэмд нэгтгэхэд тус дөхөм болох шаардлагатай бүх арга хэмжээг авах үүрэгтэй болохыг онцлон тэмдэглэсэн байна.

5. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц¹:

1 дүгээр зүйлд “эмэгтэйчүүдийг алагчлах гэдэг нь гэрлэлтийн байдлаас үл хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэдийн болон аливаа бусад салбарт эмэгтэйчүүдийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, эсвэл үгүйсгэх үр дагавар, эсвэл зорилго бүхий хүйсээр ялгаварлах, үгүйсгэн гадуурхах буюу хязгаарлахыг ойлгоно”,

16 дугаар зүйлд “гэрлэлт, гэр бүлийн харилцааны бүх асуудлаар эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгах зохистой бүх арга хэмжээг авах ба эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр аливаа арга хэмжээг авна”,

“*Эмэгтэйчүүдийг хүчирхийлэх* гэдэг нь эмэгтэйчүүдэд бие махбод, бэлгийн буюу сэтгэл санааны гэм хор, зовлон шаналал учруулсан буюу учруулж мэдэх, бэлгийн харьцааны шинжтэй үндэслэлээр үйлдэгдсэн хүчирхийллийн аливаа үйлдэл, мөн ийм үйлдэл хийхийг албадсан, нийгмийн буюу хувийн амьдрал дахь эрх, эрх чөлөөг дур мэдэн хасах явдал мөн” гэж тодорхойлжээ.

6. Эхчүүдийг хамгаалах тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 103 дугаар конвенц:

2 дугаар зүйлд “эмэгтэй хүн гэж нас, үндэсний харьяалал, арьс үндэс, буюу шашин шүтлэг, гэрлэлтийн байдлаас үл шалтгаалан аливаа эм хүйсийн хүнийг, хүүхэд гэж гэрлэлт буюу гэрлэлтээс гадуур төрсөн эсэхээс үл хамааран бүх хүүхдийг ойлгоно” гэж тус тус тусгагдсан байна.

Иргэний баталгаат эдлэх эрхийг хангах, гэр бүл дэх хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүднээс 2004 оны 05 дугаар сарын 13-ны өдөр “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийг 5 бүлэг, 20 зүйлтэйгээр баталж, 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр 6 бүлэг, 47 зүйлтэйгээр шинэчлэн найруулсан.

¹ Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрийг устгах тухай конвенц. НҮБЕА. 1993.

Монгол Улсын Үндсэн хууль¹-д Хүний суурь эрх, тэдгээрийг хамгаалах асуудлаар:

- 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно”;

- 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11-д “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй”, “Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж;

- 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13-т “иргэн ... халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй”;

- 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”;

- 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7-д “Засгийн газар төрийн хуулийг биелүүлж ... хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх”.

Гэр бүлийн зөрчил, маргааны шалтгаанаас хамаарч гэр бүлийн хүчирхийлэл нь жендерт суурилсан хүчирхийллийн нэг төрөл болох гэр бүлийн хүчирхийлэл нь иргэний хэрэг, маргаан, зөрчил, гэмт хэрэг болдог бөгөөд Гэр бүлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийн тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Зөрчлийн тухай, Зөрчил хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх шийтгэх тухай хуулиар хамгаалдаг.

Одоогоор 355 хэм хэмжээний актын² 107 нь гэр бүл, гэр бүлийн гишүүн, гэр бүлийн бусад гишүүн, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн зэрэг ойлголтын талаар зохицуулсан байна. Үндсэн хуульд гэр бүл, гэр бүлийн гишүүн, гэр бүлийнхэн гэсэн томъёоллоор илэрхийлж байгаа бол бусад хуульд гэр бүлийн гишүүд, гэр бүлийн гишүүн, гэр бүлийн буюу төрөл садны, гэр бүлийн хамаарал бүхий этгээд зэргээр зөрүүтэй томъёолсон байна, Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Компанийн тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай, Дампуурлын тухай, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад гэр бүлийн гишүүн, гэр бүлийн гишүүд, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд гэр бүлийн болон бусад хүн, Төрийн аудитын тухай, Төрийн албаны тухай хуульд гэр бүл, төрөл, садны хүн, Хөдөлмөрийн хуульд гэр бүлийн буюу төрөл садны хүмүүс, Иргэний хуульд гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүн, гэр бүлийн гишүүн Гэр бүлийн тухай хуульд гэрлэлт, гэр бүл, гэрлэгчид, гэр бүлийн гишүүн, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,

¹ Монгол Улсын Үндсэн хууль //Төрийн мэдээлэл. 1992. №1.

² Өлзийсайхан Б. Хууль тогтоомжийн судалгаа. Уб., 2000.

Гэрч, хохирогчийн хамгаалах тухай хуульд гэр бүлийн гишүүн, бусад хүн, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн гэж өөр өөр нэр томъёог хэрэглэсэн байна¹.

Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих”, Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэж зөрчил, гэмт хэргийг тусгайлан авч үзэн гэр бүлийн дундын эд хөрөнгө, өмчлөгчийн эрхийг хамгаалж байна. Эрүүгийн хуулиар хамгаалагдсан гэмт хэргийг шалгах явцад Гэрч, хохирогчийн хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын төрлөөр гэрч, хохирогчийн эрхийг хангаж байна. Уг зөрчил, гэмт хэрэгт хохирсон этгээдийг Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар гэрлэгч, гэр бүлийн гишүүн, гэр бүлийн бусад гишүүн гэж томъёолж болох байсан хэдий ч дээрх хуульд огт байхгүй гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн, хамаарал бүхий этгээд гэж томъёолон Эрүүгийн хуульд гэр бүлийн хамаарал бүхий харилцааг тайлбарласан. Иймд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.2, 5.3-д заасан хамаарал бүхий этгээд, Эрүүгийн хуулийн 11.7-ын 1, 12.1-ийн 2.3-т заасан гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн, Зөрчлийн тухай хуулийн 5.4-ийн 4 дэх хэсэгт заасан гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн гэснийг “гэр бүлийн гишүүн” гэж өөрчлөн найруулах нь зүйтэй.

7.2. Хүүхэд эмэгтэйчүүдийн эрхийг хангах хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах нь

Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө (хүчирхийлэл)-г бусад хууль буюу төрөлжсөн Иргэний хууль, Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийн тухай, Боловсролын ерөнхий хууль², Дээд боловсролын тухай хууль³, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай⁴, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль зэргээр баталгаажна, шүүхийн болон шүүхийн бус журмаар хамгаалагддаг.

Хуульд зааснаар иргэний эрхийг хамгаалахын тулд ТАНЫГ жендерт суурилсан хүчирхийллээс хамгаалах тулд дараах эрх зүйн баталгааг гаргасан байдаг. Үүнд:

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого нь эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангах нөхцөлийг бүрдүүлэх, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, түүнийг арилгахад чиглэнэ⁵.

- Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална⁶.

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бодлого боловсруулах, төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх замаар зохион байгуулна⁷.

- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг хуулийн хүрээнд буюу хуульд заасан үндэслэл, журмыг дагуу зохион байгуулах ёстой. Үүнд:

¹ Отгонтуяа О. Гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт. Нэг сэдэвт бүтээл. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Монгол Улс., 2022. 63 дахь тал.

² Монгол Улсын Боловсролын ерөнхий хууль. 2023.07.07.

³ Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль. 2023.07.07.

⁴ Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль //Төрийн мэдээлэл. 2019. №42.

⁵ Монгол Улсын Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль //Төрийн мэдээлэл. 2011. №8. 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг.

⁶ Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль //Төрийн мэдээлэл. 1999. №30. 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг.

⁷ Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль //Төрийн мэдээлэл. 2019. №42. 3 дугаар зүйл.

- Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хангах, эрхийг нь хамгаалах нөхцөл, журмыг хуулиар тогтооно¹.

- Гэр бүлийн эрхийг төрийн захиргааны болон нийгмийн халамжийн байгууллага Гэр бүлийн тухай хуульд, шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хамгаална².

Гэр бүлийн хүчирхийлэл нь иргэний хэрэг, маргаан, зөрчил, гэмт хэрэг болдог бөгөөд Гэр бүлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийн тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Боловсролын ерөнхий хууль, Зөрчлийн тухай, Зөрчил хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх шийтгэх тухай хуулиар хамгаалдаг.

Эрүүгийн хуулиар хамгаалагдсан гэмт хэргийг шалгах явцад Гэрч, хохирогчийн хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын төрлөөр гэрч, хохирогчийн эрхийг хангаж байна.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж, өөрийнхөө болон гэр бүлийн хайртай дотны хүнээ хамгаалахын тул гэр бүлийн хүчирхийлэл нь иргэний хэрэг, маргаан, зөрчил, гэмт хэрэг болох хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлж болно. Үүнд:

- Хүүхдийн төлөө үндэсний газар, түүний нэгж байгууллага;
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, түүний нэгж байгууллага;
- Цагдаагийн ерөнхий газар, түүний нэгж байгууллага (Гэрч, хохирогчийн хамгаалах хэлтэс)
- Хүүхдийн тусламжийн 108 утас;
- Цагдаагийг байгууллагын 102 утас;
- Бүх шатны байгууллагын нийгмийн ажилтан;
- Боловсролын байгууллагын ажилтан;
- Иргэн;
- Хуулийн этгээд.

Хуулиар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх дээрх байгууллага нь хүүхдийн эрх, ашгийг хамгаалахад түүний халдашгүй эрхийг зөрчихгүй, бие даасан байдалд шууд болон шууд бусаар нөлөөлөхгүй, мэдээллийг аюулгүй байдлыг ханган, түүний эрх, ашиг сонирхлыг тэргүүн эгнээд хамгаалахад бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлэх хэрэгтэй юм гэсэн дүгнэлтэд хүрлээ.

¹ Монгол Улсын Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль //Төрийн мэдээлэл. 2011. №8. 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг.

² Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль //Төрийн мэдээлэл. 1999. №30. 5 дугаар зүйл.

ДҮГНЭЛТ

Бид хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын криминологи судалгаанд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна:

1. Монгол Улсад хэрэгжүүлж байгаа эрх зүйн шинэтгэлийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлан, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх үйлдлийг зөрчил, гэмт хэрэгт тооцон хуульчилж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цогц хууль тогтоомжийг мөрдөж, багагүй хугацаа өнгөрч байна. Эрдэмтэн судлаачдын дунд тухайн төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, зөрчил, эрүүгийн эрх зүйн зохицуулалт, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагаанд тулгамдсан асуудал, хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх асуудлын талаарх судалгаа шинжилгээний ажил цөөнгүй хийжээ. Энэ судалгаа нь G9198/9221-МОН: Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд Монгол Улсад анх удаа хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын хүрээнд виктимологийн үүднээс судалсан бүтээл юм. Энэ төрлийн судалгааг цаашид тогтвортой хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2. Виктимологийн суурь судалгааны үр дүнд үндэслэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, түүний онцлог, хэрэгцээ, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн хянан шийдвэрлэхэд хохирогч төвтэй аргачлалыг хөгжүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн үр дагавар, шалтгаан, нөхцөл, хүчин зүйл, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх виктимологийн арга замыг тодорхойлох хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

3. Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх НҮБ-ын удирдах газар, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс 2010 онд “Гэмт хэрэгт хохирох явдлын талаар шинжлэн судлах Удирдамж” (Manual on Victimization surveys) батлан гаргасан нь улс орнуудад гэмт хэрэгт хохирох явдал, эрсдэлийг судлах, судалгааны үр дүнг гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсронгуй болгоход чухал хувь нэмэр оруулж байна. Энэхүү удирдамж нь гэмт хэрэг хохирох явдлыг судлах, шинжилгээ хийх арга зүйн зарчмуудыг олон улсын хэмжээнд нэгдмэл байдлаар боловсруулах анхны баримт бичиг төдийгүй, хохирох эрсдэлийг үндэсний түвшинд судлах, ялангуяа тухайн судалгааг анх удаа хийж байгаа улс оронд чухал ач холбогдолтой байна.

4. Гэмт хэргийн виктимологийн шинжлэх ухаан шинэ тутам хөгжиж байгаа өнөө үед гэмт хэрэгт хохирох явдал, гэмт хэрэгт хохирох эрсдэл, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, учир шалтгаан, хохирогч-этгээд (хувь хүн, байгууллага, төр, нийгэм), гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх арга замыг, ажлыг виктимологийн шинжлэх ухааны үүднээс шинээр тодорхойлж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх нийгэм-улс төр, эрх зүйн хэрэгцээ шаардлага тулгамдаж байна.

5. Эрүүгийн анхан шатны шүүхээр 2022 онд хянан шийдвэрлэсэн нийт хэргээс хүнийг алах гэмт хэрэг 18 хэргээр буюу 9.1 хувиар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2 хэргээр буюу 2.0 хувиар, хүн худалдаалах гэмт хэрэг 3 хэргээр буюу 50.0 хувиар тус тус буурсан бол хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг 72 хэргээр буюу 22.0 хувиар, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 1091 хэргээр буюу 21.8 хувиар, хүчиндэх гэмт хэрэг 17 хэргээр буюу 4.9 хувиар

тус тус өссөн дүнтэй гарчээ. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг дангаар зүйлчлэхээс гадна хүн алах, санаатайгаар хүний биед гэм хор учруулах, хүчиндэх гэмт хэрэгт гэр бүлийн хамаарал бүхий этгээд болон бага насны хүүхдийн эсрэг гэмт хэрэгт гэсэн нэр томъёогоор илэрхийлж давхар зүйлчлэх асуудал шүүхийн практик элбэг байна. Жишээ нь эрүүгийн хуулийн “Хүнийг алах” гэсэн 10.1 дүгээр зүйлийн 2.7 дах хэсэгт хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй, бага насны хүүхэд, жирэмсэн болохыг мэдсээр байж алах, 2.8 дахь хэсэгт гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж алах үйлдлийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс өөр зүйлээр зүйлчлэх нь хүчирхийллийн статистик мэдээлэл бүрэн гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлжээ.

6. Бид түүвэр сонголтоор нийслэл хотын 7 дүүргийн хүрээнд 1000 иргэдээс гэр бүлийн хүчирхийлэл, түүний дотор хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын талаар тандалт судалгааг компьютер ашиглан ярилцлага авах (CAPI) аргаар явуулсан. Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь гэр бүлийн хүчирхийллийн аливаа нэг хэлбэрт өртөж байсан бөгөөд 70 орчим хувь нь төрийн байгууллагад хандаж байгаагүй байна. Мөн 40 орчим хувьд нь хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан байна.

7. Шүүхийн мэдээнээс үзэхэд 2020-2022 онд шүүхээр хянан шийдвэрлэсэн хэргийг хүчирхийллийн хэлбэрээр нь авч үзэхэд нийт хүчирхийллийн 93% нь бие махбодын, 5% нь бэлгийн хүчирхийлэл, сэтгэл санааны хохирол 2%-ийг эзэлж байна. Харин хүүхдийг үл хайхрах хүчирхийллийн хэрэг сүүлийн 3 жилд огт хянан шийдвэрлээгүй байна. Бид хүүхдийг үл хайхрах, гадуурхах хэлбэрүүдийг эрүүгийн хуулийн зохицуулалтын гадна үлдээсэн гэх дүгнэлтэд хүргэж байна. Иймд үл хайхрах явдлыг эрүүгийн эрх зүйн хамгаалалтад авах нь зүйтэй гэж үзэж байна.

8. Гадаад улсын хууль хэрэглээний практикт “хамгаалах ордер” гэж нэрлэх гэр бүлийн доторх хүчирхийллийг таслан зогсоох хууль зүйн хэрэгслийг өргөнөөр амжилттай хэрэгжүүлж байна. Эрх зүйн хамгаалалтын энэ хэрэгсэл нь гэмт хэрэг, хүчирхийллийн аюул заналаас шууд хамгаалах, хүчирхийллээс хараат байгаа этгээд болон хүчирхийлэлд өртөж болзошгүй этгээдийн аюулгүй байдлыг хангах баталгаа төдийгүй тэдний хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгийг хадгалах, мөн хариуцагчийн зүгээс тэдэнд эд хөрөнгийн дэмжлэг үзүүлэх тодорхой баталгаа болдог байна. Энэ арга хэрэгслийг манай улсад нэвтрүүлэх нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн, түүний дотор хүүхэд эмэгтэйчүүдийг дахин хохирохоос хамгаалахад чухал ач холбогдолтой.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Эрүүгийн хуулийн “Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх” гэсэн 16.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Хуулиар хүлээсэн асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээсээ зайлсхийж хүүхдийг хаясан, орон гэрээ олох боломжгүй газар зориуд орхисон, хүүхдийг оршин суугаа газраас нь хөөж тэнүүчлэхэд хүргэсэн гэснийг” дараах байдлаар “Хуулиар хүлээсэн асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээсээ зайлсхийж хүүхдийг хаясан, орон гэрээ олох боломжгүй газар зориуд орхисон, хүүхдийг оршин суугаа газраас нь хөөх буюу гадуурхах, үл хайхрах зэргээр тэнүүчлэхэд хүргэсэн” гэж өөрчлөн найруулах;

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ” гэсэн 29.6 дугаар зүйлд: “2 Гэрч хохирогчид нөлөөлөх, нотлох ажиллагаанд саад учруулахгүй байх талаар мөрдөгч, прокурор сэжигтэн, яллагдагч этгээдэд “хамгаалах захирамж” бичиж гардуулна” гэж нэмэх;

- Виктимологийн суурь судалгааны үр дүнд үндэслэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, түүний онцлог, хэрэгцээ, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн хянан шийдвэрлэхэд хохирогч төвтэй аргачлалыг хөгжүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн үр дагавар, шалтгаан, нөхцөл, хүчин зүйл, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх виктимологийн ажил, арга хэмжээг шинээр тодорхойлох;

- Гэмт хэргийн виктимологийн шинжлэх ухаанд суурилсан хөтөлбөр, сургалт, судалгааны төслийн ажлыг өргөжүүлэх, гэмт хэргийн төрөл нэг бүрээр цаашид гүнзгийрүүлэн судлах, эрдэм шинжилгээний ажлыг өрнүүлэх;

- Хүүхэд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулж, хүчин чармайлтыг нэмэгдүүлэх, ГХУСЗ-ийн ажлын хүрээнд тэдний ажлыг уялдуулан зохицуулах, хийж буй судалгааны ажлын үр дүнгийн хэрэгжилтэд мониторинг хийдэг байх;

- Судалгааны ажлыг мэдээллээр хангах нэгдсэн цахим тогтолцоог бий болгох, судалгааны ажлын талаар харилцан мэдээлэл солилцох ажлыг нээлттэй болгох, журамлах;

- Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх НҮБ-ын удирдах газар, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс 2010 онд “Гэмт хэрэгт хохирох явдлын талаар шинжлэн судлах Удирдамж” (Manual on Victimization surveys) батлан гаргасан нь улс орнуудад гэмт хэрэгт хохирох явдал, эрсдэлийг судлах, судалгааны үр дүнг гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсронгуй болгоход чухал хувь нэмэр оруулж байна. Энэхүү удирдамжийн орчуулгыг албажуулж, практикт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

- Хууль зүйн их дээд сургуульд “Гэмт хэргийн виктимологи” хичээлийн хөтөлбөрийг нэвтрүүлж, энэ талаар гарын авлага, сургалтын материалыг боловсруулж хэвлүүлэх;

- “Хотжилт-хохирох явдал” судалгааг ойрын хугацаанд зохион байгуулж, сургууль цэцэрлэгийн алслагдмал байдал, замын түгжрэл, боловсролын тогтолцоо (хүүхдэд өгөх гэрийн даалгавар, хичээлийн агуулга, хэлбэр, ачаалал хүүхдийн чөлөөт цаг, албан бус боловсрол, тоглох эрхэд хэрхэн нөлөөлж буй гэх зэрэг) зэрэг үзэгдэл

нь хүүхдийг үл хайхрахад болон гэр бүлийн гишүүд гэр бүлдээ тавихад хэрхэн нөлөөлж байгааг нарийвчлан судлах;

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явдлын виктимологийн судалгааг гаргахдаа давхар зүйлчлэх онцлогийг харгалзах, жишээ нь хүнийг алах (10.1), хүний биед санаатайгаар хохирол учруулах (11.1, 11.4, 11.6), хүчиндэх (12.1), бэлгийн мөлжлөг (12.3) гэх зэрэг болон хүүхдийн эсрэг зарим гэмт хэргийг гэр бүлийн хүрээнд буюу гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгтэй хамт статистик мэдээлэл гаргах шаардлага нь эрдэм шинжилгээ судалгааны болон хууль зүйн практик ач холбогдолтой байна.

НОМ ЗҮЙ

Хууль, эрх зүйн эх сурвалж.

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992. Төрийн мэдээлэл №1.
2. Хүний эрхийн түгээмэл Тунхаглал. НҮБ-ЕА. 217/A/III тогтоол. 1946.
3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт 1966.
4. Хүний эрхийн олон улсын билл Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл 2018.
5. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц. 1989.
6. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрийг устгах тухай конвенц. НҮБ-ЕА. 1993.
7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017.
8. Хүүхэд хамгааллын тухай хууль. 2016. Төрийн мэдээлэл №9.
9. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай. 2017. Төрийн мэдээлэл №5.
10. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль// 2013.Төрийн мэдээлэл №30.
11. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль//2019. Төрийн мэдээлэл
12. Зөрчлийн тухай хууль. 2017. Төрийн мэдээлэл №24.
13. Эрүүгийн хууль. 2016. Төрийн мэдээлэл №7.
14. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль//2017. Төрийн мэдээлэл №23.
15. Шүүх шинжилгээний тухай хууль //2017. Төрийн мэдээлэл №5
16. Боловсролын ерөнхий хууль. 2023.
17. Дээд боловсролын тухай хууль. 2023.
18. Монгол Улсын Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль //Төрийн мэдээлэл. 2011. №8.
19. Монгол Улсын Их Хурлын Тогтоол. 2020. дугаар 24. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”.
20. Монгол Улсын Их Хурлын тогтоол. 2020. Дугаар 52. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай.
21. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/173, А/251, А/380 дугаар тушаал “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”.
22. ХНХ-ын сайд, ХЗДХ-ийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/173, А/259, А/380 дугаар тушаалаар батлагдсан “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”.
23. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/394 дугаартай тушаал “Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам”
24. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны а/37 дугаартай тушаалын хавсралт. ₮Хохирогчийн аюулын зэргийг үнэлэх аргачлал₮.
25. Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаал №А/83. 2000 он. “Аюулын зэргийн үнэлгээ хийх журам”.
26. Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаал №А/204. 2014 он. “Биечилсэн хамгаалалтын журам”
27. УЕП, Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал №А/22, А/31. 2017 он. “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам”.

28. Хууль зүйн сайдын тушаал №А/112. 2014 он. “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ журам”.
29. Хууль зүйн тушаал №А/113. 2014 он. “Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам”.
30. Хууль зүйн тушаал №А/114. 2014 он. “Гэрч хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах, аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”.
31. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаал №А/116. 2017 он. “Түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журам”.
32. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаал, Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал №А/56, А/35. 2017 он. “Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзах уулзалтыг зохион байгуулах журам”.
33. Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаал №А/39, 2017 он. “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам”
34. MNS 6040 : 2019 Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага.
35. Нийгмийн ажлын нийтлэг шаардлага MNS 6949:2021.
36. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/265 дугаар тушаал.
37. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны Б/135 дугаар тушаал.
38. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022.03.23-ны өдрийн 01/196 дугаар албан бичиг.
39. Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. 2020 оны 03 сарын 24 өдөр. Дугаар 278.

Сурах бичиг, нэг сэдэвт бүтээл, гарын авлага.

40. Т.Алтангэрэл. XVI XVIII зууны Монгол цаазын бичгүүд. УБ. 2003.
41. Н.Арвинтариа нар. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ. УБ., 2020 он.
42. Н.Арвинтариа нар. Хохирогчийг хамгаалах цогц тогтолцоо ба салбар дундын зохицуулалт-Мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага. УБ., 2019
43. Амарсайхан О. нар. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль, түүний хэрэгжилт. УБ., 2009.
44. Б. Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. УБ., 2004.
45. П.Батбаатар. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлын онол, практикийн асуудал. УБ., 2021.
46. П.Батбаатар. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлын онол, практикийн асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. -УБ., 2021.
47. А.Батхишиг нар. Хүүхдийг Ивээх Сан "Хүүхэд хамгааллын хамтарсан баг". УБ. 2016.
48. Д. Баярболд. Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээний бэлэн байдал- үнэлгээний тайлан. УБ., 2023.
49. Ж.Болдбаатар. Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997.
50. Г.Ганбаатар. Гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбоотой үйлдсэн гэмт хэргийг мөрдөх арга зүй. УБ., 2019.

51. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хамтарсан багийн хүлээсэн үүргийн хэрэгжилт (Мониторингийн тайлан). Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ. УБ., 2021.
52. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн криминологи. Судалгааны тайлан /2018-2020/. УБ., 2021.
53. Д.Зүмбэрэлхам “Криминологийн онол” УБ., 2022.
54. Монгол Улсын Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал. Судалгааны тайлан. УБ. 2021.
55. Т.Намжил нар. Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт. Судалгааны тайлан. УБ. 2019.
56. Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. УБ., 2005.
57. Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдлын зарим асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2013.
58. Ч.Нямсүрэн, Г.Эрдэнэбат нар. Хохирлын үндэсний тогтолцоо - тодорхой төрлийн гэмт хэргийн хохирол, хор уршгийн нөхөн төлүүлэлт. Цуврал судалгаа №2. УБ. 2020.
59. Номин-Эрдэнэ, Ш. Гэмт хэрэг илрүүлэхэд ппрофайлинг ашиглах онол, арга зүй. Шинжлэн магадлахуйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2023 он.
60. Д.Нямбат “Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас хүүхэд хохирсон эсэх судалгаа 2020-2022.03 сар” УБ., 2022.
61. НҮБ-ын Хүн амын сан. Жендэрт суурилсан хүчирхийллийн тархалтын судалгаа. УБ., 2017.
62. НҮБ-ын Хүн амын сан, Жендэрийн Үндэсний Хороо, АХБ.2021. Монгол Улсад КОВИД-19 цар тахлын охид эмэгтэйчүүдийн нийгэм эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн судалгаа.
63. Нэгдсэн үндэсний байгууллага, “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” мэдээллийн хуудас, 2011 он.
64. З.Ундрах нар. ХЭҮТ-Кейс менежмент. Гарын авлага. УБ., 2023.
65. Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ). 2020 оны хүн ам, орон сууцын тооллогын мэдээ. 2020.
66. Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ), Дэлхийн Банкны хамтарсан “Ядуурлын дүр төрх” тайлан. УБ. 2020.
67. Үндэсний Статистикийн Хороо Согтууруулах ундааны хэрэглээ, үйлдвэрлэлийн өнөөгийн байдал. УБ. 2019.
68. Үндэсний статистикийн хороо. Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа. 2017.
69. Х.Оюунцэцэг. Гадаад орнууд дах гэр бүлийн хүчирхийлэл, түүний эрх зүйн зохицуулалтын байдал /харьцуулсан шинжилгээ/ /Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга зам/, УБ., 2003.
70. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага IDLO гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэх. УБ 2021 он.
71. Отгонтуяа О. Гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт. Нэг сэдэвт бүтээл. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Монгол Улс., 2022.
72. ОУХЭЗБ (IDLO). Мониторингийн тайлан: Монгол улс дахь гэр бүлийн хүчирхийллийн хэргийн шүүх хуралдааны ажиглалт 2020. УБ. 2021.
73. Өлзийсайхан Б. Хууль тогтоомжийн судалгаа. УБ., 2000.

74. Б.Содовсүрэн. Хувьсгалын өмнөх монголын төр ба хууль цааз /1911-1920/. УБ., 1989.
75. Стамбул. 2011. Гэр бүл дэх хүчирхийлэл ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай.
76. “Төрийн мэдээлэл” эмхтгэл, Тусгай дугаар, Монгол Улсын олон улсын гэрээ, I боть.
77. Хүүхдийг ивээх сангийн 2022 оны үйл ажиллагааны тайлан//УБ.
78. Д.Цэвээндорж. Монгол Улсын түүх. Тэргүүн дэвтэр. УБ., 2004.
79. Б.Энхболд. Хотжилт ба гэмт явдал.УБ.,2011.

Гадаад хэл дээрх бүтээл.

80. Алексеев А.И., Журавлев М.П., Миньковский Г.М. Проблемы уголовно-правовой и процессуальной защиты жертв преступлений // Актуальные проблемы управления и правового регулирования деятельности органов внутренних дел. – М.: Академия МВД России, 1994.
81. А.С. Архипова. Международный опыт противодействия семейному насилию. г. Ростов-на-Дону. Юридические науки - (2018)
82. Вицин С.Е. Методологические и информационные предпосылки исследования преступности в городах // Предупреждение преступности и обеспечение безопасности в городах. Материалы международной научно-практической конференции. М., 2009.
83. Гришин А.Н. Уличная преступность и ее профилактика службой милиции общественной безопасности в условиях крупного города. Автореф. дис. ... канд. юрид. наук. СПб., 2012.
84. Гильманов Сергей Амирович, «Профилактика жестокого обращения с несовершеннолетними» -М. 2019.
85. Гэр Бүлийн Хүчирхийллээс Урьдчилан Сэргийлэх, Үр Дүнтэй Тэмцэх Олон Агентлагийн Үр Дүнтэй Хамтын Ажиллагаа, 2015. Роза Логар, Бранислава Марванова Варгова.
86. Доклад Всемирной неправительственной организации ЕСПАТ «Насилие над детьми в киберпространстве. 2006» // Криминальное насилие против женщин и детей: международные стандарты противодействия: Сб. документов / Сост. В.С. Овчинский. М., 2008.
87. Доклад Всемирной неправительственной организации ЕСПАТ «Насилие над детьми в киберпространстве. 2006» // Криминальное насилие против женщин и детей: международные стандарты противодействия: Сб. документов / Сост. В.С. Овчинский. М., 2008.
88. Дети и насилие. Материалы международного семинара "Права ребенка: проблемы насилия над детьми". - МН.: МТС-Пресс, 2000.
89. Ениколопов, С.Н. Современные проблемы психологии семейного насилия // Домашнее насилие в отношении женщин: Масштабы, характер, представления общества. М.: МАКС–Пресс, 2003.
90. Елизаров, А.Н. Социально-психологическая помощь семье, страдающей от насилия // Психология зрелости и старения. Ежеквартальный научно-практический журнал. 2006. № 4 (36).
91. Забрянский Г.И. Городская и сельская виктимизация: сходство и различия // Виктимологические проблемы борьбы с преступностью. Иркутск, 2008.

92. С.М.Иншаков. Зарубежная криминология. М., 1997.
93. Х.Ю.Кернер. Криминология. Словарь- справочник., М.,1998.
94. Краткий психологический словарь/Под ред. А.В. Петровского, М.Г. Ярошевского. - М.: Политиздат, 1985.
95. Коновалов. В.П. Изучение потерпевших с целью совершенствования профилактики правонарушений. М.: ВНИИ МВД СССР. 1982.
96. Конвенция Совета Европы от 11 мая 2011 года по предотвращению и борьбе с насилием в отношении женщин и насилием в семье // Официальный сайт Совета Европы //
97. Малкина-Пых, И.Г. Психология поведения жертвы: справочник практического психолога. М.: ЭКСМО, 2006.
98. Москаленко, В.Д. Жены больных алкоголизмом. Вопросы психологии. 1991. № Норбер Рулан. Юридическая антропология. М., 1999. С 154.
99. Маханько А. Предупреждение насилия и пренебрежения детьми: исследования и эффективные решения, базирующиеся на междисциплинарном и межсекторном подходе // Социальная работа. - 2008.-№4.
100. Модельное законодательство о насилии в семье. Рекомендации ООН // Вестник «Новые возможности для женщин». М.: ИЦ НЖФ, 1997. № 10.
101. Межамериканская конвенция по предотвращению, наказанию и искоренению насилия в отношении женщин 1994 г. (Convention of Belem do Para); Протокол к Африканской хартии прав человека и народов о правах женщин в Африке 2003 г. – Протокол Мапуту (The Protocol to the African Charter on Human and Peoples' Rights on the Rights of Women in Africa – Maputo Protocol).
102. Д.В. Ривман. Криминальная виктимология . СПб., 2002.
103. Рима Ф. Основные формы страха / Пер. с нем. Э.Л. Гушанского. – М.: Алтейа, 1999.
104. Панок, В.Г. Обиженные дети. Анализ проблемы. К., 1997.
105. Подройкина И.А. Система уголовных наказаний в истории России и в современном зарубежном законодательстве: монография. – М.: Юстицинформ, 2017.
106. Подройкина И.А. Зарубежный опыт и преемственность при построении системы наказаний в России // Бизнес. Образование. Право. Вестник Волгоградского института бизнеса. 2012. № 4 (21).
107. Смит З.У. Внуки алкоголиков / Пер. с англ. М.: Просвещение, 1991.
108. Сальников, М.В. Право и закон в правовом государстве. //Правоохранительная деятельность и правовое государство. -СПб., 1995.
109. Франк.Л. Потерпевшие от преступления и советской виктимологии. Душанбе., 1977.
110. Фрейд, А. Психология «Я» и защитные механизмы. М.: Педагогика-Пресс, 1993.
111. Харламов В.С. Отечественный и зарубежный опыт противодействия криминальному насилию в семье. СПб, 2014.
112. Adler, Muellet, Laufer. Criminology. Second edition. New York.,1995.
113. M.Brewster. Domestic Violence Theories. Research and Practical Implication. NY., 2002.

114. Grabosky P.N. Fear of Crime and Fear Reduction Strategies // Current Issues in Criminal Justice. – 1995. – № 7 (1).
115. Finkelhor D, Dzuiba-Leatherman J. Victimization of children. *Am Psychologist*. 1994;49:173-183
116. Piffaut Gina. Concrete achievements toward the implementation of the fundamental principles of justice for victims // *Changing Victim Policy: The United Nations Victims Declaration and Recent Development in Europe*. HEUNI publication N 16. Helsinki, 1989.
117. Council of Europe Convention on the Protection of Children against Sexual Exploitation and Sexual Abuse
118. Irako, Keiko, and Koji Ono. "The Prevention of Spousal Violence and the Protection of Victims in Japan." *Int'l Surv. Fam. L.* (2005): 371.
https://www.gender.go.jp/policy/no_violence/e-vaw/law/pdf/sv.pdf Last visited 2021.10.14
119. National Statistics Office, UNFPA, *Breaking the silence for equality, 2017 National Study on Gender-based violence in Mongolia*, 2018
120. Act on the Prevention of Domestic Violence, etc of Victims Thereof
121. UN Women, UNFPA, WHO etc., *Essential Services Package for Women and Girls Subject to Violence, Core Elements and Quality Guidelines: Module 2: Health Services*, 2016.
122. Bross D. *World perspectives on child abuse: the fourth international resource book*. Denver, 2000; Report of the Consultation on Child Abuse Prevention, 29-31 March 1999, WHO, Geneva. Geneva, 1999(document WHO/HSC/PVI/99.1).
123. What is elder abuse? *Action on Elder Abuse Bulletin*, 1995.
124. World Health Organization, *Responding to intimate partner violence and sexual violence against women, WHO clinical and policy guidelines*, Geneva, 2013
125. Refugees, United Nations High Commissioner for. "Refworld | Korea, Republic of: Domestic violence, including legislation, availability of state protection and support services for victims". Refworld. Retrieved 2019-06-07
126. World Health Organization, *Strengthening health systems to respond to women subjected to intimate partner violence or sexual violence: a manual for health managers*, Geneva, 2017
127. Lars Nylen & Gun Heimer, *Sweden's response to domestic violence*, Swedish Institute (1 April 2000).
128. Joyce Plotnikoff & Richard Woolfson, *Policing Domestic Violence: Effective Organisational Structures* (1998).
129. Nemoto, Keiko; Rodriguez, Rachel; Valhmu, Lucy Mkandawire (May 2006). "Exploring the Health Care Needs of Women in Abusive Relationships in Japan". *Health Care for Women International*. 27 (4): 290– 306. doi:10.1080/07399330500511774. PMID 16595363. S2CID 275052.
130. Cabinet Office, Gender Equality Bureau. "Violence against Women"
131. Penal code of Japan, 1907 <http://www.gender.go.jp>
132. https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=28627&lang=ENG
133. Act on the Prevention of Domestic Violence, etc of Victims Thereof <https://evaw-global-database.unwomen.org/>

Цахим эх сурвалж

134. <https://legalinfo.mn> – Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
135. <https://montsame.mn> - “Монцаме” албан ёсны веб сайт
136. <https://www.1212.mn/mn/> - Үндэсний статистикийн газрын албан ёсны веб сайт
137. <https://www.unicef.org> – ДЭМБ-ын албан ёсны веб сайт
138. <https://judcouncil.mn> - Шүүхийн ерөнхий зөвлөлийн веб сайт
139. <https://redcross.mn/> - Монголын улаан загалмайн нийгэмлэгийн сайт
140. <https://ikon.mn/> - Мэдээллийн сайт
141. <http://www.asuudal.mn> - Мэдээллийн сайт
142. <https://eguur.mn> - Мэдээллийн сайт
143. <https://eguur.mn> - Мэдээллийн сайт
144. <http://vip.chuhal.mn> - Мэдээллийн сайт
145. <http://tovch.mn> - Мэдээллийн сайт
146. <http://tovch.mn> - Мэдээллийн сайт
147. <http://TV5Mongolia.mn> - Видео мэдээ

Бусад эх сурвалж:

148. Монгол Улсын шүүхийн 2016 оны тайлан.
149. Монгол Улсын шүүхийн 2018 оны тайлан.
150. Монгол Улсын шүүхийн 2020 оны тайлан.
151. Монгол Улсын шүүхийн 2021 оны тайлан.
152. Монгол Улсын шүүхийн 2022 оны тайлан.
153. ЦЕГ-ын статистик судалгаа 2017.
154. ЦЕГ-ын статистик судалгаа 2018.
155. ЦЕГ-ын статистик судалгаа 2019.
156. ЦЕГ-ын статистик судалгаа 2020.
157. ЦЕГ-ын статистик судалгаа 2021.
158. ЦЕГ-ын статистик судалгаа 2022.

ЦАХИМ ОРЧИНД ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ, ТҮҮНИЙ ШАЛТГААН НӨХЦӨЛИЙН ТАЛААР ГАРСАН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ТҮҮВРИЙН ЖАГСААЛТ

№	Мэдээллийн эх сурвалж	Он сар, өдөр	Хүүхэд хүчирхийлэл	Гэр бүл хүчирхийлэл	Холбогдогч		Хохирогч		Нийт хандалт	Нийт сэтгэгдэл	Хохирогчийн талаар эерэг хандалттай сэтгэгдэл	Хохирогчийн талаар сөрөг хандалттай сэтгэгдэл
					Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй				
2017-2019 он												
1	Time.mn	5/23/2017		СХД-ийн 26-р хороонд нэг гэр бүлийн таван хүн амиа алдсан харамсалтай хэрэг гарсан. Тодруулбал, тус хороонд суух 39 настай Х гэгч удаа дараа гэр бүлээ хүчирхийлдэг байсан ба өөрийн 4, 6, 11 настай хүүхдээ, эхнэрийнхээ хамт хөнөөгөөд, өөрийн амиа егүүтгэжээ.			3	2	6800	880	97%	3%
2	Eagle news	11/27/2017	Цэцэрлэгийн багш хүүхдэд үл мэдэгдэх тариа тарьж, хүчирхийлэл үйлддэг байсныг тогтоолоо			1	1	45300	2580	91%	9%	

3	Eagle news	12/22/2017	Эцэг нь 5 настай дагавар охиноо хүчиндсэн хэрэг гарчээ.		1			1	5400	650	90.5%	9.5%
4	Радио 88.8	12/18/2017	Хойд эцэг нь 3 настай хүүгээ хүчирхийлж зодсон хэрэг ахин гарлаа.		1		1		2800	98	96%	4%
5	SBN TV	3/22/2018	Замын-Үүд суманд 1 ой 8 сартай хүүхдийг хүчирхийлсэн онц ноцтой хэрэг гарчээ.		1			1	970	82	94%	6%
6	chuhai.mn	4/9/2018	Хойд эцэг нь есөн настай охиноо хүчирхийлсэн хэрэг дахин гарчээ		1			1	2800	77	95.5%	4.5%
7	News.mn	9/23/2018	Баянзүрх дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр "Очир" төвийн зочид буудлын өрөөнд 13 настай охин амь насаа алдсан хэрэг өнгөрсөн сарын 23-нд гарсан.		2			1	12000	1500	86%	14%
8	news.zindaa.mn	10/5/2018	Хойд аав нь дагавар охиноо хүчирхийлж, жирэмсэн болгожээ		1			1	3600	260	91%	9%
9	TV-9	10/29/2018	13 настай охиноо хүчирхийлж жирэмсэн болгожээ.		1			1	17000	453	100%	0%

10	TV-5	10/30/2018	Хойд аавдаа зодуулсан 4 настай хүүхдийн биеийн байдал хүнд байна.		1		1		424	122	100%	0%
11	Bolod.mn	11/5/2018	Нөхрөө нас барснаас хойш хадмууд нь эхнэрийг нь гэрээсээ хөөжээ.			1		1	3100	2400	92%	8%
12	TV-5	4/16/2019	3 сартай жирэмсэн эхнэрээ зодож, хоолойг нь боож унагаад 1 настай охиноо гудамжинд орхин зугтсан этгээдийг хайж байна.		1			2	275	109	100%	0%
13	Tovch.mn	5/15/2019	7 настай охины гарын 4 хурууг Нагац ах нь тас цавчиж хүчирхийлэл үйлдсэн этгээдийг шалгаж байна.		1			1	3068	3155	100%	0%
14	Zindaa.mn	9/24/2019	Орон нутгийн прокурор нөхөр О нь эхнэрээ 10 жилийн турш байнгын хүчирхийлэлд өртөж, 9 удаагийн үр хөндөлт хийлгэсэн байна. Нөхөр нэр нөлөө бүхий этгээд учир цагдаад хэлэхгүй хав дардаг байж.		1			1	6870	645	100%	0%
15	Tovch.mn	10/10/2019	Цэцэрлэгийн багш 2 настай хүүхдийн сандалтай нь хүлж хүчирхийлэл үйлдсэн байна.			1		1	296	123	100%	0%
16	ITV	10/25/2019	Нөхөр М нь эхнэрээ удаа дараа буюу 5 жилийн хугацаанд хүчирхийлж байсан нь тогтоогдлоо.		1			1	14000	690	86.5%	13.5%

17	Aarhal.com	11/8/2019	Дархан-Уул аймагт 5 настай эрэгтэй хүүхдийг төрсөн аав нь хүчирхийлсэн хэрэг гарч олныг цочроож байна.		1		1		2600	680	91%	9%
18	Eagle news	11/11/2019		Бага насны хүүхдийн гэрт нь ганцаараа үлдээснээс болж 3 настай хүүхэд тагтнаас дүүжлэгдсэн байсан.	1	1	1		1200	130	63%	37%
19	NTV	12/6/2019		3 хүүхдээ орхиж явсан гэх ээж гэр бүлийн хүчирхийллийн улмаас аргагүй байдалд орсон	1			1	2800	406	73%	27%
20	Fact.mn	12/14/2019	Монголын хөл бөмбөгийн холбооны менежер Б.Учралсайхан охидыг удаа дараа хүчирхийлжээ.		1			1	6200	248	83%	17%
21	ETV	12/17/2019	4 настай хүүг орондоо шээсэн гэж хойд аав нь зодож хүчирхийлжээ.		1		1		58000	334	56%	44%
22	TV-5	5/29/2020		Гэр бүлийн хүчирхийллээс болж гурван сартай охиноо тэврээд 6 давхраас үсэрсэн хэрэг ахин гарлаа.	1		1	1	9205	2065	100%	0%
23	TV8 Mongolia	8/10/2020		Нөхөр нь эхнэрээ хардаж автомашинаасаа хөл нүцгэн хөөж буулгажээ	1			1	18600	151	61%	39%

24	TV8 Mongolia	8/10/2020		Хүүхдийн тэтгэмж шаардсан эхнэрээ удаа дараа зодож, гэмтээжээ	1			1	90300	1400	63%	37%
25	Eguur.mn	9/7/2020	12 настай охиныг фейсбүүкээр танилцсан 15 настай хүү хүчирхийлжээ.		1			1	6900	139	63.5%	36.5%
26	Zarig.mn	9/20/2020	БЗД-ийн нутаг дэвсгэрт 9 настай охин бусдын гарт хүчирхийлэлд үйлдэж амь насаа алдсан		4			1	9750	2500	100%	0%
27	Bolod.mn	10/23/2020	Дагавар хүүхдээ удаа дараа хүч хэрэглэж хөнөөсөн Б.Хүлгэнийг бүх насаар нь хорих ял оноолоо		1		1		7927	743	100%	0%
28	TB-24	10/26/2020	НЕБ-ын 97 дугаар сургуульд багш нь 5 дугаар ангийн сурагчаа хүчирхийлсэн хэрэг гарчээ.		1			1	5400	100	90%	10%
29	Zarig.mn	10/28/2020	Дөрвөн настай охины толгойг эцэг нь аягаар зодож хүчирхийлсэн хэрэг гарлаа. Охины эцэг, эх нь архины хамраалтай байсан байна.		1			1	1200	868	95%	5%

30	Todmedee.mn	10/29/2020	Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүг хүчирхийлжээ.		1			1	680	126	100%	0%
31	SBN TV	10/29/2020	Баянхонгор аймагт 10 настай охиныг хүчирхийлсэн хэрэг гарлаа		1			1	5000	40	93%	7%
32	Moogle.mn	10/29/2020	10 настай хүүг хойд эцэг нь хүчирхийлсэн хэрэг гарсан байна.		1		1		1450	340	92.5%	7.5%
33	TV-5	11/5/2020	4 настай охин гэртээ өлсөж сульдсан байдалтай олджээ				1		170000	5600	84%	16%
34	Zindaa.mn	11/21/2020		Гэр бүлийн хүчирхийлэлд 8 жил өртсөн эмэгтэй нөхрийнхөө гарт амиа алджээ.	1			1	6800	480	90%	10%
35	Сэтгүүлч Н.Урантогтох	11/26/2020	1 нас 5 сартай хүүхдийг хойд эцэг нь зодож, хөнөөжээ		1			1	3000	1600	70%	30%
36	TV8 Mongolii	#####		гэртээ согтуу ирж, хүүхдүүдээ айлган эхнэрээ зоджээ	1			1	42900	345	96%	4%

37	zindaа	12/30/2020		Х.Аймая насанд хүрээгүй хүнд бэлгийн дарамт үзүүлж хар тамхи хэргэлдэг байсан.	1			1	37000	151	60%	40%
38	TV6	2/3/2021	Асрамжийн газрын ах нар нь 11 настай хүүг хүчирхийлжээ.		2		1		7100	460	90%	10%
39	Zarig.mn	2/3/2021	Багш нар нийлж сурагчдадаа хүчирхийлсэн хэргийг цагдаагийн байгууллага шалгаж байна.		2		2		73500	13500	85%	15%
40	Зөв.МН	5/1/2021		Мөнхийн реп хамтлагийн дуучин Лхагваа 9 сартай жирэмсэн эхнэрээ зодож хүчирхийлсэн хэрэг гарсан.	1			1	7800	274	95%	5%
41	gogo.mn	5/1/2021	Хойд эцэг нь 7 сартай хүүхдийн хөлийг хугартал цохиж хүнд гэмтэл учруулжээ		1		1		2377	720	100%	0%
42	Zarig.mn	5/19/2021		Олон жил гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэй Элизабет хотхонд өндрөөс унаж нас барлаа	1			1	4800	1050	60%	40%
43	gogo.mn	6/9/2021	2 настай охиныг аав нь хүчирхийлсэн талаар ээж нь мэдээлэл өгөв.		1			1	53200	11506	90%	10%
44	NTV	10/22/2021		Архидан согтуурч явахдаа зээ охин болон охиноо алджээ		1		1	10600	75	91%	9%

45	Livetv.mn	10/26/2021	Төрсөн эцэг эх нь хоёр настай охиноо хүчирхийлсэн хэрэг гарлаа.		1	1		1	40800	941	100%	0%
46	Eguur.mn	10/27/2021		30 жил гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэй охин, зээгээ хамгаалахын тулд нөхрөө хөнөөжээ.			1	1	24000	2100	5%	95%
47	TV-5	12/2/2021	БНСУлсад 6 цагийн турш зодуулж хүчирхийлэл үйлдүүлсэн охины хэрэг дээр тайлбар авч байна.		1			1	1361	441	100%	0%
48	Eagle news	12/4/2021	Архангай аймгийн цэцэрлэгийн багш 4 настай хүүхдийг зодож хүчирхийлсэн хэрэг гарлаа.			1	1		56000	651	95%	5%
49	TV7 Mongolia	12/7/2021		Хардалтаас болж 2 хүүхдээ шатааж өөрөө амиа егүүтгэсэн гэх	1		1	1	983000	3200	100%	0%
50	Geteg.mn	####	Даалгавраа хийгээгүйгээс болж багшдаа зодуулжээ			1		1	42000	69	90%	10%
51	gogo.mn	4/7/2022	Дархан Уул аймгийн 12 дугаар сургуулийн орос хэлний багш хүүхдийг сандал унагаасан гэсэн шалтгаанаар тамлаж зоджээ.		1		1		1414	310	100%	0%

52	ETV	7/23/2022		Иргэн А өвлийн хүйтэнд 1 нас хүрээгүй чармай шалдан хүүхдээ дагуулан, архи дан согтуурч яваад эрүүлжүүлэгдлээ		1		1	293000	1190	86%	14%
53	Eagle news	8/10/2022		10 настай хүүгээ хотоос зайдуга вакум сургалтад явуулжээ. Хүүхдээ зодуулж хүчирхийлүүлсэн талаар ирэхэд нь мэдсэн байна.		1	1		120000	23000	80%	20%
56	NTV	8/15/2022		1 ой 6 сар охины хурууг тайруулах гэж байжээ		1		1	100000	1000	86%	14%
54	Tsahiur.mn	8/24/2022		4 хүүхдээ орхиод сураггүй болсон		1	2	2	315000	451	70%	30%
55	NTV	9/30/2022		Олон нийтийн газар бага насны хүүхдээ зоджээ		1		1	36000	1200	100%	0%
57	NTV	11/3/2022		Зургийн тайлбарт ээж нь архи дан согтуурч хүүхдүүдээ орхиж явсан гэж бичжээ.		1		1	123000	63	75%	25%
58	ETV	11/8/2022		2 настай хүүхдээ дагуулан архи ууж хөлийн хурууг нь хөлдөөсөн ээж		1	1		587000	399	100%	0%
59	Moogje.mn	12/8/2022		13 настай охиныг 4 Солонгос хүн хүчирхийлсэн		4		1	280000	16000	100%	0%

60	Naгaнтсaтсaлт Бaяaрkhуу /Ундрaм гишүүн/	12/7/2022		УИХ-ийн гишүүн Ундрaм эр нөхрөө хүчирхийлдэг тaлaар тa бүхэнд үзүүлбe.		1	1		69200	1260	60%	40%
61	Zarig,mn	12/11/2022		УИХ-ийн гишүүн Ч.Ундрaм хүүхдээ сaндал дээрээс түлхэж, -Хүнээр тэжээлгэж байж зайл чи хэмээн зодож хүчирхийлсэн хэрэг гарлаа.		1	1		6800	1400	90%	10%
62	Tovch.mn	1/25/2022		Төв аймагт бусдад зодуулж гудамд хаягдсан 1 настай хүүхдийн тaлaар цагдаагийн байгууллагаас тодруулж байна		1		1	3316	900	100%	0%

63	Zogji.mn	1/19/2023		Прокуророос Б-г “Хүнийг алах” гэмт хэргийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, онц харгис хэрцгийгээр, хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй болохыг мэдсээр байж гэх хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн гэж яллах дүгнэлт үйлдэн хэргийг шүүхэд ирүүлжээ	1			1	1401	399	100%	0%
64	NTV	3/3/2023	Төрсөн эцэг нь хоёр настай охиноо хүчирхийлсэн хэрэг гарсан. Уг хэргийг хууль, шүүхийн байгууллага тоохгүй, шийдэгдэхгүй байгаа учир хэвлэл мэдээллийн байгууллага, ард түмэндээ хандаж байгааг хохирогч талынхан мэдээллээ.		1			1	8400	970	86	14

65	ZOGII.MN	3/12/2023	<p>Нялх хүүхдэд эр бяраа гаргасан этгээд хоёр хонолгүй баригдсан бол хэргийг нуун дарагдуулсан ээж Л-ийг нь таслан сэргийлжээ.</p> <p>Амьтан хүртэл үр зулзагаа хамгаалж амь, биеэ зориулдаг байтал төрсөн үрээ биш нууц амрагаа хаацайлсан байна. 3-р сарын 6-нд зодуулж, хүчирхийлүүлсэн хүүг эмнэлэгт яаралтай үзүүлэхийн оронд бүтэн 2 хоног нуун дарагдуулж, бөө дээр очиж цаг алдуулжээ.</p>		1	1		8400	1140	100	
66	Mass.mn	4/7/2023	Төрсөн охиноо 3 жилийн турш хүчиндсэн этгээдэд 15 жилийн хорих ял өглөө.		1		1	9336	650	95%	5%
67	Зангараг.mn	4/20/2023	Нэткапитал банк бус санхүүгийн байгууллагын захирал н. Сүндий эхнэрээ хүчирхийлж хэвтэрт ортол нь зодсон байна.		1		1	36000	1200	95%	5%
68	Zarig.mn	5/23/2023	У.Цогтбаяр, Кёкүшюүзан Д.Батбаяр нар гэр бүлийнхэндээ танхайрч удаа дараа хүчирхийлсэн байна.		1		1	3800	750	80%	20%

69	Зөв.МН	6/1/2023	Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр 5 настай хүүг хойд эцэг нь зодож хүнд гэмтээсэн хэрэг гарсан байна.		1		1		25000	2000	95%	5%
70	Mass.mn	6/6/2023		Иргэн Ган-Очир эхнэрээ удаа дараа зодож хүчирхийлдэг байжээ.	1		1		56400	6900	65%	35%
71	ltoim.mn	6/20/2023	13 настай хүүг том лам нар бус үеийн хүүхдүүд нь хүчирхийлсэн хэрэг гарсан байна.		1		1		15400	1020	95%	5%
72	C1	6/22/2023	Гандантэгчинлэн хийдийн Жүд дацанд шавилж байсан 6 настай хүү хамт сурдаг ах нартаа хүчирхийлүүлсэн байж болзошгүй тухай хүүгийн аав манай редакцад хандлаа.		1		1		1802	445	90%	10%
73	zarig.mn	8/12/2023		Лифтэнд нөхрөө зодсон эмэгтэйг шалгаж байна		1	1		43700	171	80%	20%
74	Eagle news	9/5/2023	26 дугаар цэцэрлэгийн туслах багш 2 настай хүүхдийг зодож хүчирхийлсэн хэрэг гарсан байна.			1		1	49100	7300	90%	10%

75	TV-5	10/4/2023		Иргэн Д.Мөнхбаяр 26 жилийн турш нөхөртөө зодуулж гэр бүлийн хүчирхийлэл дунд насыг барж байна.	1			1	7796	2062	80%	20%
76	TV-5	10/6/2023	Эрэн хайж байсан 12 настай охиныг 80 цагийн дараа амиа алдсан байдалтайгаар олджээ.		1		1	12524	730	100%	0%	
77	Urug.mn	10/7/2023		Г.Эрдэнэтуяа: Тогоо шиг том гэдэстэй би гараа хугартал зодуулчхаад төрсөн ч хүүхдээ аварч чадаагүй	1		1	19107	864	90%	10%	
78	TV-5	10/9/2023	Сургуулийн багш нар хүүхдүүдийг бие засуулахгүй байх нь хүчирхийллийн нэг хэлбэр юм.		1	1	1	11629	764	100%	0%	
79	TV-5	10/10/2023	Наймхан настай охиныг минь хүчиндэж хөнөөсөн этгээд шүүхийн танхимд юу ч болоогүй юм шиг зогсож байсан.		1		1	13381	1178	100%	0%	
80	TV-9	10/12/2023	Караокед ажилладаг 2 охиныг хүчирхийлсэн хэрэг гарлаа.		1		2	8780	881	100%	0	

65 26 28 65 4184839 143854